

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

---



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

---

2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

---

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

---

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН  
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 10
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 – 156
1. <i>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах</i>	12 – 13
2. <i>Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	13 – 59
3. <i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	59 – 70
4. <i>Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	70 – 72
5. <i>БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	72 – 95
6. <i>Улсын Их Хурлын асуулгын цаг.</i>	95 – 153
7. <i>Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.</i>	153 – 156

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
04 дүгээр сарын 24-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн хүрэлцэн ирж, 59.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.*

*Томилолттой: Н.Батсүмбэрэл, Б.Батцэцэг, Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Б.Хэрлэн, М.Энхцэцэг;*

*Чөлөөтэй: П.Батчимэг, Ж.Баясгалан, Т.Мөнхсайхан, Ч.Номин;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Болормаа, С.Замира, П.Мөнхтулга, М.Сарнай, Б.Чойжилсүрэн;*

*Тасалсан: Д.Амарбаясгалан, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Ц.Туваан;*

*Хоцорсон: Н.Алтаншагай–31 минут, С.Амарсайхан–1 цаг 04 минут, Ч.Анар–04 минут, Х.Баттулга–08 минут, Э.Болормаа–01 минут, Х.Булгантуяа–04 минут, Ж.Галбадрах–1 цаг 04 минут, Д.Ганбат–18 минут, Л.Гантөмөр–12 минут, Б.Дэлгэрсайхан–1 цаг 39 минут, Б.Жаргалан–01 минут, Д.Жаргалсайхан–1 цаг 17 минут, Ж.Золжаргал–1 цаг 22 минут, Ц.Мөнхбат–3 цаг 12 минут, Ц.Мөнхтуяа–23 минут, Н.Номтойбаяр–01 минут, Л.Оюун-Эрдэнэ–5 цаг 24 минут, Б.Пунсалмаа–03 минут, О.Саранчулуун–06 минут, Б.Түвшин–41 минут, Х.Тэмүүжин–01 минут, Г.Тэмүүлэн–06 минут, А.Ундраа–13 минут, Ч.Ундрэм–18 минут, Н.Учрал–4 цаг 01 минут, Г.Уянгахишиг–05 минут, Д.Цогтбаатар–1 цаг 21 минут, Ж.Чинбүрэн–08 минут, Ж.Энхбаяр–23 минут, С.Эрдэнэбат–39 минут, Р.Эрдэнэбүрэн–55 минут.*

***Нэг.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т “нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 21  
Бүгд: 87

Улсын Их Хурлын нийт гишүүний олонх буюу 75.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 77.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Уг асуудлыг 10 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл** /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, **эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ**/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын дарга И.Лувсанцэрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Монголбанкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал П.Мөнхбаяр, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чулуунбат, “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга У.Чинзориг, Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, “Сэлбэ 20 минут корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал У.Баатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын

хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв. /10:10/

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Л.Мөнхбаясгалан, Да.Цогтбаатар, Н.Алтаншагай, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Д.Рэгдэл, Р.Батболд, Б.Жаргалан, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн сайд З.Мэндсайхан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Н.Наранбаатар, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чулуунбат, “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал ажлын 4 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /11:50/

***Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, М.Ганхүлэг, О.Номинчимэг, Х.Тэмүүжин, О.Саранчулуун нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 16.00 цаг хүртэл хойшлуулав. /12:16/*

***Дөрөв.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн 2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Оюунцэцэг, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Туул, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга Б.Бат-Эрдэнэ, Шинжлэх ухааны академийн Дэд ерөнхийлөгч Б.Авид нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар танилцуулав.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй, Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Д.Болд-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Да.Цогтбаатар, М.Ганхүлэг, О.Номинчимэг, П.Наранбаяр, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ, “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач Э.Сундуй нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 16.00 цаг хүртэл хойшлуулав.*

*Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 12 минут үргэлжилж, 13 цаг 12 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.*

### **Зургаа.Улсын Их Хурлын асуулгын цаг**

Улсын Их Хурлын асуулгын цагтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1-д “Ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна.”, 112.5-д “Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75 минутаас, олонхын бүлэгт 15 минутаас, цөөнхийн гишүүдэд 30 минутаас хэтрэхгүй байна.” гэж тус тус заасныг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал нарыг чуулганы танхимын голд тусгайлан бэлдсэн индэрт урив.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Г.Очирбат, С.Эрдэнэболд, Ө.Шижир, Л.Мөнхбаясгалан, Ш.Бямбасүрэн, Д.Батбаяр, Ц.Баатархүү, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь олонхын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдээс Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Б.Мөнхсоёл, П.Ганзориг, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын асуулгын цагт Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлгийн гишүүд болон Улсын Их Хурлын цөөнхийн гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авч дууслаа.

*Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /16:00/

***Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.***

**С.Бямбацогт:** Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 48  
Бүгд: 106  
54.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

***БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.***

**С.Бямбацогт:** Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58  
Татгалзсан: 48

---

Бүгд: 106  
54.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 55.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**С.Бямбацогт:** Хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 57  
Бүгд: 106

46.2 хувийн саналаар дэмжигдээгүй тул хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов. /16:18/

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 12<sup>г</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Э.Одбаяр нарын урилгаар Завхан аймгийн Тэлмэн сумын ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 37 дугаар сургуулийн 12<sup>в</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын урилгаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн 12<sup>а</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн урилгаар Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын авто тээврийн цехийн ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын албан хаагчид, Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн эрх зүйн ангийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Улиастай

сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын урилгаар Монгол, Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн 12<sup>Г</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын урилгаар Говь-Алтай аймгийн хувиараа бизнес эрхлэгч оёдолчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайханы урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ Монгол” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 8<sup>В</sup> ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийн урилгаар Төв аймгийн Монгол Ардын намын хорооны дэргэдэх Социал-демократ Ахмадын холбооны гишүүд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 5 цаг 31 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 106 гишүүн ирж, 84.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 20 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим  
10 цаг 00 минут

### ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

---

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2026 оны 4 дүгээр сарын 24-ний чуулганы нэгдсэн хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 75 гишүүн буюу 59.5 хувийн ирцтэй байна.

2026 оны 4 дүгээр сарын 24-ний хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /минут дуусав/

Өнөөдөр гишүүдийн төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлье.

4 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Салдагийн Одонтуяа төрсөн байна.

Тэгээд С.Одонтуяа гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч Танд болон таны гэр бүлд нийт гишүүдийнхээ өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хамгийн эрт 09.00 цагт ирцэд орсон зарим гишүүдийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Ганбатын Очирбат, Оюунсайханы Алтангэрэл, Сүхбаатарын Эрдэнэболд, Доржзовдын Энхтуяа гишүүд өглөө яг цагтаа ирцдээ орсон байна. 09 цаг 02 минутад.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүний урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 33 дугаар сургуулийн 12-ын “ё” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэн хэдхэн хоногийн дараа амьдралынхаа хамгийн гэгээлэг нэгэн хуудсыг хааж, амьдралын их далайд хөл тавьж, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаж, мэргэжлээ эзэмшиж, Монгол Улсынхаа хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсан дэлхийн иргэн болохыг Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ өмнөөс Та бүхэндээ хүсэн ерөөе. /алга ташив/

---

Манай Ж.Ганбаатар гишүүн сайн бизнесмен болоорой гэж байна шүү. Жамбалын Ганбаатар гишүүн.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Дараах 7 асуудлыг хэлэлцэнэ.

- **Нэг.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.
- **Хоёр.**Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.
- **Гурав.**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.
- **Дөрөв.**Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.
- **Тав.**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар зургаа дахь асуудал Монгол Улсын Их Хурлын асуулгын цаг.

Долоо.Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

---

**Нэг.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,  
түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай  
хуулийн төслийг эцэслэн батлах**

---

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батална.

Гишүүд санал хураалттай. Танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

64 гишүүнээр хуулийн төслийг эцэслэн батална. Хуулийн төслийн эцэслэн батлах хувилбарыг Төрийн байгуулалтын байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. /алх цохив/

---

Санал хураалтад 63 гишүүн бэлэн болсон байна. Ирцдээ ороогүй, санал хураалтад бэлтгэж амжаагүй гишүүдийг санал хураалтдаа бэлдье. Өглөөний ирцэд 85 гишүүн байгаа.

Санал хураалтад 67 гишүүн бэлэн болсон байна. Бусад ирцдээ ороод орж ирж амжаагүй, санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүдийг санал хураалтдаа бэлтгэхийг хүсье.

Бүртгэлийн санал хураалт ирцийн санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууна уу. Санал хураалт явуулна шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн батлагдсанд тооцно.” гэж заасан байдаг.

64 гишүүнээр санал хураалт дэмжигдэж байж эцэслэн батлагдана. Санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг Х.Баасанжаргал гишүүнийг дэмжсэнд тооцъё. Бүртгэлд.

Хуулийн төслийг эцэслэн баталлаа. Улсын Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье.

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Хоёр.Гадаад зээллэгийн ашиглалт,  
үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл**  
/Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн  
2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг,  
үргэлжилнэ/

---

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025 оны 12 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ажлын нэг өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж үг хэлэх үү? Үг хэлэхгүй юм байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

**Д.Энхтүвшин:** Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

Гадаад зээллэгийн тухай хуулийн хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудал ажлын хэсэг дээр дэмжигдээгүй учраас гээд хассан. Өөрөөр хэлбэл хэлэлцүүлгийн явцад Сэлбэ дэд төвтэй холбоотой ямар ч хэлэлцүүлэг орж ирээгүй. Тэгээд ингээд үргэлжлээд явсан.

Сэлбэ дэд төвтэй холбоотой асуудлыг Байнгын хороон дээр асуусан. Уг нь өртөг зардалтай холбоотой хариулт өгье гэсэн мөртлөө одоо болтол өгөөгүй байна.

Тэгэхээр үүнийг дахиад асууя.

- Сэлбэ дэд төвийн яг барилгынх нь өртөг нь хэд байна?
- Дэд бүтцийг нь оруулбал хэд байна?
- Газар нь оруулбал хэд байна?

Тэгээд үүнтэй холбогдуулаад–

- дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дүн,
- газар чөлөөлөлттэй холбоотой мэдээллийг өгөөч.

Дээр нь нэмээд энэ төслөөс хэдий хэмжээний ашиг бий болж, газрыг дахин төлөвлөх болон гэр хорооллын хөгжлийн санд хэдээр нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа вэ?

Дараагийн нэг асуулт нь барилгатай холбоотой төслүүдийг Хятадын 1, 2 болон 3.1 дүгээр багцуудыг Хятадын компаниудад өгсөн байгаа.

Тэгээд Монголын 4 компанид энэ төслийг өгсөн юм билээ.

- “Морин сувд констракшн”,
- “Нутгийн буян”,
- “Монкон”,
- “Профешнл Строй” –

-гээд ийм 4 компани орон сууцтай холбоотой гэрээ хийгдсэн билээ.

Энэ 4 компани дээр нийслэлийн удирдлагуудтай холбоотой компани байгаа юу? Энэ дээр ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил үүссэн асуудал байгаа юу гэдэг ийм асуултууд байна. Тэгээд тодруулъя.

**С.Бямбацогт:** Ажлын хэсгээс хариулах уу? Та бүхэнд чуулганы танхимд дэг сахиулах, парламентад үнэн зөв мэдээлэл өгөх талаар хуулийг танилцуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцож байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн гишүүд гишүүдийн асуусан асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх ёстой. Худлаа мэдээлэл өгч болохгүй. Асуултад гүйцэд хариулах ёстой. Хэрэв асуулт хангалтгүй байна гэж үзэх юм бол Их Хурлын гишүүдэд бичгээр дутуу асуултыг гүйцээж хариулах үүрэгтэй шүү.

Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, худлаа мэдээлэл өгсөн, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээд төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хуулийн хариуцлага хүлээлгэдэг болохыг сануулъя.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ичинхорлоогийн Лувсанцэрэн Эрчим хүчний яамны Салбарын хяналтын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Санхүү, зах зээл, валютын газрын захирал, Түмэндалайн Даваадалай Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах Нийслэлийн Засаг

даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чулуундаваагийн Чулуунбат Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос боловсруулах газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Дашдаваагийн Алтанцэцэг “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Улаанхүүгийн Баатар “Сэлбэ 20 минут корпорац” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал, Уранбаатарын Чинзориг “Монголын газрын тос боловсрох үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гэрээ, эрх зүйн газрын дарга, Бямбын Мөнх-Эрдэнэ “Монголын газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Технологийн албаны дарга.

Ийм ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ иргэдийг төлөөлөх үүргээ нэр төртэй, хариуцлагатай хийж хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүний асуусан асуултад хэн хариулах вэ? Т.Даваадалай. Ажлын хэсэг. 4 дүгээр микрофон.

**Т.Даваадалай:** Эрхэм гишүүдэд энэ өглөөний мэндийг хүргэе.

Д.Энхтүвшин гишүүний асуултад хариулъя.

Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Гишүүний асуултад сая 2 хоногийн өмнө албан бичгээр танд хариу өгсөн юм байна. Албан бичиг нь цахимаар болон шуудангаар явсан гээд бичгийг нь авсан байж байна.

Сэлбэ төслийн хувьд нийт хөрөнгө оруулалтын зардал талдаа 2 их наяд 185.83 тэрбум төгрөгийн зарлага төлөвлөж, нийт борлуулалтын орлогыг энэ оны 5 сарын сүүлээс эхэлж борлуулалт хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Борлуулалтын орлогоор нийт 2 их наяд 647.74 тэрбум төгрөгийн борлуулалтыг орлогоор төлөвлөж байгаа.

“Сэлбэ 20 минутын хот” төслийн хувьд Улаанбаатар хотод Орон сууцжуулалтын корпорац дээр борлуулалтын төлөвлөгөөг журам баталж,

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсны дараа 2026 оны эхний улиралдаа буюу 5 сарын сүүлээр чадвал, чадахгүй бол 6 сарын эхээр бид борлуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Нийт 8575 өрх дээр 113 блок дээр борлуулалтыг хийнэ. Дундаж метр квадрат 61.72 метр квадрат. Дундаж орон сууцын үнэ 1 метр квадрат 4 сая 810 мянган төгрөгөөр борлуулахаар одоогийн бизнес төлөвлөгөөнд төлөвлөгдөөд явж байгаа.

Зах зээлийн үнэ болон бизнес төлөвлөлттэй уялдуулаад бид улирал болгон “Сэлбэ 20 минутын хот” дээр бизнес төлөвлөгөө, зах зээлийн үнэтэй судалгааг шинэчлээд явж байгааг дуулгах нь зүйтэй байх.

Газар чөлөөлөлт дээр одоогийн байдлаар 392.0 тэрбум төгрөгийн зардал гарсан гэсэн тооцоо байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Д.Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Монгол 4 компани байгаа. “Нутгийн буян”, “Монкон констракшн”, “Морин Сувд констракшн”, “Профешнл Строй” гээд 4 компани тендерт ялсан байгаа.

Энэ компаниудтай нийслэлийн удирдлага холбоотой болон хамааралтай компаниуд байгаа юу гэдэг асуултад хариулж өгөхийг хүсье.

Дээр нь метр квадрат талбайн өртөг, тэгээд дэд бүтцийн газар чөлөөлөлт 392.0 тэрбум гэж ойлголоо.

- Дэд бүтэцтэй холбоотой хөрөнгө оруулалт нь хэд юм?
- Метр квадратын өртөг нь зөвхөн барилгынх нь өртөг нь хэд болж байгаа юм?

Дэд бүтэц нь ороод, газар нь ороод гээд тооцвол ямар өөр өөрөөр дүнгүүд байгаа юм. Энэ талаар мэдээлэл өгөөч.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. 4 дүгээр микрофон.

**Т.Даваадалай:** Гишүүний асуултад хариулъя.

Засаг дарга нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Одоогийн байдлаар нийслэлийн удирдлагуудтай хамааралтай гэсэн мэдээлэл надад байхгүй байна. Би яг адилхан сошиал сувгаар тань шиг мэдээллүүд харж байгаа. Энэ талаар бид нягтлаад ямар компаниуд албан ёсоор ямар эзэмшигчтэй байгаа танд нэмээд бичгээр хүргүүлье.

Таньд 2 өдрийн өмнө албан бичгээр өгүүлсэн бичгийг давхиж VIBER-аар явууллаа.

Зардлын хувьд 1 метр квадратыг дотор тохижилттойгоор 4 сая 124 мянга 669.56 төгрөгөөр одоогийн байдлаар төлөвлөөд явж байгаа юм байна. Борлуулалтыг түрүүн хэлсэн. Дундаж үнэ 4 сая 810 мянгаар борлуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

**С.Бямбацогт:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Сошиалын мэдээ гэхээс илүү “Профейшнл Строй” гэдэг компани маань Нийслэлийн иргэдийн Хурлын төлөөлөгч Б.Сэргэлэнбаатар гэж Нийслэлийн Засаг даргын туслах гэж ойлгосон. Ийм хүн болон Үнэн ба зөв намын орлогч Ш.Мөнхсайхан гэдэг хүний хамтран байгуулсан компани байгаа.

Энэ компани мянган айлын орон сууц барихаар гэрээ хийсэн байна. Холбогдох мэдээллээр нь ороод үзэхэд энэ нотлогдож л байна лээ л дээ. OPEN DATA-гаар ороод үзэхээр.

Тэгэхээр төсөл маань одоо энэ газрын тос ч юм уу, Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц гэдэг төслийн халхавч доор анх эхэлж хийж гүйцэтгэхдээ бондоор санхүүжүүлнэ гээд яг одоо хийх болоод ирэхээр чадахаа болиод.

Тэгээд энэ дундуур нь ашиг сонирхлын зөрчил үүсээд байгаа юм биш биз дээ гэдэг хардлага төрөхөөр ийм мэдээллүүд угаасаа нээлттэй төрийн мэдээлэл дээр байна.

Тэгэхээр энэ талаар тодорхой мэдээлэл та хэд болон яг над шиг ингээд... /минут дуусав/

**С.Бямбацогт:** 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулья.

**Т.Даваадалай:** Гишүүний асуултад хариулья.

Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Сэлбэ дэд төвийн таны яриад байгаа “Профейшнл Строй” компани багц 3.3 дээр 12 блок дээр шалгараад ажил гүйцэтгээд явж байгаа юм байна.

Эзэмшлийн хувьд тодорхой мэдээлэл одоо яг надад байхгүй байна. Эргээд танд бичгээр мэдэгдье.

Б.Сэргэлэнбаатар бол Нийслэлийн Засаг даргын туслах биш. Одоогийн байдлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байгаа. Өнөөдөр яг одоо 10.00 цагаас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

Монгол Ардын намын бүлгийн хурал хуралдаж байгаа учраас өнөөдөр Засаг дарга ирж чадсангүй.

Энэ талаар хуулийн байгууллага тодруулаад, хэрвээ гомдолтой асуудлууд байгаа бол яах байх. Бид танд албан ёсоор тэр байгууллагуудын эзэмшлийг тодорхойлоод бичгээр явуулъя.

**С.Бямбацогт:** Т.Даваадалай дарга Д.Энхтүвшин гишүүний асуултад маш тодорхой хариулт бичгээр өгөөрэй. Одоогоор тодорхой мэдээлэл алга. Бичгээр өгье гэж Та хэд хэдэн удаа хэллээ шүү.

Тийм болохоор асуултад дутуу хариулсан, дутуу мэдээллүүдээ гүйцээж бичгээр өгөөрэй.

Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Уг нь энэ хуулийг анхнаас нь дэмжээд, санаачлагч өргөн барьсан гишүүдийн нэг байгаа юм.

Нийтдээ 13 их наядын гадаад зээллэгтэй. Үүнээс 6.2 нь газрын тосны үйлдвэр дээр байгаа.

Тэгээд энэ үйлдвэрийг 2028 оны нэгдүгээр улиралд багтааж ашиглалтад оруулах чиг үүргийг Байнгын хороон дээрээс өгсөн. Засгийн газар тэндээ ажиллаж байгаа болов уу гэж бодож байгаа.

Гэхдээ нийслэлийн төсөл нь ороод ирэхээр энэ хуулийг эргэлзээтэй, итгэл төрүүлэхүйц биш болгож байгаа байхгүй юу. Тэр Ш.Сэргэлэнбаатарын холбоотой компани Сэлбэ дэд бүтэц дээр бас ажил авсан явж байгаа юм байна шүү дээ.

Саяын тайлбар хэлдэг Т.Даваадалай дээр ч гэсэн тэр эхнэрийнх нь компани Туулын хурдны зам дээр бас 20 тэрбумыг авсан явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм эргэлзээтэй байгаа үед энэ хуулийг батлах уу? Ажлын хэсэг дээр Сэлбэ дэд бүтцийг дэмжээгүй юм билээ шүү дээ. Тийм ээ. Буцаагаад босгоод ирсэн.

Тийм хууль санаачлагч нар дахиж ярилцвал яасан юм. Хэд нь хуулиа буцааж татах санал гаргаж байгаа юм. Манай намын гишүүдээс энэ хуулийг буцааж татах санаачилгыг гаргасан байгаа. Хамт өргөн барилдсан гишүүдээс нь.

Тэгэхээр Их Хурлын дарга аа, энэ дээр ямар хуулийн гаргалгаа байгаа юм. Энэ дээр дахиж хууль санаачлагч нар ярилцвал яасан юм гэж би бодож байна.

- Газрын тосны үйлдвэр,
- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц–

-дээр эргэлзэх зүйл байхгүй. Үүнийг ашиглалтад нь оруулах ёстой.

Гэтэл Г.Дамдинням сайдаас дээр Байнгын хороон дээр асуулт асуух гэсэн. Байгаагүй. Одоо ч алга байна шүү дээ.

- ▶ Агаарын хөлгийн түлшээ 100 хувь үйлдвэрлэнэ гээд байгаа шүү дээ. Алтанширээгийн газрын тосны үйлдвэр ашиглалтад орох юм бол. Одоо 4.7 их наяд төгрөг нь ашиглаж болохгүй байна гээд энэ хуулийн гол амин судас нь байгаа.

Гэтэл Оросын Холбооны Улстай 15 жилээр агаарын хөлгийн түлш авах гэрээ байгуулна гээд. Одоо энэ нь соёрхон батална шүү дээ.

Тэгэхээр чинь нэг төр шийдвэр гаргаж байж хоёр өөр үзвэртэй юм яриад байгаа байхгүй юу. Хоёр өөр юм. Тэгээд Г.Дамдинням сайд алга. Их Хурлын дарга аа. Энэ хүн дөнгөж сая энүүгээр гүйгээд явж байсан. Энэ асуултыг асуумаар байна.

Дээрээс нь энэ хуулиа одоо яах юм бэ гэдгийг санаачлагч нар дахиж зөвшилцөх хэрэгтэй гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 12-ын “в” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг, амьдралд нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Онц сураарай. Тэгээд хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаарай. Эх орондоо хэрэгтэй иргэн болж төлөвшөөрэй гэж хүсье.

Энэ дээр Эдийн засгийн Байнгын хороо, ажлын хэсэг хариулна. Ажлын хэсгийн ахлагч хэн билээ? Жуковын Алдаржавхлан гишүүн.

Одоо ингээд 3 чухал төсөл орж ирсэн. 3-аас салгаад явж болох уу, болохгүй юу гэж байна. Эдийн засгийн байнгын хороо дээр ямар хариулт өгөх. Ж.Алдаржавхлан гишүүн ажлын хэсгийн ахлагч дээр хариулъя.

Дараа нь хууль санаачлагч Наранцэцэгийн Алтаншагай гишүүн бас хариулт бэлдэж байгаарай.

Г.Дамдинням сайдыг дуудъя. Г.Дамдинням сайд асуултад хариулна. Орж ирээрэй.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч аль ч шатанд татаж болно гэсэн хуулийн заалт байгаа.

Гэхдээ энэ хуулийг татах юм бол Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын асуудал, газрын тосны үйлдвэрийн асуудлууд дарагдаж татагдаад нөгөө бидний зорьж байсан ажил маань хүндэрнэ гэсэн бодолтой байна.

Тийм учраас энэ түвшинд хүрээд явсан юм чинь санал хураалтаар асуудлаа шийдээд явбал яасан юм бэ.

Бидний зүгээс заавал тэр Сэлбэ төвийг оруулна гэж шахаагүй шүү дээ. Манай ажлын хэсэг хасаж оруулсан. Тэгээд Их Хурал дээр босгосон юм билээ.

Тэгээд үүнийгээ Та Их Хурлын санал хураалтын түвшинд шийдэх бололцоотой.

**С.Бямбацогт:** Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хууль санаачлагч төслийг хэлэлцүүлгийн аль ч шатад татах боломжтой. Дэгийн хуулиар ийм зохицуулалт байдаг.

Гэхдээ хууль санаачлагчийн олонх нь татъя гээд санал нэгдсэн бол татагдана.

Гэхдээ сая хэлж байна шүү дээ. Энэ чухал олон 2 төсөл явж байгаа учраас үүнийг хэдүүлээ зөвшилцөөд, ойлголцоод явбал яасан юм бэ гэж. Энэ дээр Эдийн засгийн байнгын хороо тодорхой гаргалгаа гаргах нь зөв байх. Р.Сэддорж дарга.

Гонгорын Г.Дамдинням сайдыг Их Хурлын гишүүний асуултад хариулахаар Их Хурлын танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Сайд нар чуулгын танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Ярилцлага өгч байгаа юм уу? Гадаа ярилцлага өгч байгаа юм байна. Түр хүлээж байх уу? Л.Мөнхбаясгалан гишүүн ээ.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууж байя. Г.Дамдинням сайдыг орж ирэхэд Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Улсын Их Хурлын дарга аа, хариуцлагатай байх юмаа яримаар байгаа юм. Яг энэ хуультай холбоотойгоор өнгөрсөн хугацаанд ажлын хэсэг дээр Монголбанк орж ирж байна гээд тэнд дэд Ерөнхийлөгч нь юунд ч дуртай юм ороод ирсэн сууж байсан. Одоо болохоор байхгүй.

Манай бүлэг завсарлага аваад завсарлагынхаа хугацаанд ажлын хэсэгтэй уулзаж ярилцъя гээд явсан. Монголбанкны дэд Ерөнхийлөгч нь ирээд би ажлын хэсэгт байхгүй. Зүгээр та нарыг дуудахаар хүрээд ирлээ гэж байна шүү дээ.

Яг өнгөрсөн чуулган дээр ажлын хэсгийг танилцуулъя гээд Та тэнд Монголбанкны дэд Ерөнхийлөгч гээд л уншаад сууж байсан. Ямар ч хариуцлага байхгүй. Улсын Их Хурал өөрөө хариуцлагатай баймаар байна.

Тэгээд тэр гар утас хурааж авдаг бол Та наадах индэр дээрээсээ засаад хэлчхээрэй. Төрийн байгууллагууд бүгдээрээ дарга руугаа орохдоо гар утсаа хураалгаад ордог ийм нэг утгагүй зүйлтэй болсон юм билээ. Юугаа нуух гээд байгаа юм бэ? Хулгайгаа нуух гээгүй л юм бол. Ил яримаар байна. Тэрийг та бас нэг хэлчхээрэй.

Гадаадын зээлийн ашиглалт гэж яриад байгаа юм. Уг нь манай Монгол Улс Хөгжлийн банктай. Сая буудаг Г.Занданшатар Ерөнхий сайдын Засгийн газар Хөгжлийн банкныхаа балансыг 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлээд өгсөн.

Дахиад дээрээс нь

- ➔ Сэлбэ гэж орж ирж байгаа.
- ➔ Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гэж орж ирж байгаа.
- ➔ Газрын тос боловсруулах үйлдвэр гэж орж ирж байгаа.

Энэ гурвын мөнгөн дүнг нь аваад үзэх юм бол 2 тэрбум доллар.

Яг энэ чигээрээ Хөгжлийн банкн дээрээ өгөөд. Төслийн санхүүжилт байхгүй юу. Төсөл. Тэгээд төслүүд нь амжилттай хэрэгжээд явах юм бол Хөгжлийн банк ч гэсэн томроод үлдэнэ.

Хөгжлийн банк томроод үлдэж байгаагийнхаа хэрээр дахиад дараа дараагийнхаа том төслүүдийг Хөгжлийн банк санхүүжүүлэх баланстай болох байхгүй юу даа. Уг нь.

Жишээлэхэд, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Байдрагийн голын усан цахилгаан станцаас юугаараа ялгаатай болохоор Байдрагийн голын усан цахилгаан станц Баянхонгор аймагт баригдах гэж байгаа тэр станц хасагдаад ганцхан Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гэж оруулж ирээд байгаа юм.

Төсвийн байнгын хорооны хурал чинь тоглоом биш шүү дээ. Төсвийн байнгын хорооны хурал дээр танилцуулагдаж байхад энэ Сэлбэ дэд төвийн асуудал яригдаагүй. Тэгсэн чинь хулгайн замаар нэмээд чуулган руу оруулаад ирж байгаа юм.

Тэгээд нийслэлийнхэнд тоглоом гээд Д.Энхтүвшин гишүүн тоглоод яриад байгаа юм байхгүй шүү дээ. Эсвэл гомдоод яриад байгаа юм байхгүй байхгүй юу.

Гомдоод байгаа. Шалгаад хэлээдэхье гээд байх юм. Хүн гомдоод асуулт асуугаад суугаад байгаа юм биш шүү дээ. Хурлын дарга аа, бас нэг жоохон хариуцлагатай байлгах талаас нь харахгүй бол гомдоод байвал эргээд хариулаадахъя гэж байна шүү дээ.

Тэгээд Монгол Улс зээл авах эсэх асуудлаар ярьж байхад уг нь Монголбанк нь ажлын хэсэгт нь орж ярилцаад. Одоо жишээлэхэд төсөв дээр дахиад хариуцлагагүй юмнууд явагдаж байгаа. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц гээд үүнийг чинь дахиад төсөв дээр ачаалал болгохгүй гэж яриад байгаа байхгүй юу.

Гэтэл төсөв дээр ачаалал болсон. Хөгжлийн банкнаас зээл авсан. Тавантолгойн цахилгаан станцын төслийн нэгж байна. Эгийн голын усан цахилгаан станцын төслийн нэгжүүд байна. Зардлууд нь явсаар байгаад одоо бараг 100 орчим тэрбум төгрөг болсон байна уу. Тэгээд тэрийгээ төсөвт суулгаад төлнө гээд байсан. Одоо болтол байхгүй. Яаман дээрээ баахан зардал улсын төсөвтөө суулгана гэж хэлээд Хөгжлийн банкандаа бас нэг баахан гай.

Иймэрхүү асуудлуудаа цэгцлэхгүй бол ингээд өмнөх гай чинь дуусаагүй байхад дараа дараагийнх нь гай нэмэгдэж орж ирэх гээд байгаа. Үүнийг яаж эергээр харж байгаа юм.

- Яагаад Баянхонгор аймгийн Байдрагийн голын усан цахилгаан станцыг хасаж байгаа юм?
- Яагаад Сэлбэ дэд төвийн хулгайн төслийг нэмж байгаа юм?

Байшин бариад хүн оруулаад буцаагаад зарах юмыг заавал Улсын Их Хурал гадаадын зээл, тусламж гэж оруулж ирж хууль баталж өгөх ёстой юм. Энэ дээр нэг тайлбар авах гэсэн юм.

**С.Бямбацогт:** Хэн хариулах вэ? Сангийн яам. Ажлын хэсэг хариулъя. Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад.

**Ж.Дэлгэржаргал:** Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Байдрагийн усан цахилгаан станцын хувьд бодлогын баримт бичиг болон бусад асуудал дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр батлагдсан.

Одоо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу 63 мегаваттын усан цахилгаан станц төр, хувийн хэвшлийн түншлэлээр шинжилгээнүүд нь хийгдээд Засгийн газраар орж батлагдахаар явж байгаа.

Энэ хуулийн төслийн хувьд Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан гэрээ, хэлэлцээртэй төслүүдийн гадаад зээлийн санхүүжилттэй төслүүдийнхээ яг хэлэлцээрийн дүнгээр батлагдсан санхүүжилтээ бид хэрхэн яаж ашиглах вэ гэдэг зохицуулалт байгаа.

- Гадаад зээлүүдийн хувьд улсын хэмжээнд **98 төсөл** явж байгаа.
- Зээлийн ашиглалт **14 их наяд**.
- **14 их наядыг** бид цаад талын гэрээ, хэлэлцээрийн хугацаа 2030 он хүртэл ашиглах гэрээ, хэлэлцээртэй.

► Улсын Их Хурал яг ингэж баталж өгсөн.

Тэгэхээр одоогийн хуулийн зохицуулалт, төсвийн боломжоор бид энэ хугацаанд амжих боломжгүй нөхцөл байдал үүсэж байгаа.

Тэгэхээр гэрээ, хэлэлцээрийн хугацаанд нь гадаад зээлийнхээ санхүүжилтийг бид хэрхэн үр дүнтэй ашиглах вэ гэдэг дээр зөвхөн энэ хоёр төсөл дээр бодлогын зохицуулалт хийж байгаа ийм хуулийн төсөл байгаа.

**С.Бямбацогт:** Да.Цогтбаатар гишүүн Их Хурлын даргын өрөө рүү орохдоо гар утсаа хураалгаж байна гэж асуудал ярьж байна.

Миний мэдэхийн л Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 гишүүн дээр орохдоо гар утсаа үлдээгээд ордог. Би лав сүүлийн арван хэдэн жил ийм л дэг жаяг, ийм л Төрийн ордны ёс журам, дүрэм журмыг биелүүлээд л явж байгаа. Энэ 126 гишүүн ч гэсэн биелүүлдэг, бүх л хүмүүс биелүүлдэг.

Тэгэхээр Их Хурлын гишүүдэд тийм ялгавартай ханддаг дүрэм журам гэж байхгүй байх.

Өнөөдөр би тэнд очиж суучаад бий болгосон биш. Уламжлалт байсан дүрэм журмыг нь би усыг нь уувал ёсыг нь дага гээд л тэр дүрэм журмын дагуу л хандаж байгаа.

Харин Та тэгээд хэтрүүлээд нэгжсэн барьсан, нэгжих гэсэн гээд юм ярьж байна лээ.

Тэгвэл тийм зүйл байхгүй ээ. Үүнийг Та зөв ойлгоорой.

Гонгорын Дамдинням гишүүн асуултад хариулья.

**Г.Дамдинням:** Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулья.

Сая орж ирж байгаад хоцорлоо. Уучлаарай.

2025 оны хувьд бид Алтанширээд газрын тосны үйлдвэр барьж байгаа.

► Газрын тосны үйлдвэр 80 мянга орчмын хүчин чадалтай.

Өнөөдрийн манай хэрэглээ 85 мянга байгаа. 140 мянган тоннын хүчин чадалтай юм. Манайх тэр дамжуулан ачих байгууламж маань, цэнэглэх байгууламж.

Тэгэхээр хэлэлцээрийн хувьд бид зах зээлийн зарчмаар нээлттэй өрсөлдөж, аль хямдаас нь авах ийм зарчимтай.

Мөн Монгол Улсад үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүнийг шууд хамгийн түрүүнд авах ийм зохицуулалттайгаар бид хэлцэл хийсэн. Шалгаж үзээрэй. Хардаж болно. Бодит ажил. Эх орондоо хэрэгтэй зүйл хийгээд явж байгаа л гэж ойлгох ёстой байх. Тийм.

**С.Бямбацогт:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Хамгийн сүүлчийн байдлаар таныг Орос руу явахаас өмнө энэ хэлэлцээрийг шүүж үзсэн. Бүх юмыг уншсан. Тийм заалт байхгүй.

Одоо нэмээд ирсэн байх магадлалтай гэж бодож байна. Тэгэхдээ төр хэрвээ нэг л байгаа бол нэг л зарчимтай баймаар байна. Оросын Холбооны Улстай 15 жилийн бүр Улсын Их Хурал соёрхон баталсны дараа санамж бичгээр тийм юм оруулдаггүй. Та тэрийг мэдэж байгаа.

Тийм учраас энэ хуулийг буцаагаад, хотын орлогч Б.Сэргэлэнбаатарын хувийн ашиг сонирхол бүхий компани Сэлбэ дэд бүтцэд орсон байгаа. Т.Даваадалай таны ч гэсэн сонирхол өмнөх төсөл дээр чинь байгаа.

Тийм учраас энэ хуулийг санаачлагч гишүүд буцаж хоорондоо зөвшилцөх тийм боломжийг олгож өгөөч ээ.

**С.Бямбацогт:** Г.Дамдинням сайд эхлээд хариулъя. Дараа нь Ж.Алдаржавхлан ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Г.Дамдинням:** Хэлэлцээр дээр Та бүтэн харна биз дээ. Монгол Улсын зах зээл дээр ямар нэг ялгаварлал байхгүй. Хямдхан, бас дотоодын эх үүсвэрээс авна гээд л явж байгаа л даа.

Тэгээд бид өөрийнхөө дотоодын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг л хийнэ шүү дээ. Л.Мөнхбаясгалан гишүүн ээ.

Тэгэхээр бидэнд тэр дээр айх, эргэлзэх зүйл байхгүй. Сингапурт хямдхан байх, эсвэл “Jet A-1” ч гэдэг юм уу. Тийм ээ. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлээс хямдханаар орж ирэхээр бид тэндээс авах эрхээ нээлттэйгээр авч үлдсэн байгаа энэ хэлэлцээрээр.

Энэ хэлэлцээрийн хамгийн том давуу тал нь юу вэ гэхээр 36 жилийн хугацаанд Монгол Улсыг газрын тосны бүтээгдэхүүнээр тогтвортой, тасралтгүй хангана гэдэг хэлэлцээр давхар мөрдөгдөж эхэлж байгаа юм. Хүчин төгөлдөр болж байгаагаараа их том давуу тал манай улсад бий болгож байгаа л гэж харах ёстой.

**С.Бямбацогт:** Жуковын Алдаржавхлан гишүүн. Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

**Ж.Алдаржавхлан:** Бид гишүүдийн саналд хүндэтгэлтэй хандаж байна.

Хууль санаачлагчтай бас ярилцсан. Хэрвээ дэгийн хуулиар боломж байвал ажлын хэсэг болон хууль санаачлагчтай зөвшилцөх цагийг нэг өдрийн хугацаатай завсарлага өгөөч ээ гэж Их Хурлын даргаас хүсэж байна.

**С.Бямбацогт:** Л.Мөнхбаясгалан гишүүн бол хууль санаачлагчид нь яг Сэлбэтэй холбоотой асуудлаа татвал яасан юм бэ гэсэн санал гаргаад байгаа.

Манай хууль санаачлагч Наранцэцэгийн Алтаншагай гишүүн байр сууриа илэрхийлэх үү. Энэ дээр. Наранцэцэгийн Алтаншагай гишүүнд микрофон өгье.

**Н.Алтаншагай:** Баярлалаа. Энэ өөрөө их өндөр ач холбогдолтой хууль л даа. Олон жил яригдаж байгаа.

Авсан зээлээ ашиглах, стратегийн бүтээгдэхүүнээ эргэлтэд оруулах, Улаанбаатарын хотын өмнө тулгамдсан олон асуудлуудыг шийдэх ийм хууль байгаа юм.

Тэгээд ажлын хэсгийн даргатай байр суурь нэг байна.

Мөн хамт өргөн барьсан Л.Мөнхбаясгалан гишүүн ийм санал гаргаж байна. Тэгээд зөвшилцөх, дахиж ажлын хэсгийг хуралдуулах завсарлага авъя гэсэн ийм.

**С.Бямбацогт:** Ойлголцоод, зөвшилцөөд явах ёстой байх. Энэ дээр Та бүхэн хоорондоо нэг сайн ярилцаад, бүлгийн дарга нар нэг ярилцаадахгүй юу.

Даваагийн Цогтбаатар гишүүн нэмэлт асуултаа асууя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Төсвийн тухай хуульд гай болох гээд байна л гэж малгайтайгаар яваад байгаа шүү дээ. Ер нь бол.

- Газрын тосны төслийг дэмжиж байгаа.
- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг дэмжиж байгаа.

- Сэлбэ төвийн хулгайг дэмжихгүй байгаа.

Тэгээд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр энэ дээр жоохон идэвхтэй ажиллах хэрэгтэй байх.

Хөгжлийн банкныхаа тухай хуулийг өөрчлөөд Хөгжлийн банкн дээрээ одоо жишээлэхэд иргэдэд тавьдаг, Монголбанкнаас иргэдийн эрсдэлийг хаахын тулд тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлт гэдэг юмыг Хөгжлийн банкн дээрээ тавьж хуульгүйгээр журмаар зохицуулагдаж яваад байгаа энэ асуудлыг цэгцлээд энэ шатандаа жишээлэхэд бид одоо энэ –

- газрын тос боловсруулах үйлдвэрийн зээл,
- Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын зээлийг –

-Хөгжлийн банкн дээрээ аваад явах юм бол Хөгжлийн банкны чинь баланс ч томорно. Энэ дагуу дахиад дараа дараагийн том төслүүд рүү Хөгжлийн банкиг оруулахад бэлэн болгох энэ талаас нь ажилламаар байгаа юм.

Тэгээд Их Хурлын даргатай холбоотой нэг юм хэлбэл... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Наранцэцэгийн Алтаншагайгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 12-ын “д” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Тэгээд хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаж эх орондоо хэрэгтэй дэлхийн иргэн болж хүмүүжихийг Та бүхнээс хүсье. /алга ташив/

Да.Цогтбаатар гишүүний асуултад хэн хариулах вэ? Эдийн засгийн хөгжлийн сайд Жадамбаагийн Энхбаяр хариулъя.

**Ж.Энхбаяр:** Энэ хариулах бололцоонд Л.Мөнхбаясгалан гишүүнд нэг мэдээлэл хүргээдэхье.

- Манай газрын тос боловсруулах үйлдвэрийн хүчин чадал жилийн 1.5 сая тонн.
- Монгол Улсын хэрэглээ өнөөдрийн байдлаар 2025 оны гүйцэтгэлээр 2.9 сая тонн болсон.

Тэгэхээр Алтанширээний тос боловсруулах үйлдвэр манай Монгол Улсын хэрэгцээний 50, 60 хувь дээр л очно.

Тэр агаарын хөлөг төстэй холбоотойгоор одоо бид 80 мянган тонныг импортолж байгаа, хэрэглэж байгаа.

Гэхдээ ирээдүй цаг дээр үйлдвэр маань өөрөө 85-д хүрнэ.

Тэгэхээр агаарын орон зай нислэг нэмэгдэх, гаднын дамжин өнгөрөх ачаалал нэмэгдэх үед манайх дотоодоосоо 100 хувь хангаж чадахгүй.

Тийм хоёр дахь нийт тогтвортой нийлүүлэлтийг хангах үүднээс Оросын Холбооны Улсаас агаарын түлшийг 15 жилийн хугацаанд бид авч хэрэглэж таарна. Учир шалтгаан нь ийм шүү. Энэ өөрөө бүтэн... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Ганбаатар:** Жоохон дэгээрээ явмаар байна. Дуртай хүнд нь үг өгөөд байдаг.

Энэ төсвийн хүрээний мэдэгдэл улсын төсвийн батлагдсан нийт зарлагын хязгаарт хамаарахгүй байх гэдэг дээр нь би эсрэг байгаа.

Ийм замбараагүй байж болохгүй. Би л лав 2016 оноос хойш гишүүн байгаа. Ийм байхыг санахгүй юм байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл билүү. Хүн байна уу? Энэ юу гэж үзсэн юм.

Тэгээд ийм цонх нээгээд өгч болохгүй шүү дээ. Ингэж замбараагүй байж болохгүй.

О.Цогтгэрэл гишүүн завсарлага авахдаа хэлж байсан. Би адилхан саналтай байгаа. Ийм байж болохгүй. Хэдэн онд ингэж нээж өгсөн юм. Мэдэхгүй. Гэхдээ ийм байж болохгүй. Би үүнийг эсэргүүцэж байгаа.

Тэр доторх төслүүдийн чухал чухал биш дээр нь би ярьсангүй. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл юу гэж үзсэн юм гэдгийг би хариулт авмаар байна.

Хоёрдугаарт, хэлэлцүүлгийн явцад Хөгжлийн банктай холбоотой юм орсон юм уу, ороогүй юм уу? Эсвэл анх хуулийн санал дээр байсан юм уу?

Хөгжлийн банктай холбоотой зүйл, заалтуудыг зүгээр хэлэлцүүлгийн явцад нэмсэн юм уу? Эсвэл өргөн баригдахдаа байсан юм уу?

Гуравдугаарт нь, жоохон далайцтай асуулт асууя. Их зээлүүдээ төлөх чадвар Монгол Улсад байгаа юу? Байгаа юу? Өнөөдөр.

Тэр Уул уурхайн яам биржээр нүүрсээ зарж байгаа юу? Мөнгө олж байгаа юу? Олсон мөнгөөрөө зээлээ төлнө шүү дээ. Надад нарийвчилсан тоонууд байна л даа.

Тэгэхээр энэ чинь эдийн засагтай холбоотой, төсөв мөнгөтэй холбоотой маш том асуудал.

Тэгээд төсвийн хязгаарыг чинь санамсаргүй тавьчхаагүй шүү дээ. Энэн чинь маш тийм өндөр ач холбогдолтой учраас “зарлагын дээд хязгаар” гэдгийг тавьж байгаа шүү дээ.

Тэгээд нь энэ хамааралгүй, тэр нь хамаатай тэр гэж ийм дураараа аашилж болохгүй байх. Би ингэж аашилж байсныг санахгүй байна. Олон жил би харж байхад туршлагатай гишүүд хийлгэдэггүй байсан шүү дээ. Ийм асуудлуудыг. Өргөн бариулдаг ч үгүй байсан юм.

Ингээд харж байхад ер нь зах замбараагүй. Тэгээд хаа хамаагүй татварынхаа хуульд гар дүрдэг. Тэгээд нөгөөдүүл нь нүдэн балай. Өөртөө таалагдсан юмаа янз янзын юм яриад зогсоодог.

Тэгээд ийм ялгавартай байдлаар хандаж болохгүй. Сангийн яам тэр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл юу харж байдаг юм. Юу гэж үзсэн юм. Зөв гэж үзсэн юм уу, үгүй гэж үзсэн юм уу.

Тэгээд Хөгжлийн банктай холбоотой заалтаар ер нь яг яах гэж байгаа юм. Л.Оюун-Эрдэнэ сайдын хийсэн хамгийн гол үнэхээр магтууштай зүйл нь энэ Хөгжлийн банктай холбоотой асуудал шүү дээ.

Би ихэнх юман дээр нь санал нийлдэггүй. Л.Оюун-Эрдэнэтэй. Гэхдээ би хамгийн гол хийсэн ажлыг нь магтаж хэлэхэд Хөгжлийн банктай холбоотой асуудал.

- Хөгжлийн банкиг цэгцэлсэн.
- Өрүүдийг нь төлүүлсэн.
- Зээлүүдийг нь төлүүлсэн.
- Хөгжлийн банк нь цэгцэрсэн.

- Энэ заалтаар яах гэж байгаа юм?
- Юу урсгуулах гэж байгаа юм?

Би уншаад сууж байна л даа. Энэ заалтыг. Оруулсан заалтыг нь. Их сайхан үгтэй л юм байна л даа.

Анх Хөгжлийн банк чинь маш сайхан үгтэй, маш сайхан санаатай гарсан. Тэгээд бүгд завхарсан шүү дээ. Асуултад хариулт аваад тэгээд тодруулъя.

**С.Бямбацогт:** Төсвийн байнгын хороо. Энэ төсөвтэй холбоотой асуудал ярьж байна. Энэ бол Төсвийн байнгын хороогоор орсон асуудал.

Тийм болохоох мэргэжлийн Байнгын хороо хариулах ёстой. Дээрээс нь Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэгт ямар хүмүүс оруулах, оруулахгүйг зохицуулалтыг хийж байгаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс оруулах ёстой байсан уу, байгаагүй юу. Монголбанкнаас холбогдох албан тушаалтан ирсэн байна. Да.Цогтбаатар гишүүн дэд Ерөнхийлөгч нь ирэх ёстой гэж байна. Энэ дээр Та бүхэн бас нэг тайлбар хийе.

Араас нь Г.Дамдинням сайд асуултад хариулт бэлдэж байгаарай.

Н.Наранбаатар гишүүн. Тэгээд ажлын хэсэг нэмж хариулна шүү.

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар.

**Н.Наранбаатар:** Хуулийн төсөлтэй холбогдуулаад Төсвийн байнгын хорооноос Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд албан бичиг явуулсан.

Тэгээд энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад Та бүхэн дүгнэлт гаргаж өгөөч ээ гэсэн утгатай албан бичиг явуулаад хариу ирсэн.

Тэгээд хариуг нь гишүүдэд бүгдэд нь хувилаад цаасаар тараагаад өгсөн.

Тэгээд шаардлагатай дахиад. Ер нь Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагуудыг зөрчиж байна гэдэг ийм л утгатай хариу ирсэн.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хүн байгаа юу?

Ажлын хэсгээс нэмээд хариулъя. Тогтвортой байдлын зөвлөлөөс.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 12-ын “г” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс удахгүй болох гэж байгаа элсэлтийн шалгалтдаа амжилттай сайн бэлдэж, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаж, улс эх орондоо хэрэгтэй хүн болоорой гэж хүсэн ерөөе. /алга ташив/

Манай Д.Батлут гишүүн маань өөрөө тэнд зогсож байна. Д.Батлут гишүүний маань бага хүү 10-ын “г” ангийн сурагч юм байна. Хосбаяртаа,

гишүүнийхээ хүүд. Б.Хосбаяр аавтайгаа хамт зогсож байх шиг байна. Тийм ээ. /алга ташив/

Ажлын хэсэг нэмж хариулъя. Жуковын Алдаржавхлан гишүүн. Дээрээс нь Сангийн яамнаас тодруулж нэмэлт хариулт бэлдээрэй.

**Ж.Алдаржавхлан:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Энэ хууль бол нэмж төслүүдийн нэрийг өөрчлөх, нэмж өөр төсөлд тусгахыг хориглосон тийм заалттай байгаа хууль.

Тэгэхээр өөр төслийн талаарх бололцоо байхгүй. Төсөвт угаасаа манайхан мэдэж байгаа шүү дээ. Төсвийн ачаалал хэтэрсэн. Гадаад зээлийнхээ ашиглалтыг ашиглаж чадахгүй. 13.5 их наяд төгрөгийн гадаад зээлийн хүүг бид өнөөдөр хий дэмий төлөөд явж байгаа.

Тийм учраас гарцаагүй энэ хуулийг гаргаж гадаад зээлийн ашиглалтыг өндөр түвшинд аваачихгүй бол энэ хоёр нөгөө яриад байгаа—

- газрын тосны төсөл,
- Эрдэнэбүрэнгийн станцын төсөл—

-хоёр маань сунаад 2032 он руу явах гээд байгаа юм.

Одоогийн батлагдсан төсвийн харилцаагаар 1.2 их наяд төгрөг гадаад зээлийн ашиглалтаас төсөвт туссан. Энэ үр дүнгээр явах... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Сангийн яам. 3 дугаар микрофон.

**Ж.Дэлгэржаргал:** Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам. Ж.Дэлгэржаргал.

Зээлийн үйлчилгээний төлбөрийн хувьд одоо яг 98 төслийн зээлийн үйлчилгээний төлбөр дээр 3 янзын төлбөр явж байгаа.

▷ **Нэгдүгээрт нь,** үндсэн төлбөр.

Эргэн төлөлтүүд өөрөө –

- урт хугацаатай,
- хөнгөлөлттэй,
- нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй.

▷ **Хоёрдугаарт нь,** эргэн төлөлтүүд.

Бид үндсэн төлбөрийн хугацаа болохоор үндсэн төлбөрөө хүүгийн төлбөр, нэмэх нь хэр ашиглаж байгаа, ашиглалтын үлдэгдэл дээрээ шимтгэл төлдөг.

Тэгэхээр одоогоор жилд дунджаар 1.3 их наядыг зээлийн үйлчилгээний төлбөрт төлөөд явж байгаа.

Засгийн газрын өр нийтдээ гадаад зээлийнх 23 их наяд байгаа.

Тэгэхээр энэ төслүүд маань өөрөө Их Хурлаар батлагдсан хугацаандаа. Дээрээс нь бусад улс орнууд төсвийн дүрмээсээ үндэсний томоохон төслүүдээ хэрэгжүүлэхдээ тусад нь хууль гаргасан улс орнууд байгаа. Сингапур, Герман гээд.

Дээрээс нь бодлогын зохицуулалт хийхгүй бол одоогийн бид төсвийн дүрмээрээ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулъя. 3 дугаар микрофон.

**Ж.Дэлгэржаргал:** Одоогийн төсвийн дүрмээрээ яах юм бол –

- ▷ **Нэгдүгээрт**, хөрөнгө оруулалтын төсөл хамгийн чухал ач холбогдол нь төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орж байж нийгэм, эдийн засгийнхаа асуудлыг шийдэж, нийгэм, эдийн засгийнхаа хэрэгцээг хангах байдаг. Санхүүгийн ач холбогдлоос илүү ач холбогдол нь.

Тэгэхээр яг энэ төсвийн дүрмээрээ явах юм бол бид газрын тос боловсруулах үйлдвэрийг 10 жилийн дараа ашиглалтад авна.

Гэтэл Улсын Их Хурлаар соёрхон баталсан хэлэлцээрийн хугацаа 2028 он байгаа.

Тэгэхээр бусад улс орнууд ч гэсэн тусад нь томоохон төслүүд дээрээ зохицуулалт хийдэг. Нэгэнт одоо бид энэ эхэлсэн төслүүдээ зайлшгүй бодлогын зохицуулалт хийхгүй бол өнөөдөр нийгмийнхээ асуудал, тэгээд бусад эдийн засгийн асуудлуудаа шийдэхэд маш хүндрэлтэй байдал бий болж байгаа.

Нөгөө талдаа эх үүсвэрүүд –

- газрын тос гэхэд **1.75 хувь**,
- Эрдэнэбүрэн **2 хувийн хүүтэй**.

Одоо бид цаашдаа яг ийм нэн хөнгөлөлт, хөнгөлөлттэй эх үүсвэрүүд олдоход маш хүндрэлтэй. Олдох боломжгүй байгаа.

Тэгэхээр эх үүсвэрээ бид хугацаанд нь ашиглах бодлогын зохицуулалт гэж үзэж Сангийн яам энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

**С.Бямбацогт:** Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Нэгдүгээрт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дэмжээгүй. Энэ бол чухал асуудал шүү. Энэ чинь мэргэжлийн хүмүүс байгаа шүү дээ.

Хоёрдугаарт, энэ төслийг ойлгож байгаа. Гэхдээ хаалгаар чинь дараа нь олон ийм байдалтай хууль орж ирнэ шүү дээ. Зүгээр нь энэ л чухал. Дараа нь ахиад 2 төсөл яриад л энэ хаалгаар чинь ороод ирнэ. Тэгэхгүй юу? Нийгэм, эдийн засгийн маш чухал төсөл одоо энэ хязгаарт хамаарагдахгүй гээд дахиад л ороод ирнэ.

Тэгэхээр нь “за” гээд л зогсож байхаас өөр арга байхгүй. Тэгвэл наад төсөв чинь хэд задарна гэсэн үг. Яг тэр арван хэдэн онд замбараагүй байсантай адилхан болно гэсэн үг. Тийм байлгахгүй гэж наад хязгаарыг чинь тавьсан байгаа шүү дээ. Та нар сайн мэдэж байгаа. Тэрийгээ.

Тэгээд энэ Хөгжлийн банктэй холбоотой асуудалд яагаад хариулахгүй байгаа юм бэ? Хариул л даа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг хариулъя.

**С.Бямбацогт:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Ажлын хэсэг дээр энэ санал анх гарсан юм.

Ер нь Хөгжлийн банкиг цаашдаа гадаадын зээл ашиглалтыг хариуцаад явах нь зүйтэй гэсэн саналууд Их Хурлын гишүүдийн түвшинд яригдсан.

Тийм учраас ажлын хэсэг дээр анх санал гарсан. Гэхдээ нэлээд зөөллөж ерөнхий байдлаар энэ саналыг оруулсан боловчиг Байнгын хороон дээр дэмжигдээгүй. Дэмжигдээгүй саналыг одоо энд тайлбарлаад л сууж байх шаардлагагүй байх.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**Ж.Ганбаатар:** Дарга анхааралтай байгаарай.

Энэ хуулийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дэмжээгүй байхад нь яагаад ингээд үргэлжлүүлээд хүчээр түрээд байдаг юм.

Тэгээд дээрээс нь би энэ төсөлтэй нь холбоотой юм ярихгүй шүү дээ. Төсөл нь үнэхээр чухал уу гэдэгт чухал гэдгийг ойлгож байна. Тэгэхдээ араас нь чинь өчнөөн олон төслүүд энэ хаалгаар чинь орно. Ийм байдлаар шийдэхгүй байх

гаргалгаа байгаа шүү дээ. Сангийн яам өөрсдөө гаргалгаагаа гаргаад ажлаа хийгээч тэгээд.

Өмнө нь бас иймэрхүү байдлуудтай холбоотой юм зөндөө л яригддаг л байсан л даа. Өнөөдөр анх яригдаж байгаа юм биш. Тэр болгонд нь яам, Сангийн яам учраа олоод л явдаг л байсан юм даа.

Тэгээд л заавал Их Хурал руу оруулж ирээд л. Үүнийгээ анхаарах хэрэгтэй дээ. С.Бямбацогт дарга. Санал хэллээ. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Санал хэллээ.

Ер нь сая Жамбалын Ганбаатар гишүүний асууж байгаа асуулт, хөндөөд байгаа асуудлууд дээр бичгээр нэмэлт мэдээлэл, тайлбар ажлын хэсгээс, холбогдох албан тушаалтнаас хүргүүлээрэй. Үүнийг Төсвийн байнгын хорооны ажлын алба зохион байгуулаарай.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Та бүгдийнхээ өдрийн мэндийг хүргэе.

Төслүүд хэрэгтэй төсөл үү гэвэл хэрэгтэй төсөл. Яалт ч байхгүй хэрэгтэй төсөл.

Тэгэхдээ өрийн бүртгэлээс гадуур байлгана гэдэг бол аюултай эрсдэлтэй зүйл байгаа юм. Нөгөө талаараа төсөл нь өөрөө эрсдэлтэй байгаад байна шүү дээ.

- ▶ Эрдэнэбүрэнгийн зээлийг намайг сайд байхад 2018 онд хөрөнгийн эх үүсвэрийг нь шийдээд л явсан. Одоо болтол эхлээгүй.
- ▶ Энэ нефтийн төсөл байна. Бас л би тэр үед тэнд эрчим хүчний шугамыг нь татаж өгөөд л төслийн ажил гээд л ингэсэн. Одоо болтол 8 жилийн дараа байхгүй.

Тэгэхээр энэ хоёр эрсдэл чинь нийлээд маш том хүндрэлийг авчирч магадгүй гэдгийг бид бодох ёстой.

2014 онд энэ өрийн бүртгэлээс гадуур төмөр зам, эрчим хүчийг гаргасан юм. Тэгээд эцсийн дүндээ Ардчилсан намыг одоо энэ зээлийн өрөнд унагалаа гэдгээр унагасан байхгүй юу.

Тэгэхээр одоо бид өөрсдөө ийм аманд орох вий гэж би бас болгоомжлоод байгаа юм.

Би яагаад тэгж байна вэ гэвэл экспортын орлого чинь эрс буурч байна. Яг үнэндээ бид 15 тэрбум доллар гаднаас экспортоор олж байгаа боловч үүний дийлэнх нь нүүрс.

Өнгөрсөн жил 8 тэрбум нь нүүрс байсан байхгүй юу.

- 2024 онд **8 тэрбум**.
- 2025 онд **5 тэрбум** болсон.

➤ **3 тэрбумаар буурсан.**

Тэгэнгүүт тэр хүндрэл өнөөдөр төсөв, санхүү дээр бий болж эхэлж байна шүү дээ.

Манай экспортын бодит хүчин чадал гэвэл ерөөсөө 3 тэрбум доллар л байгаа байхгүй юу. 15 биш.

Бид нэг ноос, ноолуур бүх юмаа яаж байгаад, хөдөө аж ахуй, мах гэж байгаад 1 тэрбумыг олно. Дээр нь нэг алт, зэс гэж байгаад 2-ыг олбол их юм байхгүй юу.

Ингээд үндсэндээ 3-хан тэрбум яг манай бодит чадал.

Тийм учраас тэр 15 харагдаад байгаагийн хэмжээгээр бид төсвөө тэлээд, төсвийнхөө алдагдлыг нэмээд өр зээлээ аваад яваад байх юм бол нэг өдөр Аргентин болно.

Яг тийм болно шүү. Яагаад гэвэл бодит эдийн засгийн экспортын чадал чинь 3 тэрбум доллар байгаа байхгүй юу. Зүгээр л алт, зэсийн үнийн өсөлт, нүүрсний үнийн өсөлт энэ тэрээс олсон хэдийгээ байнгын юм шиг бодоод байгаа чинь буруу.

Өнөөдөр төсвийн алдагдал 1.3 их наяд. Энэ чинь 400 сая. Энэ 400 сая долларыг чинь бид зээлээр санхүүжүүлнэ шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр—

- **төсвийн алдагдлаа** зээлээр санхүүжүүлнэ,
- **хөрөнгө оруулалтаа** зээлээр санхүүжүүлнэ.

Ингээд явах юм бол үүнийг төлж дийлэх үү. Үүнийг бид маш сайн бодохгүй бол нэг өдөр төлж дийлэхээ больсон байж магадгүй.

Юун түрүүнд бидний анхаарах юм бол ерөөсөө экспорт байгаа юм. Экспортын орлого дутвал бид валютын нөөц дутаад төлбөрийн шокт ороод бүх юмны үнэ өсөөд, валютын ханш чинь өсөөд явна.

Тийм учраас импортыг орлох, экспортыг дэмжих үйлдвэрлэлийн тухай бид ярих ёстой. Одоо ингээд л нэг төр садаа болоод л, бизнесийг зогсоогоод байгаа юм шиг юм яриад байх юм. Тийм юм байхгүй.

► Гол садаа болж байгаа юм чинь **санхүү, татварын орчин**.

Одоо хандлагаа өөрчил. Тэр дэмий 90-ээд оны юм ярьдгаа боль. Энэ зээлийн хүү өндөр байгаагаа өөрчил. Зээлийн хүүгээ бид бууруулах хэрэгтэй байна шүү дээ. Ийм банкны монопол тогтсон байхад бид яаж бизнес хөгжих юм бэ.

Тэгээд хэрвээ экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол түүнд татварын дэмжлэг үзүүл. Импортын татвар тавьж өг. Тэгэхгүй яаж бизнес хөгжих юм бэ.

Тийм учраас бид өнөөдөр бизнесээ хөгжүүлэе гэвэл хамгийн гол учир шалтгаан төрийн дарамтдаа биш шүү. Энэ попролт. Харин гол шалтгаан юу байна гэвэл төсөв, санхүүгийн орчин чинь муу байна. Үүнийгээ өөрчлөх хэрэгтэй.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. Газрын тос боловсруулах үйлдвэр удаашралтай байгаа талаар асууж байна. Хариулъя. 3 дугаар микрофон.

**Д.Алтанцэцэг:** Сайн байна уу? Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Газрын тос боловсруулах үйлдвэр цоо шинээр дэд бүтэц, үйлдвэрээ, түүхий тос дамжуулах хоолой бүгдийг нь цогцоор барьж байгуулж байгаа.

Энэ үйлдвэрийн төсөл маань яг олон улсад томоохон төслүүд хэрэгждэг дэс дарааллын дагуу явагдаж байгаа.

Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсны үндсэн дээр төр, засгаас энэ үйлдвэрийг барих нь нийгэм, эдийн засагт үр ашигтай гэсэн шийдвэр гараад 2019 оноос эхэлж бид инженерчлэлийн ажлыг эхлүүлсэн.

Инженерчлэлийн ажил нь байгууламж тус бүрд өөр өөр цаг хугацаа, төвөгшил шаардаж байгаа учраас 4 хэсэгт хэрэгжүүлж, эхний хэсэг нь харьцангуй бага төвөгшилтэй байсан нь 2024 онд ашиглалтад хүлээж авсан.

2, 3 дугаар багцаас эхэлж үндсэн технологийн байгууламжууд эхэлж байгаа.

Одоогийн байдлаар төслөө бид хэрэгжүүлэгчийн хувьд амжилттай хэрэгжүүлж байгаа гэж бодож байгаа. Нарийвчилсан инженерийн зураг, төслийн

ажил дуусаж тоног, төхөөрөмжүүд гадаадад үйлдвэрлэгдэн тээвэрлэлт хийгдэж үйлдвэрийн талбайд ирээд барилга угсралтын ажил явагдаж байгаа.

Гишүүний санаа зовж байгааг ойлгож байна. Энэ үйлдвэр бүрэн хүчин чадлаараа буюу 1.5 сая тонн түүхий тос боловсруулах үед 2025 оны байдлаар тооцож үзэхэд 5.5 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой. Үүнээс зээлээр санхүүжиж байгаа Энэтхэгийн газрын тосний үйлдвэрийг санхүүжүүлж байгаа нэн хөнгөлөлттэй урт хугацааны зээл, мөн Эрдэнэс Тавантолгойгоос санхүүжиж байгаа түүхий тос дамжуулах хоолой зэрэг зээлүүдээ эргэн төлсний дараа татварыг 25 хувиар улсын төсөвт төвлөрүүлэхэд үлдэгдэл нь 300 орчим тэрбум төгрөг үлдэхээр байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин, Эрдэнэбилигийн Одбаяр нарын урилгаар Завхан аймгийн Тэлмэн сумын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Ахмадууд Та бүхэндээ өнгөрсөн цаг хугацаанд Монгол Улсынхаа тусгаар тогтнол, хөгжил дэвшил, бүтээн байгуулалтын төлөө хийж бүтээснийг Монголын дунд үеийнхэн, залуучууд маань үргэлж дурсан санадаг шүү.

Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Манай тойргийн гишүүд байна. Манай Э.Одбаяр гишүүн хамт явж байгаа юм байна.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн нэмэлт асууя.

**Ц.Даваасүрэн:** Ашиглаагүй зээлийн үлдэгдэлтэй хүү төлдөг гэж үнэн үү? Үүнийг тодруулъя.

Нефтийн үйлдвэр чухал нь үнэн. Яагаад гэвэл бид өнөөдөр хүнс, хувцсандаа тэрбум доллар зарцуулдаг мөртлөө хүндээ машиныхаа хоолонд 2 тэрбум доллар зарцуулж байгаа чинь өөрөө буруу байхгүй юу. Хэрэглээ нь өөрөө буруу болсон байгаа байхгүй юу.

Тийм учраас бид энэ хандлагуудаа өөрчилж явахгүй бол ерөөсөө болохгүй болчихоод байна.

Татварын аргаар зохицуулж машины импортын асуудлыг шийдэхгүй бол хүнээсээ илүү хоол иддэг машинтай улс орон хаана байдаг юм бэ? Тэгээд үүнийгээ хэдүүлээ зохицуулаад явъя.

Тэгээд нефтийн үйлдвэрийнхээ энэ юун дээр нэлээн анхааралтай хандаж явахгүй бол. Ер нь экспорт, импортыг дэмжих тийм банк л хэрэгтэй.

Түүнээс биш төсвөөс гадуур өргүй, бүртгэлгүй болгох асуудал байж болохгүй. Хариултаа авъя.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг хариулъя. 3 дугаар микрофон.

**С.Тулга:** Сангийн яам. С.Тулга гишүүний асуултад хариулъя.

Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр хүү төлөхгүй байгаа. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр гэдэг өөр төлбөр төлж байгаа. Үүний хувьд 2026 онд 60 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр төлнө. 2027 онд 51 тэрбум төгрөг төлөхөөр ийм тооцоотой байгаа.

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулъя. Хариултаа жоохон тодорхой хариулъя. Жоохон чанга тод хариулъя.

**С.Тулга:** Ашиглагдаагүй зээлийн үлдэгдэл дээр хүү төлөхгүй байгаа. Энэ дээр хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр гэдэг өөр тусдаа төлбөр төлж байгаа.

Энэ нь олон улсын банк, санхүүгийн байгууллага Монгол Улсад зориулаад яг энэ нөөцийг хадгалж байгаа гэдэг дээр бид ашиглахгүй байвал түүнд төлбөр төлдөг.

2026 оны хувьд энэ төлбөрийн хэмжээ 60 тэрбум байгаа. 2027 онд 51 тэрбум байна.

**С.Бямбацогт:** Ц.Даваасүрэн гишүүн тодруулж асууя.

**Ц.Даваасүрэн:** 60 тэрбум гэдэг чинь их л мөнгө л дөө. Цалин, тэтгэврээ өөрийнхөө хэмжээгээр нэмэх л мөнгө.

Тэгэхээр одоо энэ зээлээ яаж төлөх вэ гэдэг юманд хэдүүлээ анхаарахгүй болохгүй нь. Бидний экспортын орлого олох юм гэж ерөөсөө хөдөө аж ахуйн салбар л байна. Органик хүнс. Энэ чиглэл рүү анхаармаар байна. Нүүрснээс гадна.

Нөгөө нэг юм нь уул уурхайн бүтээгдэхүүнээ дахин боловсруулж гаргадаг болмоор байна. Тэгвэл арай өртөг нэмэгдэнэ, валют нэмэгдэнэ. Өөрөөр бид нэг их юм гаднаас олж чадахгүй дээ. Аялал жуулчлалаар сүртэй юм олохгүй. Манайхаас сайхан байгальтай, тэгээд дэд бүтэц татсан орнууд зөндөө байна шүү дээ.

Тийм учраас хөдөө аж ахуйн органик хүнсний үйлдвэрлэл, тэгээд уул уурхайн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах. Санхүү, банкны зээлийнхээ орчныг өөрчилье. Энэ дээр л хэдүүлээ анхааръя. Энэ хүүг бууруулахад анхаар. Тэр төрийн дарамтаас илүү энэ рүүгээ анхаар. Энэ хүү чинь өөрөө зүгээр монопол. Шулж байна шүү дээ. Энэ банкнууд чинь. Хэн яаж бизнес эрхлэх юм бэ. Бүгд өртэй, зээлтэй.

Тэгэхээр үүнийг хэдүүлээ шийдмээр байгаа юм.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Ажлын хэсэг анхааралдаа авъя.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

**Д.Рэгдэл:** Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр зээлийн ашиглалтыг сайжруулах талаар хэлэлцэж байгаа хуулийн төсөл дээр хоёрдмол байдалтай л байгаад байгаа юм.

Угаасаа бид нэгэнт авсан зээлийн ашиглалтыг бүх боломжоороо л сайжруулаад явах ёстой. Зээлийн хөрөнгө, хөрөнгө оруулалт босгох гэж байгаа юм бол сайн ашиглалттай байх боломжтой нөхцөлөөр л хөрөнгө оруулалт босгож байхгүй бол одоо ингээд төслийнхөө дундуур янз бүрийн асуудал үүсээд байгаа юм.

Байнгын хороодоор харамсалтай нь ярьсан зүйлүүд, дэвшилттэй хэсэг нь энэ хуультай зарим дэвшилттэй зүйлүүд Их Хурал дээр өөрчлөгдсөн учраас өнөөдөр нэлээн яриа хөөрөө, хэлэлцүүлгийн сэдэв үүсээд байна л даа. Жишээлбэл, энэ хуулийн хүрээнд хамрагдах 3 төслийг 2 болгоё гэдэг саналыг би 100 хувь дэмжиж байсан. Харамсалтай нь 3-аараа ороод ирсэн байна.

Төсвийн байнгын хороон дээр хамгийн чухал саналаа унагачхаад ороод ирж байгаа. Өөрөөр хэлбэл энэ чинь хэрэгжүүлэх төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх төсөл дээр иймэрхүү асуудал ярья гэсэн саналыг Төсвийн байнгын хороо унагаж байгаа юм.

Тийм учраас хөрөнгө оруулалтаа төсвийн орлогоороо нөхөж чадахгүй ийм төслүүд орж ирэх хаалгыг нээгээд байгаа юм.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг харахад тийм бөөрөнхийдүү, хоёрдмол, түдгэлзсэн шинж чанартай ийм дүгнэлт орж ирсэн. Энэ хуульд хориг тавиагүй. Дэмжээгүй. Гагцхүү улсын төсөвт нөлөөлөх нөлөөллийг багасгах талаар ажиллах хэрэгтэй гэсэн нэг ийм бөөрөнхий дүгнэлттэй ийм юм ороод ирсэн байгаа.

Зүгээр өнгөрсөн туршлагаас харахад манай улс 5 төсөвтэй явж байсныг та нарын маань олонх мэдэж байгаа байх.

Тэгээд 5 төсвөөс болоод дараа нь Засгийн газрууд нь гадаадын зээлээ төлөх гэж арваад жил үзэж тарж байж нэг ийм овоо гайгүй болоод, одоо сүүлийн 2 жил овоо цэгцтэй ороод явж байтал дахиад энэ ороод ирж байгаа юм.

Гэтэл нөгөө амьдрал баян юм чинь одоо энэ газрын тосны үйлдвэрийн асуудал, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын асуудлууд. Энэ чинь авсан зээлээ ашиглахгүй бол 10, 15 жил үргэлжлээд, ер нь ямар ч үр дүнгүй юм болох гээд байгаа учраас энэ хууль орж ирж байна гэж бодож би дотроо дэмжиж байгаа.

Зүгээр улсын төсөвт нөлөөлөх нөлөөллийг багасгах, төсвийн алдагдалд яаж тооцох, энэ бүхнийгээ хуулиараа зохицуулаад ирвэл дэмжихэд бэлэн байна.

Хоёр дахь асуудал бол энэ газрын тосны үйлдвэрийн асуудлыг би олон сонссон.

Тэгээд надад нэг л ойлгомжгүй юм яриад байдаг юм. Тамсагийн ордын нефтээр гол түүхий эдээ хийнэ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ чинь тэр сая 500 мянган тонн газрын тос боловсруулахад хүрэлцээ байхгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ ордын нүүрсийг их сайхан шингэн нүүрс байдаг. Шингэн нефть байна. Тэр хоолойгоор зөөхөд асуудал үүсэхгүй гэж дандаа хариулаад байдаг.

Гэтэл миний мэдэх, энэ талаар олон жилийн өмнө газрын тосны үйлдвэрүүд сураг ч байхгүй байхад сонсож байсан тайлангуудаас харахад энэ Тамсагийн ордын нефть зуурамтгай, амархан царцдаг энэ тайлангуудыг нь би харж байлаа. Тэр түүхий эдийг нь яагаад амархан зарж байна вэ гэдгийг нь ч нүдээр харж байсан.

Тэгэхээр үүнийг тэр хоолойгоор явуулах технологио та нар сайн боловсруулахгүй бол асар их зардлаар үүнийг хийх гээд байгаа юм шүү.

Тэгээд энэ тал дээр ер нь ямар шинэчлэл, дэвшилттэй юм хийх гэж байгааг би одоо хүртэл сонсоогүй байгаа.

Тэгээд энэ тал дээр нэг хариулт өгвөл зүгээр байна.

Хоёрдугаарт, ер нь зүгээр бид газрын тосныхоо хэрэгцээний тодорхой хэмжээг дотоодоосоо хангах, гадаадаас авч байгаа эрчим хүчээ багасгах тал дээрээ 2 төслийг дэмжиж... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. Н.Наранбаатар. Төсвийн байнгын хороон дарга хариульъя. Нанзадын Наранбаатар.

**Н.Наранбаатар:** Эхний хэсгийг нь би. Тэгээд дараагийн хэсгийг нь ажлын хэсэг үйлдвэртэй холбоотой.

Хууль санаачилсан гишүүд 3 төслийг оруулж ирсэн. Сэлбэтэй хамт.

Ингээд ажлын хэсэг дээр Сэлбэ хасагдаад Байнгын хороон дээр орж ирсэн. Байнгын хороо дэмжээд хассан. Ингээд 2 төсөл. Эхний 2.

Эрдэнэбүрэн, нефтийн үйлдвэр 2 Байнгын хороон дээр дэмжигдээд ингээд чуулган дээр орсон. Харамсалтай нь чуулган дээр буцаагаад босгосон. Байнгын хороон дээр хассан Сэлбийг чуулган дээр босгосон.

Тийм учраас Байнгын хороон дээр үүнийг босгосон гээд түрүүн гишүүдийн асуултад дурдагдаж байсан учраас бас энэ дээр тодруулъя.

Чуулган дээр босгосон асуудал байгаа шүү гэдгийг.

Хоёр дахь асуудал нь, Тогтвортой байдлын зөвлөлөөс ирсэн дүгнэлтийг би яг нэг өгүүлбэрийг нь тодорхой уншаад өгье. Ер нь дэмжээгүй. Ингэж бичсэн байгаа.

Энэхүү хууль батлагдвал төсвийн тогтолцоо, эрх зүйн орчинд томоохон сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд хоёр төсөвтэй болох, төсвийн алдагдлыг Тогтвортой байдлын тухай хуулийн хүрээний хязгаарлалтаас гаргах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бодлогын ач холбогдлыг сулруулах зэрэг үр дагавар гарахаар байна гэсэн. Үндсэндээ дэмжээгүй гэсэн дүгнэлт ирсэн.

Тэгээд ажлын хэсэг үйлдвэртэй холбоотой асуудал дээр хариулт өгье.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. 3 дугаар микрофон хариулъя.

Энэ асуудлыг 60 минутад хэлэлцэж дуусгах ёстой байсан. Амжихгүй байгаа учраас дахиад сунгалаа. 30 минут. /алх цохив/

**Ч.Чулуунбат:** Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Ашигт малтмал, газрын тосны газар. Ч.Чулуунбат байна.

2010-2012 оны хооронд Тамсаг, Тосон-Уул, Зүүнбаян, Цагаан-Элсний орд газрын газрын тосны нөөцийг Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр баталгаат нөөцийг 335.0 сая тонноор. Үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 43.6 сая тонноор хүлээж авсан байгаа.

2014 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжөөр дотоодод газрын тосны боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эд дээр тулгуурлан барих нь зүйтэй гэсэн зөвлөмж гарсан.

Энэ зөвлөмж болон дотоодоос олборлох газрын тосны орд ашиглах төлөвлөгөө дээр үндэслэн газрын тосны боловсруулах үйлдвэрийг жилийн хүчин чадлыг 1.5 сая тонноор тооцсон.

Дээрх орд газруудын орд ашиглах төлөвлөгөө нь 2017 оноос эхлэн олборлолтын хэмжээ 1.4-өөр... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Хариултаа дуусгая. Сунгая.

**Ч.Чулуунбат:** 2016 оноос эхлэн олборлолтын хэмжээ нь дээрх нэр бүхий 4 ордоос 1.4-өөс 1.6 сая тонн хүртэл газрын тос олборлохоор орд ашиглах хөдөлгөөнд тусгасан боловч 2017 оноос авхуулан олборлолтын хэмжээ маань харамсалтайгаар буурсан байгаа.

Сүүлийн 2020-2025 оны хооронд дунджаар 500 гаруй мянган тонн газрын тос олборлож экспортолсон.

Энэ онд бид дээрх ордуудаас 419 сая тонн газрын тос олборлож экспортлохоор төлөвлөж байна.

Орд ашиглах төлөвлөгөөний дагуу олборлолтын хэмжээ буурсан үндсэн шалтгаан нь—

- ◆ бүтээгдэхүүн хуваах гэрээ,
- ◆ Монгол Улсын хууль тогтоомжуудын хоорондын зөрчил;
- ◆ татварын маргаанууд;
- ◆ тосны үнийн уналт;
- ◆ эрчим хүчний дутагдал;
- ◆ 2020, 2021 онууд болсонд ковид цар тахлын асуудал;
- ◆ орон нутгийн эсэргүүцэл —

-зэрэг асуудлуудаас болж тухайн орд ашиглах төлөвлөгөө... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Хариулт хангалттай юу? Д.Рэгдэл гишүүн тодруулж асууя.

**Д.Рэгдэл:** Нефть олборлолтын түвшин буураад байгаа дээрээ нэлээн сайн дүгнэлт хиймээр юм шиг байгаа юм. Тийм ээ. Тэр газрын доорх нефть нь тийм бага гарчхаад байна уу? Яагаад байна? Өөр ойр хавьд нь ямар эх үүсвэр байж болох юм? Энэ талаар судалгаа хийж байгаа гэж би сонссон.

Зүгээр тэр 600 шахам километр урт замд хоолойгоор тээвэрлэхэд их энэ царцамхай, зурамтгай нүүрсийг хялбархан явуулах ямар технологи та нар маань олчихоод байгаа юм гэдгийг би ерөөсөө сонсохгүй байгаа.

Технологийнхоо талаар Их Хурлын гишүүдэд товчхон яриад өгвөл зүгээр байна.

**С.Бямбацогт:** 3 дугаар микрофон. Ажлын хэсэг хариулъя.

**Д.Алтанцэцэг:** Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Д.Алтанцэцэг. Газрын тос боловсруулах үйлдвэрийн захирал.

Газрын тосыг шинж чанарын хувьд 3 гол үзүүлэлтээр хэмжиж байгаа. Түүгээр үнэ цэнийг нь тодорхойлдог.

- ◆ Нэг нь, - нягт.
- ◆ Хоёр дахь нь, - хүхрийн хэмжээ.
- ◆ Гурав дахь нь, - хүнд металлын агуулга.

Манай газрын тос нягтаараа олон улсын “Эй Пи Ай” (API gravity, American Petroleum Institute)<sup>1</sup> гэж ярьдаг. Олон улсын нягтын хэмжүүрээрээ “хөнгөн” тосны категорид багтдаг.

“Brent”<sup>2</sup> тос болоод “West Texas Intermediate”<sup>3</sup> хоёр бол 37 гээд энэ тоо их байх тусмаа “хөнгөн” гэсэн үг.

Манайх 33-аас 34 байдаг. Оросын Холбооны Улс, арабын тоснууд 25-аас 30-ийн хооронд хэлбэлзэж байгаа.

Тэгэхээр манай тос шинж чанарын хувьд хөнгөн, сайн тосонд хамаарагдана.

Хүхрийн агуулгаараа Монголын тос шиг бага хүхэртэй тос дэлхийд өөр байхгүй.

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулъя. 3 дугаар микрофон.

**Д.Алтанцэцэг:** 0.11 хувийн хүхрийн агуулгатай.

Энэ бол бусад газрын тос дунджаар 1-ээс 2 хувийн хүхрийн агуулгатай байдаг бол манайх ийм бага хүхрийн агуулгатай, цэвэр, хөнгөвтөр тосонд хамаарна.

<sup>1</sup> American Petroleum Institute-ийн API gravity буюу нягтын хэмжүүр.

<sup>2</sup> Brent crude oil (Brent) Их Британи, Норвеги. Benchmark үнийн стандарт.

<sup>3</sup> West Texas Intermediate (WTI) АНУ-ын Техас. Benchmark үнийн стандарт.

Энэ тосыг хүнд юм шиг харагдуулж байгаа зүйл бол тосны химийн шинж чанар буюу парафиник (wax/paraffin) зууралданги (viscous) чанар өндөртэй тос. Энэ бол зөвхөн талст үүсэх буюу тос царцах температур нь өндөр болохоор ингэж харагддаг.

Гэтэл температур өгөхөөр шингэн ус мэт болдог. Ялангуяа манай Тамсгийн сав газрын тос.

Тэгэхээр 520 километр урт шугам хоолойгоор дамжуулахад завсрын 4 халаах, өргөх насос станцтай. Зундаа зарим станцыг алгасна. Яагаад гэвэл газрын хөрсний температур нэмэх рүү орж байгаа учраас.

Өвлийн улиралд 2.8-аас 3 метрийн гүнд ойролцоогоор 0-ээс 4 хэмийн дулаантай учраас... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Д.Рэгдэл гишүүн тодруулж нэмэлт асуулт.

**Д.Рэгдэл:** Манай газрын тосны үзүүлэлтүүдийг би бас олон жилийн өмнөөс л харж л байсан л даа.

Тэгэхээр зэрэг шингэн, хөнгөн сайн тос л гээд байгаа.

- Яагаад энэ тос чинь ийм царцамтгай байдаг юм?
- Зуурамтгай чанар яагаад өндөр байдаг юм?

Би монгол эрдэмтдийн хийсэн тоонууд дээр яриад байгаа юм шүү. Цээжээрээ хэлж байгаа юм биш.

Тэгэхээр царцамтгай, Тамсагийн ордын нефть тасалгааны температурт царцах гээд байдаг. Ер нь 20 градусаас доошоо орохоор.

Тэгэхээр одоо яах вэ, нам газраас дээш нь өргөөд шахахад мэдээж шахдаг станцууд ойлгомжтой. Хийж таараа. Царцамхай чанарыг нь багасгахын тулд. Царцах юм бол тэр чинь явахгүй. Ямар ажил хийж байгаа бол?

Зүгээр царцамхай температурыг нь өндөр болгоё гээд дандаа тэр хоолой даяараа цахилгаанаар халаагаад явуулаад байж болохгүй л баймаар байгаа юм л даа. Энэ дээр нэг тодорхой хариулья.

**С.Бямбацогт:** Хариулья. 3 дугаар микрофон.

**Д.Алтанцэцэг:** Д.Рэгдэл гишүүний асуултад хариулья.

Д.Алтанцэцэг. Газрын тос боловсруулах үйлдвэр.

- Нэг нь, –физикийн шинж чанар.
- Нөгөөдөх нь, –химийн шинж чанар.

Хүнд гэж харагдуулж байгаа нь физик шинж чанар, нягттай холбоотой.

Таны асууж байгаа зууралданги чанар гэдэг бол газрын тосыг дотор нь наптеник (**naphthenic crude oil**) төрлийн, парафиник (**paraffinic crude oil**) төрлийн гэж байгаа.

- ➔ Парафиникийн төрөл нь шулуун хэлхээтэй (straight-chain) өндөр молекулуудын агуулга өндөр гэсэн үг. Нүүрс ус төрөгчийн бүлэг.
- ➔ Наптеник гэдэг нь цагаригт нүүрс ус төрөгчийн.

Тэгэхээр манайх бол парафинлаг тосны шинж чанартай тосонд хамаарна. Энэ тосны гүн боловсруулалтад орох чадвар өндөр. Дээрээс нь зөвхөн температурын ялгаагаар урсах чадвар нэмэгдэнэ.

Одоо баригдаж байгаа газрын тос боловсруулах үйлдвэр гүн боловсруулалтын технологитой. Орчин үеийн өндөр техник, технологиор тоноглогдсон хамгийн сүүлийн үеийн стандарт нормд тохирсон шатахуун үйлдвэрлэх ийм үйлдвэр байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг чуулганы хуралдаанд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээнэ гэдгийг маш сайн бодож асуултад хариулж, мэдээлэл өгч байх ёстой шүү гэдгийг сануулъя.

Ринчиндоржийн Батболд гишүүн асуултаа асууя.

**Р.Батболд:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Гадаадын зээллэгтэй холбоотой энэ хуулийг уг нь дэмжээд байгаа юм.

Тэгээд дэмжээд явахаар хэрэгжүүлэх шаардлагатай газрын тосны үйлдвэр, Эрдэнэбүрэний цахилгаан станц гэсэн ийм 2 том төслөө дагуулаад “Сэлбэ дэд төв” гээд нийслэлийн нэг хулгайн төсөв оруулж ирчхээд зүтгүүлээд байгаа.

Ер нь яах вэ “Сэлбэ дэд төв”-ийн төслийг яагаад энэ хуулиар оруулахыг эсэргүүцээд байгаа юм бэ гээд. Энэ дээрээ нэг ганц хоёр үг хэлье.

Монгол Улс нэг төсөвтэй нэг улс. Тэгэхээр нийслэл бонд босгох болон зарцуулалтаа тооцохдоо төсвийн бодлоготойгоо уяагүй.

Тэгэхээр давхар дээлтэй яваад байгаа нийслэл гэж нэг том улс бий болсон.

Одоо тэгээд хамаагүй бонд босгож, мөнгө босгочоод үүнийгээ хуулиар хамгаалаад, хэрэглэх гээд гишүүдийг лоббидоод яваад байгаа.

Хоёрдугаарт, “Сэлбэ дэд төв”-ийн бүтээн байгуулалтын барилга, орон сууцын өртөг нь маш өндөр.

2024 онд бид хэсэг гишүүд гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдтэй танилцаад явсан. Тухайн үедээ хэлж байсан. Газрын үнэ, дэд бүтцийн үнэ орохгүйгээр 3.8 сая төгрөгийн өртөгтэй болдог юм бэ гэдгийг асуугаад байсан. Энэ дээр тайлбар хэлээгүй.

Тухайн үед 2024 онд Нисэх, Яармагийн ойролцоогоор орон сууцын барилгууд 2.6 сая төгрөгийн тийм борлуулалтын үнэтэй байсан шүү. Борлуулалтын үнэ. Өртөг биш. Одоогийн байдлаар ийм болсон байна.

2025 онд улсын комиссоор орсон. Барилгын үнэ 2025 ондоо 3 сая төгрөгөөр зарж байсан бол одоо 2026 он гараад 3.5 сая төгрөг болгосон байна.

Тэгэхээр төр өөрөө бизнест оролцоод, тэгээд орон сууцын үнийг ерөөсөө механикаар өсгөөд байгаа ийм үйлдэл яваад байгаа юм.

Тэгэхээр үүнийг хүлээн зөвшөөрөх юм уу, үгүй юу? Яаж тооцох юм гэдэг ийм асуудал.

Гуравдугаарт нь, төр бизнесийн үйл ажиллагаанд ерөөсөө шууд оролцоод байгаа. Хувийн бизнесийг дэмжихгүй байгаа. Маш томоор багцлаад Монгол Улсын аж ахуйн нэгжүүд хийх боломжтой ажлуудыг гаднын компанид өгч байгаа. Энд авлига, албан тушаалын хэрэг явж байгаа болов уу гэсэн ийм хардлага төрөөд байгаа юм.

Зүгээр нэг жишээ хэлье. Том багцуудыг гаднын компанитай 1 метр квадратыг нь 2.5 сая төгрөгөөр бариулахаар гэрээлсэн гэж байгаа. Нөгөө компаниуд нь манай дотоодын аж ахуйн нэгжүүдтэй 2.2 сая төгрөгөөр бариулахаар ингээд бас давхар туслан гүйцэтгэгчийн гэрээ хийж байгаа гэсэн ийм мэдээ байгаа.

Тэгэхээр зүгээр 8500 айлын орон сууц, түүн дээрээ дундаж квадрат нь 61 метр квадрат гээд 2.5 сая, 2.2 саяын зөрүү, 300 мянган төгрөгийн зөрүүгээр тооцоод үзэх юм бол энд ерөөсөө дундаас нь зүв зүгээр 155.5 тэрбум төгрөг гарч ирж байгаа юм. Үүнийг бодвол хувааж идэцгээж байгаа байх гэж бодож байна.

1 минутаа шууд авч болно. Тийм ээ. 1 минутыг нэмээд.

Тэгээд энэ бонд маань өөрөө ирэх жилээс төлөгдөх ёстой. 2027 оноос.

Тэгэхээр одоо 8500 айл 199 саяас 456 сая төгрөгийг шууд бэлэн төлөөд энэ бондын эргэн төлөлтийг хийж чадах юм уу гэдэг асуудал үүсэж байгаа юм.

Тэгэхээр ирэх жил бараг төсөв дээр дарамт болоод орж ирнэ дээ. Энэ дээр нийслэлийнхэн юу гэж хариулах юм. Борлуулалтаа яг яаж хийх гэж байгаа улсууд байгаа юм. Үүнийг тайлбарлаж өгмөөр байна.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. 4 дүгээр микрофон. Т.Даваадалай дарга хариулъя.

**Т.Даваадалай:** Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Засаг дарга нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Сэлбийн 500 сая ам.долларын өрийн асуудал дээр эргээд яах вэ танд Монгол Улс нэгдсэн төсвийн бодлоготой учраас бид Их Хурал, Засгийн газар баталгаа аваад орж батлуулаад Сэлбэ дээр бондын мөнгийг босгож зарцуулсан байгаа.

Би түрүүн хэлсэн манай “Сэлбэ 20 минутын хот” корпорац бид зах зээлийн төлөвлөгөөгөө улирал болгон шинэчилж тооцоолол хийж байгаа. Бид зах зээлийн үнэлэлтээр тооцоолол хийгээд үзэхэд Дөлгөөн нуур орчим 3 сая 700-гаар 1 метр квадрат хотын төвөөс 1 километрт байрны үнэ байна гээд зах зээлийн тооцоог бүрэн хийж үзээд 2026 онд шинэ орон сууцын дундаж үнэ 5.1-ээс 5.3 сая төгрөг метр квадрат нь, хуучин орон сууцын үнэ 5.2-оос 5.4 байхаар судалгаа гарсан.

Тэгээд бид 4 сая 800 мянга байхаар дундаж метр квадратыг одоогийн байдлаар тооцоолоод байгаа.

Тэгэхдээ Улаанбаатар хотын магадлагдсан үнэ 2 сая 470 мянгаар Барилга хөгжлийн төв дээр магадлагдсан. Сэлбэ 20 минутын хот нь өөрөө 158 га дээр 48 багц ажил дээр сургууль, цэцэрлэг, нийгмийн дэд бүтэц, гадна тохижилт гээд хүндээ ээлтэй 20 минутын хот концептын хүрээнд хэрэгжиж байгаа хот учраас бусад төв магистрал гадна тохижилт дээр их зардал орж байгаа гэж ойлгож болно.

Ийм хот учраас бид бусад зах зээлийн ханшаар борлогдож байгаа юунуудтай харьцуулахад яах вэ 1 метр квадрат дээр ногдож байгаа зардал өндөр байгаа.

Тэгэхдээ борлуулалтын үнийн хувьд алдагдалгүй тусгахаар тооцоологдсон. 500 сая доллароос одоогоор 330 тэрбум нь зарлага болж гарсан байна.

Бид ирэх жил 2027 онд 100 сая долларыг эргэж төлөөд 400 сая доллар дээр нь REFINANCE буюу дахиж урт хугацаанд зээл авч явахаар төлөвлөж байгаа.

Одоогийн байдлаар бид Нийслэлийн орон сууцын корпорац дээр орон сууц борлуулах ипотекийн журам боловсруулж байгаа. Одоогийн байдлаар бид ер нь 8 хувийн зээлтэй 20 жилийн хугацаанд төрийн албан хаагчдадаа болон жирийн иргэдэд зориулсан нэн хөнгөлөлттэй байдлаар ипотекийн зээл өгөхөөр судлагдаад ажлын хэсэг дээр явж байгаа гэдгийг танилцуулъя. Баярлалаа танд.

**С.Бямбацогт:** Р.Батболд гишүүн тодруулж асууя.

**Р.Батболд:** Нийслэл ингээд худлаа яриад байгаа юм л даа.

Яахаараа төрийн хийж байгаа ажил нь яахаараа зүгээр бизнесийн явж байгаа үйл явдлаас, өртгөөс нь өндөр болоод байдаг юм бэ. Аягүй бол нийслэл яасан байгаа даа, гаднаас орж ирж байгаа, урдаас орж ирж байгаа бараа, материал, түүхий эдийнх нь гааль, аягүй бол худалдааны татварыг нь тэглэсэн байгаа даа.

Орж ирж байгаа гадаад ажилчдын татварыг хөнгөлсөн явж байгаа даа. Аягүй бол. Энэ дээр хариулт өгөөрэй. Тийм юм байна уу, байхгүй юу?

Хувийн аж ахуйн нэгжүүд чинь зээлээ аваад, түүнийхээ хүүг төлөөд, газрын үнэ төлөөд, тэгээд дэд бүтцээ татаад ингээд барилгаа бариад явж байгаа ийм газрууд байгаа шүү.

Тэгэхээр тэрнээс өндөр өртөгтэй гараад байгаа юм гэдэг тайлбар чинь өөрөө ерөөсөө маш буруу зүйл болоод байна.

Тэгэхээр энэ дээр нийслэл. Энэ бондоо эргүүлээд ирэх жилээс шууд төлж чадах юм уу, үгүй юу? Энэ дээрээ хариултаа хэлчих.

**С.Бямбацогт:** Бодитой, үнэн зөв мэдээлэл өгөх ёстой. Ажлын хэсэг үүнийг онцгой анхаараарай.

**Т.Даваадалай:** Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Сэлбэ 20 минутын хотыг ерөнхийдөө анхны жишиг хот болох зорилгоор иргэндээ ээлтэй, хүртээмжтэй, явган алхах боломжтой буюу **"Walkable City"** 20 минутын дотор хүрэх боломжтой хотыг хийх зорилгоор анхны удаа төр менежментийг нь Нийслэлээс хийж байгаа. Дахиж нийслэл орон сууцын төсөл рүү орохгүй. Жишиг 20 минутын анхны хот болгож иргэндээ ээлтэй хот болох зорилгоор төслийг эхлүүлж, ТЭЗҮ бичиж хөрөнгө оруулалтыг татсан.

500 сая доллароос одоогоор 330 тэрбум буюу ойролцоогоор 100 сая доллар хүрэхгүй орчим нь одоогоор гүйцэтгэлд зарцуулагдсан байж байгаа.

Ирэх жил бид 100 сая доллароо буцаж төлөөд үлдсэн 400 сая доллар дээр нь REFINANCE буюу дахин зээлийг сунгаж явахаар төлөвлөөд хөрөнгө оруулагчдаа яриа хэлэлцээрийг эхлүүлсэн. Боломжтой байгаа.

Ер нь одоогийн байдлаар хүү болон... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Хариултаа дуусгая. 4 дүгээр микрофон.

**Т.Даваадалай:** Хүү болон ханшийн алдагдлаа тооцоод нийслэл 54 тэрбумын ашигтай явж байгаа.

Ер нь зээлийн эргэн төлөлт дээр ямар нэгэн эрсдэл байхгүй гэж бүрэн харж байгаа ийм зураглалтай явж байгаа.

Мэдээж Сэлбэ 20 минутын хот гээд хувийн хэвшил дээр хийж байгаа учраас бид бизнесийн зарчмаар нь бизнесийн төлөвлөгөөг улирал болгон шинэчилж явж байгаа учраас зарим борлуулалтын үнэ метр квадратын үнэ өөрчлөгдөж байгаа ийм тоо хэмжээсүүд байгаа.

Тэгээд хувийн хэвшлүүдээ гүйцэтгэж байгаа. Нийслэлээс зөвхөн менежментийг хийж байгаа гэж хэлье байгаа. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Р.Батболд гишүүн нэмж асууя.

Уучлаарай. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Нийслэлийн ерөнхий Боловсролын 37 дугаар сургуулийн 12-ын “в” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхний амьдралын нэгэн гэгээн хуудсаа хааж тун удахгүй аав, ээжийнхээ гэрээс гарч хүссэн мэргэжлээр хүссэн сургуульдаа суралцана.

Тэгээд улс эх орондоо хэрэгтэй, эрдэм мэдлэгтэй сайн хүн болоорой гэж Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Манай Ц.Баатархүү гишүүн бүр онцлоод байна шүү. Тийм.

Ринчиндоржийн Батболд гишүүн тодруулж асууя.

**Р.Батболд:** Ингээд тойруулж яриад ерөөсөө шууд хариулаад өгөхгүй юм.

Та нар энэ төслийг хэрэгжүүлэхдээ янз бүрийн татварын хөнгөлөлт энэ байгууллага, компаниуддаа үзүүлээд байгаа юм уу, үзүүлэхгүй байгаа юм уу гэдгээ нэгдүгээрт хэлмээр байна

Хоёрдугаарт, яг бондынхоо төлбөрийг ирэх жил төлж чадах юм уу, чадахгүй юм уу? Refinance хийгээд байгаа гээд байх юм. Тэгээд хүү нь ямар болж байгаа юм. Үүнийгээ нэг шууд хэлмээр байх юм. Та нар дээр яаж явуулаад байгаа чинь ч хамаа алга л даа. Тойруулаад яриад байх юм.

**С.Бямбацогт:** Хариулт хангалтгүй гэж үзэж байна. Хариулъя. 4 дүгээр микрофон.

**Т.Даваадалай:** Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай. Бид татварын хөнгөлөлт одоогоор эдэлж байгаа зүйл байхгүй.

Өрийн тухай хуулиараа уг нь татварын хөнгөлөлт эдлэх ёстой юм билээ гэж би ойлголоо. Манай хуульчид болон санхүүгээс зөвлөж байгаагаар.

Эргэн төлөлтийн хувьд эрсдэл байхгүй. Бид яг 500 сая долларыг авсан. 2027 оны 7 дугаар сард эргэн төлөх ёстой. 100 сая долларыг эргэн төлөлтийг хийнэ. 400 сая доллар дээр дахин санхүүжүүлэх талтай хэлэлцээр хийгээд дахин зээлийг сунгаж явахаар төлөвлөж төлөвлөлтийг хийж ажиллаж байгаа.

**С.Бямбацогт:** Р.Батболд гишүүнд бичгээр нэмээд хариултуудаа гүйцээгээд өгөөрэй.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна.

Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалан.** Манай улсад төсөвтэй холбоотой нэлээн олон хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа.

Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль гэх мэтчилэн.

Суурь зарчмуудаа уг нь бид өнгөрсөн 36 жилийн туршид нэлээн сайн тодорхойлсон.

Гэхдээ жил ирэх тусам улам дордоод л байх юм. Одоо энэ хууль ингэж орж ирснээрээ төсөвтэй холбоотой хууль эрх зүйн орчныг гажуудуулж, төсвийн зарчмуудыг гажуудуулж, төсөвт тавигдах тусгай шаардлагуудыг гажуудуулж, ер нь нийт тогтолцоогоо л нурааж байгаа ийм хууль болоод байгаа юм л даа.

Тэгээд гишүүдийн хэлээд байгаагаар ингэж зарим төслүүдийг төсвийн гадна гаргаснаар тэр хоёр төсөвтэй болох гээд байгаа нь гэдэг нь үнэн. Төсвийн нэгдмэл байдлын зарчим алдагдана.

Тэгээд ер нь яахаараа тодорхой төслүүдэд зориулсан тухайлсан хууль батлах гээд байгаа юм бэ гэдгийг ч ойлгохгүй байгаа юм. Яагаад вэ гэхээр хууль чинь ерөнхий харилцааг зохицуулах ёстой шүү дээ.

Гэтэл бүр тодорхой төслүүдийн нэр зааж байгаад тэдгээр төслүүдэд зориулсан хууль батлах гээд байгаа юм.

Тэгээд үүнийг тэгвэл юу гэж хардаж байна вэ гэхээр дараа нь энэ төслүүдийг хэрэгжүүлж байгаа тэр нийслэл нь байдаг санж уу, Засгийн газар нь байдаг санж уу эргээд Их Хурал руу заана.

Тэгээд Их Хурлаар ийм хууль баталчхаа биз дээ. Бид буруугүй. Энэ хамтын шийдвэр байсан.

Тэгээд өнгөрсөн хугацаанд ийм зарчимгүй байдлаар Улсын Их Хурлыг ингэж ашиглах явдал газар авч байна. Бид үүнийг хүлээн зөвшөөрч болохгүй.

Ер нь өнгөрсөн хугацаанд, сүүлийн 10 жилд төсвөөс гадуурх төсөл, хөтөлбөрийн санхүүжилт бүр хэрээс хэтэрсэн шүү дээ. Наад зах нь нефтийн үйлдвэртэй холбогдуулж яригдаж байгаа тэр хоолойны санхүүжилт байж байгаа. Бас л урд хөршийн “Nogenco” гэдэг компаниар нүүрсээр санхүүжиж байгаа тийм давхар юм явж байна. Энэ төрийн өмчит компаниудын бүр хөрөнгө оруулалт хийдэг хэрэгсэл болсон энэ байдлыг бас таслан зогсоох ёстой гэж бодож байгаа.

Гэтэл тэр асуудлаа яая гэж байхад давхар ийм гуравхан төслийг онцлоод ийм хууль оруулаад ирж байгаа юм.

Энэ Сэлбэ дэд төв гэдэг зүйлийг ерөөсөө ойлгохгүй байгаа юм. Яахаараа нийслэл хот бүр барилгын төсөл санхүүжүүлээд, тэгээд барилгын төсөл хэрэгжүүлээд, тендер зарлаад яваад байгааг ерөөсөө огтхон ч ойлгохгүй байгаа юм.

Тэгээд сая яригдаад байна л даа. Тендерүүд нь аль хэдийн зарлагдаад тэгээд тодорхой компаниуд шалгарсан гэж байгаа. Энэ тендерийнхээ процессыг нийслэлийн удирдлага нэг тайлбарлаж өгнө үү гэж хүсье.

Тэгээд дээрээс нь нийслэлийн нэгдүгээр орлогч дарга Т.Даваадалай тантай холбогдоод байгаа танай эхнэрийн компани бас энэ нийслэлийн тендерт шалгарсан асуудлаа чуулганы нэгдсэн хуралдаан дээр тодорхой тайлбарлаж өгнө үү гэж хүсье.

Төгсгөлд нь бид нэгэнт төсвийн зарчмуудыг эвдсэн, гажуудуулсан ийм хуулийн төсөл хэлэлцэж байхад шинээр Сангийн сайдаар томилогдсон хүн маань хаана байна.

З.Мэндсайхан сайдаас энэ асуудал дээр яг өөрөө ямар байр суурьтай байгаа юм. Цаашид ер нь төсвийн бодлогоо яаж барьж явна гэж бодож байгаа юм гэдгийг нь асуумаар байх юм. Яагаад гэхээр ийм чухал өөртэй нь холбоотой асуудал хэлэлцэж байхад танхимд ч орж ирдэггүй. Өөрийнхөө тэр бодлого шийдвэрийг тайлбарладаггүй. Тэгээд Сангийн яамны нэг хэдэн газрын дарга нарыг суулгаад ингээд улалзуулаад байж байдаг байдал байж болохгүй гэж бодож байна.

Тэгэхээр хурлын дарга Сангийн сайдыг дуудвал яасан юм.

**С.Бямбацогт:** Сангийн сайд З.Мэндсайханыг танхимд урьж байна. Гишүүдийн асуултад хариулъя.

Тэр болтол Т.Даваадалай дарга хариулж байх уу. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

**Т.Даваадалай:** Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай. Мөн хариулах боломж олдсонд танд баярлалаа.

Манай гэр бүлийн хүний холбогдолтой нийслэлээс тендер авсан ямар ч тийм асуудал байхгүй. Үүнийг Улсын Их Хурлын чуулган дээр хариуцлагатай хэлье.

Энэ талаар зохих нэр хүндэд халдсан асуудлууд дээр хуулийн байгууллагуудад гомдлоо гаргасан байгаа. Бусад холбогдол дээр өөрөө манлайлаад шалгуулаад явахад бэлэн гэж хэлье. Асууж хариулах боломж олгосон Б.Жаргалан гишүүнд баярлалаа.

Сэлбэ хотын төслийн хувьд гэвэл нийслэл анх удаа 20 минутын хот гээд хүндээ хэлтэй ийм хот барих зорилгоор ТЭЗҮ босгоод эхлүүлсэн. Үүнийг Та бүхэн зөвөөр ойлгоорой гэж хэлье.

Цахилгаан станцын хэмжилтээр зөвхөн тэр бүс нутагт 2100-аад нэгж талбар чөлөөлснөөр –

- ◆ 21 хувиар агаарын бохирдол бүүрсан байсан.
- ◆ Улаанбаатар хотын хэмжээнд 7 хувийн агаарын бохирдол дээр нөлөөлнө.
- ◆ 2000 нүхэн жорлон хөрсний бохирдол, агаарын бохирдлоос сэргийлнэ.

Дээрээс нь хүүхдэдээ, хүндээ ээлтэй 20 минутад жоохон хүүхдүүд алхаж хүрэх боломжтойтой, 5 цэцэрлэгтэй, 3 олон улсын сургуультай, тэгээд үйлчилгээний төвтэй хүндээ ээлтэй олон улсын “20 минутын хот” гэдэг концептын дагуу иргэндээ ээлтэй хот байгуулахаар төлөвлөж байгаа учраас анх удаа нийслэл энэ дээр менежментийн хувьд оролцсон.

Барилга, байгууламж нь нийт 11 том давуу талтай буюу хамгийн наад захаар хэлэхэд металл фасад, зэс шугам хоолой зэрэг. Зэс шугам хоолой нь жишээлбэл хүний эрүүл мэндэд урт хугацаандаа маш эерэг нөлөөтэй байдаг.

Ийм учраас монгол хүний Улаанбаатарчуудын амьдралын чанар, Улаанбаатарт хамгийн анхны удаа хүндээ ээлтэй, хүртээмжтэй, нэг хүнд ногдох ногоон эдэлбэр талбай ихтэй ийм “20 минутын хот”-ыг байгуулахаар бид төлөвлөж ажил төслийг эхлүүлсэн.

Өнгөрсөн жилийн 2025 оны 5, 9 дүгээр сард дээр нийт 7 багц ажил дээр 1.8 их наяд дээр 7 компани Монгол Улсын хуульд заасны дагуу тендерийн процессын дагуу шалгарч ажил эхэлсэн.

Мөн бусад инженерийн дэд бүтцүүдийг худалдан авалтын 10.8-ыг үндэслэн инженерингийн нийслэлийн харьяа бусад байгууллагуудаар зарим ажлуудыг захирамжилж шилжүүлж байгаа. Энд –

- **шугам хоолойг** Ус, сувгийн удирдах газар,
- **гадна тохижилтыг** Улаанбаатар тохижилт, үерийн байгууламжийг Геодези, усны барилга, байгууламж–

-гэх мэт төрийн зарим инженерийн байгууламжуудад. Гадна тохижилт төв магистралын ажлуудыг шилжүүлэлт хийж байгаа. Нийт 48 багцад хуваарилагдаж байгаа. 158 га дээр 3, 4 дүгээр хорооллыг бүтэн хоёр нугалахаар хотыг бүтээн байгуулж Монгол Улсад Улаанбаатар хотод анх хүндээ ээлтэй хотыг байгуулж байгааг дуулгахад таатай байна. Баярлалаа танд.

**С.Бямбацогт:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатын урилгаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн 12-ын “а” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Одоо Анагаахын их сургуульд сурч эмч болох гээд сонголтоо хийсэн Та нартаа, дүү нартаа хүн ардынхаа эрүүл энхийн манаанд зогссон сайн эмч болохыг хүсье. Анагаахын сургуульдаа элсэж орохыг хүсье.

Нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилт, амьдралд нь аз жаргал эрүүл энхийг хүсье. /алга ташив/

Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

**3.Мэндсайхан:** Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Үүдэнд ярилцлага өгөөд хоцроод ороод ирлээ шүү. Уучлаарай.

Энэ хоёр төсөвтэй болох асуудал огт биш байгаа юм.

Төсөв бол төсвийн орлогоо бүрдүүлээд тэр орлогоороо төсвийн зардлаа санхүүжүүлээд явна. Төсөв талдаа орлого хэлбэрээр бүртгэдэггүй. Энэ чинь санхүүжилтийн эх үүсвэр.

Тэгэхээр бид санхүүжилтийн эх үүсвэрээ хугацаанд нь ашиглах байдлаар л гишүүд маань санаачилж оруулж ирж байгаа. Төсвийн хязгаартаа бид 1.2 их наядыг энэ жил нийтдээ 76 төсөл, хөтөлбөр дээр ашигла гэдэг ийм төсвийн хязгаарт суулгаж өгсөн байгаа.

Энэ хоёр төслийн энэ жилийн санхүүжих шаардлагатай дүн нь 1.8 их наяд байгаа.

Ингэхээр энэ хоёр хэрвээ энэ хууль дэмжигдээд төсвийн хязгаараасаа гараад явах юм бол үлдсэн 1.2 дээр бусад зээлээр хэрэгжиж байгаа 74 төсөл, хөтөлбөр хэрэгжээд явах энэ боломж нь л бүрдэх юм.

Түүнээс биш өрийн таазад нөлөөлөхгүй. Хоёр төсөвтэй болно гэсэн ойлголт байхгүй гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** Батбаярын Жаргалан гишүүн тодруулж асууя.

**Б.Жаргалан:** Шинэ Сангийн сайд маань төсвийн хязгаараас гаргах явдлыг дэмжиж байгаа гэж ойлголоо.

Хотын удирдлагын асуудал дээр энэ “Сэлбэ дэд төв” гээд энэ төсөл ноднингийн төсөвт 500 гаруй тэрбум төгрөгөөр газар чөлөөлсөн байдаг.

Тэгээд одоо энэ барилгынх нь ажил нь 1.7, 1.8 их наяд төгрөг. Тэгээд нийтдээ ер нь ахиад л 2.3 их наяд төгрөгийн өртөгтэй төсөл болж байна.

Тэгэхээр нийслэл дээр ирж байгаа төслүүд чинь ерөөсөө 2-оос 3 их наядаар байдаг бүр ийм жишиг тогтлоо л доо.

Тэгээд дандаа өндөр өртөгтэй, тэгээд дандаа үр өгөөж нь тодорхойгүй, дандаа үндсэн зарчмуудаа эвдсэн төслүүдийг л нийслэл зүтгүүлээд байдаг боллоо.

Тэгээд цаашид бид ийм байдлаар явах юм уу, үгүй юм уу гэдэг асуудлыг... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Санал, үг хэллээ. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай гээд энэ хуулийн төслийг би зарчмын хувьд хатуу дэмжихгүй байгаа.

Өнгөрсөн жил анх өргөн баригдах гээд орж ирэх гэж яригдаж байх үед нь хууль бус, зарчимгүй бөгөөд дүрэмгүй үйлдлийг би эсэргүүцэж үгээ хэлж байсан. Иргэдэд мэдээлэл өгч байсан.

Үндсэндээ юу гэдэг юм нэг ийм гоё нэртэй хууль оруулж ирээд л, гол асуудлаа ард нь гаргаад л, алдаагаа агуулгаар нь засахгүйгээр өөрөө өөрсдийнхөө нэг ийм хуурсан үйлдэл хийгээд байгаа өөрөө буруу асуудал.

Үндсэндээ би Монгол Улсыг олон төсөвтэй болгох энэ хуулийг дэмжихгүй. Маш олон төсөвтэй болгох үүд хаалгыг нээж байгаа.

Үндсэндээ Монгол Улсын төсвийг шүүр шанага шиг болгох ийм үүд хаалгыг энэ хуулиар нээх гэж байгаа.

Тэгэхээр улс орон байна. Энэ чинь бас нэг худлаа үнэн ч гэсэн дүрэмтэй, зарчимтай, хуультай, эдийн засгийн онол чинь нэг онол зарчмынхаа дагуу явж байж төсвийнх нь сахилга бат, хариуцлага, хяналтууд нь бас нэг сахигдаж байж энэ улс орон чинь бас нэг эдийн засаг нь арай өнгөтэй өөдтэй явдаг юм шүү дээ.

Тэгэхээр бид хүссэн ч хүсээгүй ч юу гэдэг юм эдийн засгийг төсөв, санхүүгээ салгаж ойлгох боломж бололцоо байхгүй. Төсөв, санхүү тоглоом биш шүү гэдгийг би олон хэлээд байгаа шүү дээ.

Зөв байцгаа, дүрмээ хуулиа сахицгаа, зарчимтай байцгаа. Энэ улс чинь—

- хуультай,
- дүрэмтэй,
- зарчимтай.

Яагаад заавал ч үгүй сайхан амьдрахад хууль садаа болоод байна гээд үүнийг өөрчлөх гэж орж ирээд байгаа юм бэ?

Эсвэл хуулийн хүрээнд амьдарч болохгүй болоод байгаа юм уу. Эсвэл хуулийг нь өөрчлөөд хуулийн хүрээнд хулгай хийх гээд байгаа юм уу.

Бүр хамгийн энгийн жишээ Та нар бодоод үз л дээ. Үндсэндээ Сэлбэ орон сууц гэдэг зүйлийг улсын төсвөөсөө зээлээрээ барина гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Хувийн хэвшлийнхээ хийж чадаж байгаа ажлыг нь хулгай хийнэ гэсэн чинь өөрөө юу гэсэн үг юм бэ. Дүрэмгүй, зарчимгүй асуудал шүү дээ.

Тэгээд буруу зүйлд энэ үнэн мөнийг нь хэлэхээс өөр арга байхгүй. Энэ бол миний зарчмын хувийн байр суурь.

Тэгээд Монголын төр нэг ийм дүрэмгүй, зарчимгүй, бодлогогүй байж болохгүй. Энэ улс орны чинь эдийн засаг жолоодлогогүй боллоо шүү. Хүссэн ч хүсээгүй ч энэ улсын чинь эдийн засаг төсөв, санхүүтэйгээ салшгүй холбоотой шүү.

Бид заавал ч үгүй буруу гэдгийг нь мэдсээр байж буруу замаар будаа тээх шаардлага өөрөө юу байгаа юм бэ? Нэг үг байдаг юм. Угаасаа далайн усыг давстай гэдгийг нь мэдэхийн тулд дуустал нь уух шаардлагагүй гэдэг шиг буруу гэдгийг нь мэдсээр байж заавал ч үгүй буруу замаар будаа тээх ямар шаардлага байгаа юм бэ. Далд төсөвтэй болох гэж, далд өр зээлтэй болох гэж.

Ингээд улсын төсвийнхөө хяналтынхаа гадна өрийнхөө удирдлагыг гаргах гэж. Энэ чинь—

- хууль зүйн талаасаа ч,
- санхүүгийнхээ талаасаа ч,
- засаглалынхаа талаасаа ч—

-асар олон эрсдэлүүдийг дагуулаад байгаа асуудал юм.Тэгэхээр –

- суурь асуудлыг нь,
- төсвийнх нь сахилга батыг нь,
- хяналт, хариуцлагыг нь дээшлүүлэх талаас нь,
- төсвийнх нь тодотгол талаас нь ч гэдэг юм уу –

-энэ талаас нь оруулж ирээд хийх л уг нь шаардлагатай л байгаа шүү дээ.

Түүнээс одоо юу гэдэг юм нүдээ аниад л энэ нэг гадаад зээл, тусламжуудаа хуулийнхан гадна гаргаад нэг сайн сайхан юм шиг болохоор өөрсдийгөө хуураад байж болохгүй шүү дээ.

Хууль тогтоох, төрийн эрх барих, төсөв батлах дээд байгууллага Улсын Их Хурал ингэж өөрөө өөрийгөө хуурч боломгүй байгаа байхгүй юу.

Энэ өөрөө маш том бодлогын алдаа болно.

Үндсэндээ төсвийн сахилга батыг шүүр шанага шиг болгох асуудлыг ярьж байгаа. Тэр Сэлбийг нь байна уу, тэр орон сууцыг нь байна уу хаслаа ч гэсэн шүүр шанагатай болгох үүд хаалгыг чинь хийж байгаа. Магадгүй тэрийг нь хаслаа гэхэд шүүр шанаганыхаа нэг ганц хоёрхон нүхийг нь бөглөж байна л гэсэн үг болж байгаа.

Тэгэхээр ийм байдлаар явамгүй байна. Өөр өөрсдийнхөө хуурамгүй байна. Түүхэн зууртаа болох юм шиг ингээд өөр өөрсдөдөө хуураад ийм байдлаар явж боломгүй байгаа.

Үүнийг чинь би ч хэлээд байгаа асуудал биш. Мэргэжлийн байгууллага нь, энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөл, мэргэжлийн судлаач нар нь, эрдэмтэд нь хэлээд байгаа асуудлууд байгаа. Ийм зарчимгүй зүйл дээр бид бас нэг арай жоохон зарчимтайхан шиг баймаар байна л гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Х.Тэмүүлэн гишүүн.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр хоёр хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Ж.Батжаргал дарга. Ардын намын бүлгийн дарга.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улс яах аргагүй Төсвийн тусгай шаардлагатай, Тогтвортой байдлын тухай хуультай улс орон. Тэнд эдийн засаг, төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг хооронд нь уялдуулж тогтворжуулдаг хязгаарлалтуудыг хийж өгсөн. Үүнийгээ барьж ажилладаг.

Гэхдээ бид энэ улс орны хөгжлийг хангах зайлшгүй шаардлага байгаад байгаа юм.

Тийм учраас том том бүтээн байгуулалтын ажлууд өрнөж байна. Улсын төсвийн зарлагын 20 хувьтай тэнцэх хэмжээний газрын тос боловсруулах үйлдвэрийн маань төсөвт өртөг тэгж гарч ирж байгаа. Бүтээн байгуулалтын ажлынх нь өртөг.

Тэгэхээр үүнийг тэр тусгай шаардлагадаа нийцүүлээд явна гэхээр зэрэг ажил 20, 30 жилээр үргэлжлэхээр ийм дүр төрх байгаа. Бүгдээрээ энэ байдлаа мэдэж байгаа.

Тийм учраас үүнийгээ ингээд түгжээд өөрсдөө байгаад байх юм уу, эсвэл хууль зүйн хувьд нь авч үзэж Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, тэр Хөгжлийн банкны тухай хууль тэр гээд холбогдох хуулиуддаа өөрчлөлт оруулаад өөрөө өөрийнхөө үйл ажиллагаагаар анхны хөрөнгө юмаа нөхөж чадах ийм аж ахуй, бизнесийн чиглэлтэй том бүтээн байгуулалтын ажлууддаа зээл юмнуудаа авч ашигладаг, тэрийг нь Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээ соёрхон баталчхаад зээл авч байгаа талын хөгжлийн банк нь, зээл олгож байгаа талын банкнууд нь хоорондоо гэрээгээ хийгээд, үндсэн аж ахуйдаа зээлээ өгөөд явдаг ийм хэлбэрээрээ явах юм уу гээд бидэнд бодох юм маш их байгаа.

Өнөөдрийн энэ ярьж байгаа асуудал бол аль нэг хүн рүү буруу өгөх янзгүй. Хуулийн төсөл өргөн баригч нар 3 төсөл дээр энэ хуулийг үйлчлэхээр нэг удаагийн үйлчлэлтэй хууль оруулж ирсэн.

Мэргэжлийн Байнгын хороо, ажлын хэсэг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлаа зохион байгуулахдаа нэг төслийг нь хассан юм.

Гэтэл чуулганы нэгдсэн хуралдаан дээр анхны хэлэлцүүлгийн үеэр Их Хурлын гишүүд мэргэжлийн Байнгын хорооныхоо санал, дүгнэлтийг анзааралгүйгээр уг унагасан асуудлыг босгоод ирсэн юм.

Тэгээд одоо өнөөдөр энэ асуудлыг чинь эрх зүйн хувьд нь авч үзье гэвэл төсөл өргөн баригч хууль хуулийн төслөө хэлэлцүүлгийн аль ч түвшинд татаж авч болох ганц заалт байгаа.

Түүнээс хуулийн төсөл дотроос тухайлсан заалтыг татдаг ийм эрх зүйн зохицуулалт байхгүй.

Гэхдээ нэгэнт ийм улс орны аюулгүй байдалтай ч холбоотой, том бүтээн байгуулалттай ч холбоотой, цаг хугацаа алдамгүй шийдвэрлэх ёстой асуудал байгаа учраас Монгол Ардын намын бүлэг ирэх нэг дэх өдрийн хурлаараа энэ асуудлыг дахин авч үзээд тэгээд дөрөв дэх өдөр эцсийн хэлэлцүүлгийг нь дуусгуулъя гэсэн ийм бодолтой байна.

Тийм учраас ажлын 4 өдрийн завсарлага хүсэж байна.

**С.Бямбацогт:** Яах аргагүй нэлээн сайн хэлэлцэж байж шийдэх ёстой асуудал байх.

Гишүүд олон талаас нь байр сууриа илэрхийлж байна. Мега төслүүдээ хөдөлгөх, хэрэгжүүлэх, хурдан хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулж бүтээн

байгуулж, эдийн засгийн үр өгөөжийг нь хүртэх, эрчим хүчний тусгаар тогтнолоо олж авахад Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц чухал ач холбогдолтой.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулж монголчууд өндөр үнэтэй газрын тос гаднаас биш өөрсдөө үйлдвэрлэдэг, өөрсдөө хямд үнэтэй газрын тос, бензин шатахуунтай болох асуудал чухал байгаа.

Тийм болохоор олон талаас нь харах ёстой байх.

Ардын намын бүлэгт ирэх Пүрэв гарагийн 10.00 цаг хүртэл завсарлага өглөө.

Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяагийн урилгаар Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газрын авто тээврийн цехийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Зууны манлай үйлдвэр Монгол Улсын хамгийн том татвар төлөгч, хамгийн олон ажлын байр олгогч компаниудын нэг Эрдэнэт үйлдвэрийнхээ нийт ажилтан, албан хаагчдад Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/**

---

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн 2026 оны 3 дугаар сарын 31 ний өдрийн 04 дүгээр тогтоолоор уг дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очиороор ахлуулж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Баярбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн 43-д дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хурал албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 3 хоногийн дараа хэлэлцэж, 10 хоногийн дотор шийдвэрлэх.

Мөн Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэхээр тусгаж боловсруулсан талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцууллаа.

Ажлын хэсгээс боловсруулсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасныг баримтлан хэлэлцлээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгээс нь эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

**С.Бямбацогт:** Б.Баярбаатар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя. Нэрээ татлаа. /алх цохив/

Жамбалын Ганбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/  
Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

**А.Ариунзаяа:** Би ажлын хэсгийн гишүүн учраас асуулт асуух нь өөрөө утгагүй асуудал учраас би зүгээр протоколд цөөн хэдэн үг хэлье гэж бодлоо.

Дэгийн хууль бүлгээрээ 101 дүгээр зүйл дээр бид анхаарч өөрчлөх ёстой гэдгийг энэ ташрамд хэлмээр байна. Яг энэ 101.1 дээр долоо хоногийн дараа гэж Үндсэн хууль дээр 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ буюу Ерөнхий сайдыг огцруулахаар гишүүдийн саналаар гарын үсэг цуглуулаад асуудлыг албан ёсоор тавьж байгаа бол 3 хоногийн дараа хэлэлцэж эхэлнэ гэдэг Үндсэн хуулийн заалт.

Манай Дэгийн тухай хууль дээр долоо хоног гэж байгаа нь зөрчилтэй гэж үзсэн.

Өнгөрсөн намар яг энэ асуудлаар цаг хугацаатай асуудал орж ирэхэд яг 3 хоногийн буюу Үндсэн хуулийнхаа тэр хугацаагаараа хэлэлцэж эхэлсэн байдаг.

10 хоногийн дотор хэлэлцэж дуусах хуультай байгаа.

Тэгэхээр тухайн үеийн чуулгандаа орохгүй байсан гишүүд. Чуулганы ирцийг бид бас бүрдүүлж чадаагүй нэг өдөр өнгөрсөн шүү дээ. Бүтэн. Тийм ээ.

Тэгэхээр яг чуулгандаа Үндсэн хуулийн хугацаатай бол оролцохгүй байгаа гишүүдэд ямар хариуцлага байх вэ гэдгийг тодорхой дэгийн хуульдаа зааж өгөхгүй энэ өөрөө эргээд энэ хугацаандаа хэлэлцээгүй бол, хэлэлцэж дуусаагүй бол Үндсэн хууль зөрчсөнд орох уу, үгүй юу гэдэг асуудал эргээд нийт Улсын Их Хурлын гишүүдэд хамаарах учраас Их Хурал өөрөө чадамжгүй гэдэг. Юу гэдэг юм ийм асуудал үүсэх нь үү, үгүй юу гэдгийг тодорхой болгож өгөх хэрэгцээтэй гэж үзэж байгаа.

Мөн түүнчлэн 101.4 дээр өмнөх 95 дугаар тогтоолтой холбоотой зөрчил гарч байсан нь Байнгын хорооны дүгнэлтийг сонсож, тэгээд санал хураана гэсэн байсныг өмнөх практикаар Байнгын хорооны дүгнэлтээр буюу Байнгын хорооны дүгнэлтээр нь дэмжсэн, дэмжээгүйгээр нь санал хурааж явсан нь өмнөх практикт байсан нь хуулиар буруу ойлгогдож хэвээр явсан нь Үндсэн хуулийн зөрчилтэй байсан гэж 95 дугаар дүгнэлт дээрээ цэц дүгнэсэн байдаг учраас үүнийг илүү тодорхой болгож, 101.4-ийг өөрчлөн найруулах ёстой юм байна гэсэн ийм ажлын хэсгийн хүрээнд зөвхөн цэцийнх нь 12 дугаар дүгнэлт нь 101.1-тэй холбоотой гарсан учраас зөвхөн тэр заалтыг л хөндөж оруулж ирж байгаа.

Цаашид Улсын Их Хурлын дэгийн хууль дээр 101 дүгээр бүлэгтэйгээ нэлээд сайтар ажиллах хэрэгцээ шаардлага ойрын хугацаанд үүсэж байна гэдгийг хэлмээр байна.

Яах вэ ойрын хугацаанд хүн ямар нэгэн байдлаар огцруулах гээд байгаа асуудал огтоос биш. Зүгээр үүнийг зайлшгүй тодорхой болгох хэрэгтэй. Яг цэцийн дүгнэлт гарсантай холбоотой 101.1 түдгэлзсэн байгаа буюу одоохондоо хүчин төгөлдөр мөрдөгдөхгүй байгаа юм гэдгийг хэлье.

Хоёр дахь нь цэцийн гишүүдийн асуудлыг ч гэсэн бид ойрын хугацаанд цэцийн даргын асуудал 10 сарын өмнө хугацаа нь дууссан байгаа.

**С.Бямбацогт:** Асуулт асуух дэгтэй. Сая ажлын хэсгийн гишүүн өөрөө өөрөөсөө асуухгүй. Хариулт байхгүй байна.

- Үндсэн хуулийг бид дээдлэн сахина гэж тангараг өргөдөг.
- Монгол Улсын Үндсэн хуульд бусад бүх хуулиуд нийцсэн байх ёстой.
- Үндсэн хууль зөрчсөн хуулийг Улсын Их Хурал батлах ёсгүй.

Үндсэн хууль зөрчсөн иймэрхүү асуудлууд хааяа нэг үүсдэг. Үүнийг засаж залруулж өнөөдөр орж ирж байгаа.

Тийм учраас –

- ◆ Үндсэн хуулиа л дээдлэх ёстой.
- ◆ Үндсэн хуульд цагаан дээр бичсэн заалтуудыг ягштал баримтлах ёстой.

Энэ агуулгаараа ажлын хэсэг энэ хуулийг Үндсэн хуульд нийцүүлж өөрчлөлтийг хийж байгаа.

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

**М.Ганхүлэг:** Асуулт ерөнхийдөө давхардсан.

Орж ирж байгаа төсөлтэй холбогдолтой асуудал дээр дэмжээд явна. Цэцийн гишүүдтэй холбогдолтой, тодорхой бүрэлдэхүүнтэй холбогдолтой асуудлууд ер нь хэзээ яаж орж ирэх вэ гэдэг дээр тодруулъя гэсэн саналтай байгаа. Асуудалтай хамааралтай юу, үгүй юу?

Дээр нь Их Хурлын гишүүдийн дэгийн тухай хуулийн тодорхой төсөл илүү сайжруулахтай холбогдолтой олон асуудлууд байгаагаас үүдэж цаг үеийн нөхцөл байдлууд үүсэж байна.

Тийм учраас цэцийн гишүүд болон дэгийн тухай хуулийг илүү сайжруулах чиглэл дээр ямар явцтай байна вэ гэдгийг тодруулъя гэсэн юм. Тийм.

**С.Бямбацогт:** Хэлэлцэж байгаа асуудалтай хамааралгүй асуудал байна.

Гэхдээ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудад өөрчлөлт оруулахаар урьд нь Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очироор ахлуулсан ажлын хэсэг гарч ажиллаж байсан юм билээ.

Миний бие сая Улсын Их Хурлын даргаар томилогдсоноос хойш Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулах, нэр хүндийг нь дээшлүүлэх талаар, парламентын засаглалыг бэхжүүлэх талаар тодорхой саналуудаа өгөөч ээ гэж 126 гишүүнд албан ёсоор бичгээр саналууд хандсан.

Эндээс 30-аад гишүүнээс албан ёсоор Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой санал ирсэн.

Мөн 126 гишүүний ажлын албанаас саналуудаа өг гэсэн. 126 гишүүний ажлын албанаас 70-аад гишүүний санал ирсэн.

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудаас саналууд авсан.

Энэ бүгдийг нэгтгээд, бүгдийг нь нэг бүрчлэн уншиж танилцаад, ижил төстэйг нь ангилаад өнөөдөр Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, мөн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлтийг хийхээр ажиллаж байгаа.

Үүгээрээ үндсэндээ Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулах, парламентын засаглалаа бэхжүүлэх, Улсын Их Хурлынхаа нэр хүндийг дээшлүүлэхэд тодорхой ажлууд энэ хуулиудад хийгдэнэ гэдгийг Танд хэлье.

Мөн Үндсэн хуулийн цэцийн нэг гишүүн орон гарсан. Нэг гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан байгаа юм билээ.

Үүнийг ойрын үед судалж байгаад Улсын Их Хуралд оруулж ирэх ёстой. Энэ тал дээр анхааралдаа аваад ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

**О.Номинчимэг:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Орж ирсэн төсөл ойлгомжтой. Бид цагаан дээр хараар бичсэн өдөр хоногийн тоо зөрүүтэй байгаа учраас үүнийг ингээд хүлээж аваад өөрчлөөд явах нь зөв гэж бодож байгаа.

Зүгээр энэ асуудал яагаад бидний анхааралд орсон, иргэд гомдол мэдээлэл өгөөд, цэц дүгнэлт гаргасан гэдгийг харах юм бол намар болсон үйл явдалтай холбоотой байгаа юм.

Тэгээд яах вэ, энэ бол зүгээр нэг л өдөр хоногийн тооны асуудал байгаа.

Нэг маргаантай зүйл бол Үндсэн хуулийн цэц их суудлын хуралдаан зарлаад дүгнэлт гаргаад 64.2-ийнхоо дагуу гаргаад ирэхэд Улсын Их Хурал түүнийг нь авч хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу гэдэг асуудал Улсын Их Хурал дээр ч гэсэн маргаан болсон.

Тэгээд бид Хууль зүйн байнгын хороогоор ч гэсэн яг тэрийгээ авч хэлэлцээд байгаа юм уу, эсвэл өөр юм яриад байна уу гэдэгт ойлгогдохоо байгаад яг дэгийн хуулийн дагуу явж чадаагүй.

Дэгийн хууль дээр Үндсэн хуулийн цэц албан тушаалтантай холбоотой дүгнэлт гаргасан бол холбогдох Байнгын хороо буюу Хууль зүй, Төрийн байгуулалт нь хэлэлцээд л ингээд л явдаг ийм дэгтэй байгаад байсан.

Тэгээд үүнийг яагаад дэгээр нь яваагүй вэ гэдэг асуултад бид дараа дараагийн муу прецедент үүсгэхгүйн тулд Улсын Их Хурал өөрөө нэг хариулт өгөх ёстой.

Дэгийнхээ хуулийг хэрвээ бид зөрчсөн юм уу, эсвэл өмнө нь Улсын Их Хурлын гишүүдийг эгүүлэн татах хууль дээр Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажлын хэсэг энэ чинь бараг ингэхгүй ээ. Дэгийн хууль чинь буруу байна. Үндсэн хуулийн хууль дээр өөр эхний хоёр асуудлаар нь л Улсын Их Хуралд оруулна. Нөгөөдүүл нь дүгнэлт гаргана гэж байгаа учраас бараг л эгүүлэн татах юм бол 9 гишүүн тэнд дүгнэлт гаргах юм бол Улсын Их Хурал авч үзэхгүй шууд л татагдах нөхцөл нь болно гэдэг байдлаар оруулж ирсэн л дээ.

Тэгээд яг тэр логикоор байх юм бол тэнд чинь Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга Үндсэн хууль зөрчсөнийг шийднэ гэж байгаа юм.

Үндсэн хуулийн цэцийн 9 гишүүн тэрийг шийдэх юм бол Улсын Их Хурал тэрийг авч хэлэлцэхгүйгээр шууд огцруулах ийм үндэслэл байгаа юм шигээр тэндээс тайлбарлаж байсан л даа.

Тэгээд би бол тийм биш байх гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ нэг процессын асуудлаа тэгээд тэр дэгийн хууль дээр байгаа Үндсэн хуулийн цэцээс албан тушаалтантай холбоотой дүгнэлт орж ирэх юм бол Улсын Их Хурал тэрийгээ яаж авч хэлэлцэх вэ гэдэг юмыг нэг мөр бас тодорхой болгохгүй бол цаашид тодорхой бус явсаар байгаад муу президент болох вий дээ гэсэн болгоомжлол байгаа учраас энэ дээр Ц.Сандаг-Очир гишүүний ажиллаж байсан Улсын Их Хурлын хууль, дэгийн хууль, хянан шалгалтын хууль байгаа. Энэ дээр дахиад тэрийг нь нягтлаад, бүгдээрээ ярилцаад зөв болох тал руу нь нэг мөр шийдлийг нь гаргах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

**С.Бямбацогт:** О.Номинчимэг гишүүн санал хэллээ.

Ер нь бид анхаарах ёстой олон орхигдсон, зохицуулалтгүй, тодорхой бус иймэрхүү заалтууд Үндсэн хуульд нийцээгүй болон Үндсэн хуульдаа нийцүүлж өөрчлөөгүй заалтууд байна лээ.

Тэрийг анхаарах ёстой. Санал нэг байна. Ажлын хэсэг дээр таны саналууд ер нь яригдана. Бидний боловсруулж байгаа хуулийн төсөл дээр.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Мөн түрүүн Монгол Улсын Үндэсний Их Сургуулийн эрх зүйн ангийн оюутнууд байсан уу? Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж орж ирсэн шүү.

Тэгээд Та бүхэнтэй нийлүүлээд ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. /алга ташив/

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлаас баталсан цөөнгүй хууль тогтоомж дээр Үндсэн хуулийн үг, үсэг, үзэл санаа, зарим талаар суурь зарчим зөрчсөн иймэрхүү зүйл, заалтууд байгаа.

Сая яах аргагүй яваад ч бодсон 3 хоног гэдгийг долоо хоног гээд бичнэ гэдэг бол маш бүдүүлэг алдаа л даа.

Яг үүнтэй адилхан цэцийн хууль тогтоомж болон өнгөрсөн 30-аад жил маш буруу тайлбарласан, гажуудуулсан байдлаар хэрэглэсэн тийм хэрэглээнүүд байгаа юм билээ.

Тийм учраас бид Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ер нь Үндсэн хуульд байж байгаа зүйл, заалтуудын хоорондын уялдааг хангах тийм хэрэгцээ шаардлага, хуулийн кодвикаци хийх хэрэг үүсээд байх шиг байна.

Улсын Их Хурал энэ дээр нэлээн сайн анхаарч ажиллах хэрэгтэй болов уу гэж бодогдож байгаа.

Сая Ерөнхийлөгчийн өргөн барьсан хууль дотор ч гэсэн Үндсэн хуулийн нэр томъёог мугуйд байдлаар өөрчилж хэрэглэх гэсэн оролдлогууд харагдаж билээ.

Тэгэхээр энэ байдлуудыг бид нэг мөр шийдэх хэрэгцээ байх шиг байна. Маргаантай байгаа бол Үндсэн хуулийнх нь нэр томъёогоор бичих нь илүү зөв байх. Үндсэн хууль дээр ямар нэр томъёо байгаа, ямар зохицуулалт байгаа тэр агуулгаар нь шууд би хэрэгтэй.

Тухайлбал, Та бүхэн саяхан болсон нэг маргааныг санаж байгаа байх. Улсын Их Хурлын даргыг сонгохтой холбоотой асуудал дээр чинь ямар ч нам гэдэг, тэр дундаа олонх гэдэг юм үг байхгүй. Улсын Их Хурлын гишүүд дотроосоо сонгоно л гэсэн үг байгаа.

Хэрвээ ингээд маргаан байгаа тэр үгээр л бичсэн нь дээр. Үндсэн хууль дээр—

- ямар үг байгаа,
- ямар нэр томъёо байгаа,
- ямар агуулга байгаа—

-гэдгийг нь түүгээр нь бичсэн дээр. Тэрийг засварлах гэж, улс төрийн нөхцөл байдалдаа тааруулах гэж, эрх мэдэлтэй байгаа дээрээ бидний өнгө аясаар бичвэл зүгээр болов уу гэж найдаж бичих нь цаашдаа Үндсэн хуулийн зөрчил улам бүр даамжрах, Үндсэн хуулийг үгүйсгэх ийм жишиг тогтох аюул байгаа гэдгийг бид ойлгох хэрэгтэй.

Дээр нь дахиад Үндсэн хууль дээр Үндсэн хуулийн дэг журам гэж нэг ойлголт байгаа.

Монгол Улсад Үндсэн хуулийн дэг журам өөрөө хоёргүй үгээр нэг мөр хэрэгжиж байх ёстой. Бид хэд энэ Үндсэн хуулийн —

- дэг журамтай холбоотой,
- эрх мэдэлтэй холбоотой,
- үндсэн эрхтэй холбоотой—

-асуудал дээр хууль тогтоомжийнхоо хэл найруулга, нэр томъёог бас нэг эргэж харахгүй бол маш их гажуудсан тийм ойлголтууд байгаа юм билээ шүү.

Тэгээд чиглэлээр судалгаа хийдэг юм уу, Улсын Их Хурал дээрээс ажлын хэсэг байгуулдаг юм уу, нэг тийм идэвхтэй нэг ажил зохион байгуулахгүй бол Засгийн газарт найдаад яваад байж бүтэхгүй юм байна гэдэг тодорхой харагдаж билээ.

Тэгэхээр хууль санаачлагчийнхаа хувьд Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын зүгээс энэ дээр нэг идэвхтэй ажил зохион байгуулаад өгөөч гэж Их Хурлын даргаас хүсэж байгаа юм.

**С.Бямбацогт:** Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг олон жил батлагдаад гар хүрээгүй олон жил болсон. Тэгээд цэцээс олон удаа янз янзын шийдвэр гарч байсан.

Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн парламентын үед Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргилоор ахлуулсан ажлын хэсэг гарч ажиллаж байсан.

Миний бие энэ төслийг шинэчилж найруулах ажлын хэсэгт ажиллаж байсан. Энэ хуулийн төсөл үндсэндээ бэлэн болсон байгаа.

Үүнийг энэ парламентын гишүүд, тухайлах юм бол манай Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын гишүүд цааш нь анхаараад авч явах тал дээр анхааралдаа авъя. Энэ бол гарцаа байхгүй шийдэх, зохицуулалтыг нь сайжруулах, харилцааг нь боловсронгуй болгох шаардлагатай болсон хууль байгаа.

Тэгээд таны хэлсэн саналыг анхааралдаа авлаа.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

**О.Саранчулуун:** Асуулт гэхээсээ илүү санал байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Хүн бүр хууль зүйн этгээд байна гэдэг ийм заалт байгаа.

Нөгөө талд Улсын Их Хурлын гишүүн чуулганы танхимд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээдэггүй гэдэг бас нэг ийм заалт байгаа.

Тэгээд чуулганы танхимд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээдэггүй гэдгийн доор эргээд юу болж байгаа вэ гэхээр энэ Үндсэн хуулийн 14.2 дугаар зүйлийг зөрчдөг. Үргэлж нэгнийгээ янз бүрээр хэлдэг. Хүнийг Үндсэн хуулийн 14.2 дээр байгаа зүйл, заалтыг зөрчиж байгаа.

Доромжлох, үг хэлээр гутаах, сүрдүүлэх, чуулганы танхимаас гараад ч гэсэн тийм явдал болдог.

Тэгээд асуудлыг жишээлбэл нэгэнт дэгийн асуудлыг ярьж байгаа учраас би хэлье гэж бодож байна. Тэмдэглүүлээд.

Тэгэхээр дээр бид цаашдаа ер нь яаж зохицуулалт хийх юм бэ? Чуулганы дэгийн тухай хууль дээр анхаарах хэрэгтэй.

Нөгөө талд чуулган өөрөө Байнгын хороодоос бүрддэг. Байнгын хороод нь өөр өөрийн гэсэн үүрэгтэй. Жишээлэх юм бол Шинжлэх ухаан, технологийн байнгын хороонд байгаа гишүүд шинжлэх ухааны салбарын бодлого, хууль эрх зүйн асуудлуудыг яах вэ гээд судлаад, сайжруулаад, дүрэм журмыг нь яриад ингээд хэлэлцээд явдаг.

Үүнтэй адилхан Ёс зүйн дэд хороо гэж байгаа. Эсвэл Ёс зүйн дэд хороогоо Халдашгүй байдлын дэд хороотойгоо уялдуулаад байх юм уу? Энэ хоёр бүтцийг ер нь сайжруулж Их Хурлын 126-тай энэ хурлын дэг, зохион байгуулалтыг сайжруулахгүй цаашдаа ер нь хүндрэх байдалтай байна.

Яагаад гэвэл энэ Ёс зүйн дэд хороо чинь өөрөө, эсвэл Халдашгүй байдлын дэд хороо чинь иргэдийн парламентад итгэх итгэлийг хамгаалах нэг институт байх ёстой шүү дээ. Тэр талаас нь ажиллаад явах ёстой.

Тэгэхээр дээр анхаарсан ямар нэгэн байдлаар цаашаа үргэлжлүүлж зохицуулах ёстой гэж би бодож байна.

- **Ил тод байдал** гэдэг ойлголт,
- **хүртээмж** гэдэг ойлголтыг—

-бид хаа хаанаа ярих хэрэгтэй байгаа. Ил тод гэснээ нээлт юм уу, аливаа арга хэмжээний нээлтийнийн хэсгийг ярьж зарлачхаад гол хэсгийг нь хаадаг. Тийм гурилдсан зүйлийг ил тод гэж ярихгүй шүү дээ.

Тэгэхээр ер нь чуулганы хуралдаан дэг аливаа Байнгын хороо ч бай хурал нь ил тод байгаа бол эхнээсээ ил тод, ойлгомжтой байх ёстой. Бүх хүнд.

Хэрвээ хаалттай байх ёстой хаалттай горимоор нь бүрэн утгаар нь байх ёстой.

Тэгээд үүнийг ингээд харахаар Үндсэн хуулийн цэц маань Их Хурлын хуулиудын үг, үсгийн алдааг засдаг юм шиг бараг ийм юм яригдаж байна шүү дээ.

Тэгээд 300 хүнтэй Улсын Их Хурлын Тамгын газар гэж байгууллага тэгвэл байхын хэрэг юу байгаа юм бэ? Ийм том хууль дээр ийм алдаа гаргаж байгаа бол бусад жижиг хуулиуд ямар ямар асуудлууд гардаг бол оо. Энэ дээр бид анхаарах хэрэгтэй байх гэж бодож байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах дээр би түрүүн хэлсэн.

Тодорхой гишүүдийн саналыг аваад тодорхой нэмэлт, өөрчлөлтийн төсөл бэлэн болж байгаа. Үүнийг Улсын Их Хурлын даргын зөвлөлөөр танилцуулж, даргын зөвлөлийн гишүүд санаачилж өргөн барих ийм бодлоготой байгаа.

Энэ дээр Таны ярьж байгаа Улсын Их Хурлын гишүүд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй гээд бусдыг –

- гүтгэдэг,
- гутаадаг,
- доромжилдог,
- худлаа мэдээлэл тараадаг,
- ёс зүйгүй авирладаг –

-энэ бүгдийг тодорхой зохицуулсан, шаталсан зохицуулалт, хариуцлагын арга хэмжээнд оруулах ёстой.

Үнэхээр бие биеэ гүтгээд, гутаагаад Их Хурлын гишүүд бүгд хулгайч юм шиг, бүгдээрээ гэмт хэрэгтэй юм шиг, худлаа мэдээлэл тараагаад Улсын Их Хурлынхаа нэр хүндийг, төрийн бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах мэдээлэл тараах гэх мэтийн олон асуудлууд гарч байгаа.

Тийм болохоор хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй байдаг, бусдыг гүтгэж, гутааж, худлаа мэдээлэл тараахгүй байх. Ингэх юм бол тодорхой зохицуулалтуудыг оруулахаас өөр аргагүй байгаа.

Үүнээс чинь болоод л –

- Улсын Их Хурлын нэр хүнд унадаг,
- Улсын Их Хурлын гишүүдийн нэр хүнд унадаг,
- төрд итгэх ард түмний итгэл алдардаг –

-ийм болоод байгаа учраас зайлшгүй бид онцгой анхаарч шийдэх ёстой асуудал.

Тийм учраас үүнийг өөрчлөхөөр тодорхой ажлууд хийгдээд явж байгаа гэдгийг Танд хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Ер нь асуулт асуусангүй. Их Хурлын чуулганы хуралдааны дэгтэй холбоотой, дэгийн хуультай холбоотой нэлээн саналууд хэллээ.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаас санал хураалт явуулах ёстой. Тийм.

Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас үг хэлэх дэг байхгүй. Одоо танхимд санал хураах боломжтой ирц алга байна.

Тийм учраас санал хураалтыг хойшлуулъя. 14.00 цагаас Ерөнхий сайдын асуулгын цаг Улсын Их Хурлын нээлттэй сонголын цаг тавигдсан байгаа. Хуультай учраас энэ цаг дээр асуудал хэлэлцэгдэнэ.

16.00 цагаас уу? Тэгээд 16.00 цагаас өнөөдрийн хэлэлцэх асуудлуудаа үргэлжлүүлж явуулна.

Тийм болохоор санал хураалтыг 16.00 цаг хүртэл хойшлууллаа. 16.00 цагт санал хураалтдаа гишүүдийг бэлэн байхыг урьж байна. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Дөрөв.Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон  
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд  
/Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 3 гишүүн  
2025.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
эцсийн хэлэлцүүлэг/**

---

Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Д.Рэгдэл, Г.Хосбаяр нараас 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 4 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн

---

хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал гаргаагүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Сархадын Зулпхар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл, Болдын Уянга, Ганбатын Хосбаяр нарын гишүүд санаачилсан хууль байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Бадарчийн Оюунцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Баатарын Туул Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Батнасангийн Бат-Эрдэнэ Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга, Бүдээбазарын Авид Шинжлэх ухааны академийн дэд Ерөнхийлөгч.

Ажлын хэсэг Та бүхэнд танилцууллаа.

Тэгээд гишүүдэд асуултад хариулахдаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн гишүүд үнэн зөв бодитой мэдээлэл өгөх, худлаа мэдээлэл өгөхийг хориглодог. Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой шүү гэдгийг Та бүхэндээ сануулъя.

Сүхбаатар Эрдэнэболд гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/  
Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Хүрэлбатын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/  
Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууна гэж нэрээ өгөөд, үг хэлнэ гэж нэрээ өгөөд асуултаа асуудаггүй, үгээ хэлдэггүй ийм байж болохгүй шүү.

Өнгөрсөн 2024 оны шинэ парламент бүрдсэн 7 сараас хойш асуулт асуухаар нэр аваад үгээ хэлээгүй дээд тал нь 40 хэдэн тохиолдлууд судалгаагаар гарч байна лээ шүү. Энэ бүгд нь судлагдаж байгаа.

Үгээ хэлнэ гээд үгээ хэлдэггүй. Бусад гишүүдийнхээ өмнүүр ороод тухайн бүлэг бүлэгтээ үг хэлнэ, асуулт асууна гээд нэрээ өгдөг.

Тэгээд үгээ хэлдэггүй, асуултаа асуудаггүй. Бусад гишүүд нь асуулт асуух гээд, үгээ хэлэх гээд хүсэлтээ тавихаар тэр хүмүүсийн боломж нь хаагдсан байдаг. Тэгсэн мөртлөө энд ирж асуулт асууж үгээ хэлдэггүй. Үүнийг бид зохицуулах ёстой. Цаашдаа гишүүд энэ тал дээр хариуцлагатай хандах ёстой шүү гэдгийг хэлье.

Асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

---

**Тав.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай  
хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон  
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**

/Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн 2025.12.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/

---

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн танилцуулна.

**С.Цэнгүүн:** Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн танилцуулга.

---

### **Хуулийн төслийн зорилго.**

1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцож, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Иргэний хууль, Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудтай нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд энэхүү хуулийн төслийн зорилго оршино.

Тус хуулийн төсөл нь төрийн өмчит компанийн засаглал, захиргааны шууд хяналт тогтоох өмнөх нийгмийн хариуцлагыг халж, компанийн дотоод хяналт, хариуцлага, хувьцаа эзэмшигчдийн хяналтыг ил тод, хязгаарлагдмал механизмаар орлуулах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байна.

### **Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага.**

1991 онд батлагдсан хууль нь Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжиж байсан түр шилжилтийн үед эдийн засгийн хямралыг даван туулах, стратегийн үйлдвэр байгууллагын үйл ажиллагааг зогсолтгүй үргэлжлүүлэх зорилгоор гарсан онцгой арга хэмжээний шинжтэй зохицуулалт байсан.

Гэвч энэхүү хууль өнөөдрийг хүртэл хүчингүй болоогүй хэвээр байгаа нь эрх зүйн орчны зөрчил, давхардлыг бий болгож, төрийн байгууллагын оролцоог албадлагын замаар хэт төвлөрүүлэх, компанийн засаглалын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

2019 оноос хойш тус хуулийг үндэслэн Эрдэнэт үйлдвэр, Монросцветмет, “Эрдэнэс Тавантолгой”, “Тавантолгой” ХК зэрэг хэд хэдэн томоохон компанид онцгой дэглэм тогтоож, Засгийн газраас бүрэн эрхт төлөөлөгч томилсон.

Энэ нь эдгээр компанийн удирдлагын бүтэц, төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрхэд шууд хяналт тогтоох замаар компанийн бие даасан байдлыг хязгаарлаж, улс төрийн оролцоо, ашиг сонирхлын зөрчлийг нэмэгдүүлэх эрсдэл дагуулсан байна.

Үүнтэй зэрэгцэн төрийн өмчит компанийн зарим нь ашигт ажиллагааны түр зуурын өсөлт үзүүлсэн боловч энэ нь зах зээлийн механизм бус төрийн шууд оролцоотой захиргааны удирдлагын төлөөтэй холбоотой болохыг судалгаанууд харуулж байна.

Иймээс энэхүү хуулийн хэрэгцээ нь өнөөгийн эдийн засгийн бодит нөхцөлд нийлэхгүй болсон гэж үзэж байна.

### **Хуулийн төслийн гол агуулга.**

- ◆ 1991 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох
-

тухай хуулийг хүчингүй болсонд тооцох.

- ♦ Онцгой дэглэмийн хүрээнд эдийн засгийн хариу арга хэмжээ авах асуудлыг онцгой байдлын тухай хуульд тусгах.
- ♦ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын удирдлагын хариуцлагыг дотоод хяналтын тогтолцоо, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдлаар хангах боломжийг бүрдүүлэх.
- ♦ Төрийн өмчит компанид хяналт хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд ажиллах зарчмыг баталгаажуулах.

### **Хуулийн төсөл батлагдсанаар эрх зүйн болон эдийн засгийн үр нөлөө.**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хууль зүйн орчны давхардал, зөрчил арилж, төрийн оролцоо хуульд заасан хүрээгээр хязгаарлагдана.

Төрийн өмчит компанийн засаглал ил тод, хариуцлагатай болж, улс төрийн нөлөө, авлига ашиг сонирхлын эрсдэл буурах нөхцөл бүрдэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит компаниудад зах зээлийн зарчмаар бие даасан үйл ажиллагаа явуулах, ашгийн төлөө үр ашигтай менежмент хэрэгжүүлэх чадамж нэмэгдэх бөгөөд компанийн гүйцэтгэл, үр ашиг илүү тогтвортой хэмжээнд хүрэх боломжтой болно.

Зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хийсэн бөгөөд энэ хууль батлагдсанаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдэд материаллаг болон материаллаг бус зардал гарахгүй.

### **Нийгэм, эдийн засгийн түвшинд хүлээгдэж буй үр дүн.**

Төрийн өмчит компанийн хариуцлага хяналт сайжирна. Ингэснээр ил тод байдал, төрийн хязгаарлагдмал хяналтын тогтолцоо төлөвшиж, төрийн оролцоо буурна.

Мөн зах зээлийн зарчим бэхэжсэнээр компанийн удирдлага, санхүүгийн шийдвэр зах зээлийн нөхцөлд тулгуурлах тул үр ашиг, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

Авлига ашиг сонирхлын эрсдэл буурч, төрийн болон орон нутгийн өмчит компаниуд улс төрийн бүлэглэл, албан тушаалтны ашиг сонирхлын нөлөөллөөс ангид ажиллах боломж бүрдэнэ.

### **Иргэдийн итгэл төрийн нэр хүнд нэмэгдэнэ.**

- Төрийн өмчийг ашиглах үйл явц ил тод болж, нийгэмд итгэлцэл, хариуцлагын соёл төлөвшинө.
- Хууль дээдлэх зарчим баталгаажна.

Ингэснээр төрийн байгууллагын бүрэн эрхэд заасан хязгаарт баригдаж хууль зүйн нэгдмэл тогтолцоо бий болно.

Хуулийн төслийг хууль тогтоох үйл хэрэгт олон нийтийн санал бодлыг тусгах, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого, шийдвэрийг гаргах, тэдний дуу хоолойг хүргэх, ард олны засаглах эрхийг хангах зорилготой.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын d.parliament.mn цахим сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан бөгөөд иргэдээс цахим хэлбэрээр санал ирээгүй болно.

Харин зарим төрийн өмчит үйлдвэрийн газар болон хууль санаачлагчдын дунд зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлэгт оролцогчид салбарын мэргэжлийн холбооноос албан бичгээр ирүүлсэн саналуудыг үндэслэн зарим өөрчлөлтийг оруулсан болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Бямбацогт:** Саруулсайханы С.Цэнгүүн гишүүнд баярлалаа.

Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танилцуулна.

Индэрт урьж байна.

**О.Батнайрамдал:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 4 сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хуулийн төсөл санаачлагч нь онцгой дэглэм тогтоох харилцааг шинэчлэн тодорхойлж, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох агуулгатай бие даасан хууль байх нь үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэх.

Цаашид энэ харилцааг зохицуулах хуулийг олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиуддаа нийцүүлж, уялдааг хангах, захиргааны шийдвэрээр онцгой дэглэм тогтоохыг хязгаарлаж, эдийн засгийн

хямрал, байгалийн гамшиг, дайн, онц байдлын үед онцгой дэглэм тогтоох болон сунгах үндэслэл, нөхцөл, шалгуур, шаардлагыг тодорхой болгох. Энэ үед хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлах, онцгой дэглэм тогтоосон тохиолдолд компанийн засаглал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хяналт, аудитын хорооны чиг үүрэг, тогтолцоог хадгалж, эдгээртэй хамтран ажиллах, өмчлөгчийн эрхийг баталгаажуулан, төрийн хяналтдаа хугацаа, хүрээг нарийвчлан зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед –

- Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц 2019 оноос хойш нийтдээ төрийн өмчийн 6 компани дээр бүрэн эрхт төлөөлөгч томилон ажиллуулсан нь тус компаниудад ямар үр дүн гарсан талаар, төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөж буурах, улсын төсөвт төвлөрүүлэх орлого хангалтгүй байх нөхцөлд Засгийн газар ямар арга хэмжээ авах, энэ хуулийн төслөөр Засгийн газрын боломжийг хязгаарлаж байгаа эсэх талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 1992 оны Үндсэн хуулиас өмнө батлагдсан 6 хууль байгаа талаар дурдаад, яагаад энэ хуулийг онцолж хүчингүй болгох гэж байгаа юм. Онц байдлын тухай хуульд өөрчлөлтийг оруулахдаа одоо хүчин төгөлдөр болгож байгаа энэ хуулийн зохицуулалтыг хэвээр нь хадгалж байгаа эсэх, хэрхэн сайжруулах талаар,
- Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хуулийн төслийн үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч томилж байсантай холбогдуулан иргэний нийгмийн байгууллагуудаас Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдол бий эсэх.

Хэрэв байгаа бол ямар үр дүн гарсан талаар мэдээлэл, судалгаа байгаа эсэх. Онц байдлын тухай хуульд оруулж байгаа зохицуулалтууд нь зөвхөн онц байдал зарласан тохиолдолд үйлчлэх эсэх.

Бүрэн эрхт төлөөлөгч нь томилогдсон зарим компанийн ашиг орлого яагаад сайжирсан, нөгөө талаас энэ үед хэчнээн ажилтан, иргэнд цалин хөлс, гэнэт хал халагдсаны тэтгэмж аваагүй гэх мэт хохирсон талаар тооцоо, судалгаа байгаа эсэх.

Харьцуулалт хийх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан хуралдаанд оролцсон гишүүдээс дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж санал хэлэх үед –

- ▶ Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг 1991 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг дэмжиж байгааг дурдаад, төрийн болон

орон нутгийн өмчит компаниуд бүрэн эрхт төлөөлөгч томилох тухай асуудал нь Онц байдлын тухай хуульд орох шаардлагагүй бөгөөд холбогдох хуульд өөрчлөлт оруулах талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах талаар саналаа хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 57.3 хувь дэмжсэн бөгөөд хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

**С.Бямбацогт:** О.Батнайрамдал гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Эрдэнэ-Очирын Уянга “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн Хууль, эрх зүйн газрын дарга, Энхжаргалын Сундуй “Төв тусгал” сургалт судалгааны төвийн судлаач, Доржнамжилын Болд-Эрдэнэ Монголын хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч, Цэнддаваагийн Баяр-Эрдэнэ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга.

Ажлын хэсэг Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой. Орж ирээд гар утсаар зураг аваад байх юм байхгүй. Гар утсыг нь.

Мөн үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх ёстой. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстой шүү.

Тэгээд худлаа мэдээлэл өгөх юм бол хариуцлага хүлээдгийг сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Ганбатын Очирбат гишүүн. Алга байна. /алх цохив/

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай энэ хуулийн төслийг хүчингүй болгох хуулийн төслийг дэмжиж байгаа.

Ер нь 1992 оны Үндсэн хуулиас “Бүгд Найрамдах” гэдгээ бид аваад хаясан шүү дээ.

Тэгээд “Бүгд Найрамдах” гэдэг нь байхгүй болсон. Тэгтэл Бүгд Найрамдах Монгол Ард Улстай 2 хууль байх шиг байна.

- **Нэгдүгээрт**, - энэ хууль.
- **Хоёрдугаарт**, - Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль.

Тэгээд нэгэнт 1992 оны Үндсэн хуулиар “Бүгд Найрамдах” гэдэг аваад хаясан учраас Үйлдвэрчний эвлэлийн хуулийг цаашид одоогийн юундаа тохируулж оруулах нь зүйтэй.

Энэ дээр Үйлдвэрчний эвлэлийнхэн, одоо Ерөнхийлөгч байсан хүн нь Их Хурлын гишүүн болоод ороод ирсэн юм чинь тэр тал дээр ажиллах байлгүй гэж бодож байна.

2016 оноос хойш Монгол Ардын нам засгийн эрх авсан. 2016 оноос Монгол Ардын нам засгийн эрх авахдаа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгосон хуулийг ашиглаад өнөөдрийн хугацаанд 9 компанид бүрэн эрхт төлөөлөгч томилжээ.

Нэгдүгээрт,

- 2019 онд Эрдэнэт үйлдвэрт.
- 2022 онд Хөгжлийн банканд.
- 2022 онд Тавантолгой төмөр замд.
- 2022 онд Тавантолгой компанид.
- 2022 онд Дарханы төмөрлөгийн үйлдвэрт.
- 2020 онд Хөтөлийн цемент шохой үйлдвэрт.
- 2022-2023 онд “Эрдэнэс Тавантолгой” компанид.
- 2020 онд Монголросцветмет нэгдэлд.
- 2025 онд ТЭЦ-4 дээр Н.Тавинбэх гэдэг хүнийг томилоод –

-эдгээр 9 БЭТ-тэй ажлын үр дүн хэр гарсан бэ гэдэг өнөөдрийг хүртэл ойлгомжгүй, үр дүнгүй, тодорхойгүй.

Үр дүнд нь өөрсдөө баахан урамшуулал авсан нэг ийм шуугиан болоод дууссан.

“Эрдэнэс Тавантолгой” компани дээр ажилласан “бүрэн эрхт төлөөлөгч” нь 400 сая төгрөгийн урамшуулал авсан тухай тухайн үед хэвлэлээр яригдаад, хүлээн зөвшөөрч байсан тохиолдол хүртэл байгаа.

Бүрэн эрхт төлөөлөгч нь миний ойлголтоор уг нь засаглалыг сайжруулах гэж очих ёстой байтал засаглалыг нь хэвд нь үлдээгээд өөрсдөө цалингаа өндөр аваад явсан ийм тохиолдлууд байна. Хамгийн сүүлийн бүрэн эрхт төлөөлөгч шоронд одоо хоригдож байгаа.

Тэгэхээр бид аль 1991 оны хуулийг хэрэгжүүлээд явах нь өөрөө хэр юм. Эсвэл хэрэгтэй цагтаа ашиглана гээд энэ хуулийг бариад байсан юм уу. Би мэдэхгүй байна.

Одоо яг энэ ойлголтоор хэрвээ 6 сар хүртэл хугацаагаар улс орны эдийн засгийн амьдралд хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад нэн чухал шаардлагатай гэж БЭТ тавина гэж байгаа шүү дээ. Уг нь хуулийн зорилго нь. 6 сараар 1 удаа сонгох хэрэгтэй.

Харамсалтай нь үүнийг улс төрийн зорилгоор ашигласан. Бүрэн эрхт төлөөлөгч нарыг. Үндсэн ажлаа хийгээгүй. Үр дүнд хүрээгүй. Анхны зорилго нь бүтээгүй. Нэг ийм юм байгаад байгаа.

1998 онд Эрдэнэт үйлдвэрт бас бүрэн эрхт томилж байсан тохиолдол байдаг юм билээ.

Хэрвээ яг энэ хуулиар эдийн засаг хүндэрсэн, иргэдийн хэвийн амьдрах нөхцөл байдал хангагдаагүй гэж үзэх юм бол –

- эдийн засаг муудсан гээд өнөөдөр Сангийн яаманд хүртэл БЭТ тавьж болохоор байна шүү дээ.
- Мөнгөний ханшийн бодлого унасан гээд Монголбанканд тавьж болохоор байна.
- Олон олон банк бус байгууллагууд финтек, зээлийн аппууд хэрээс хэтэрлээ, эдийн засагт хүндрэл учруулах гэж байна гэх юм бол Санхүүгийн зохицуулах хороонд тавьж болохоор байна.

Бүр цаашлаад хуулиар чинь хувийн байгууллагууд БЭТ тавьж болохоор байна шүү дээ.

Тэгээд нөгөө чөлөөт эдийн засаг, ардчилсан нийгэм, бизнесийн өрсөлдөөн, төр, хувийн хэвшил хоёр холилдохгүй байх, төр нь хувийн хэвшилтэйгээ

өрсөлдөхгүй байх гэдэг энэ бүх үндсэн зарчмыг чинь энэ хууль өөрөө үгүйсгэж байгаа юм.

Энэ хуулийг ашиглавал дуртай компани дээрээ “бүрэн эрхт төлөөлөгч” тавих боломжтой ийм хууль.

Тэгээд ийм хуулийг ингээд санаачлаад оруулж ирж байгаа ажлын хэсэг нь баяр хүргэе.

Энэ хуулийг одоо бүгдээрээ дэмжээд явах хэрэгтэй. Тэгэхгүй бол дараа нь хэн засгийн эрхэнд гарахаас үл хамаараад хэн хэнийхээ хувийн өмчийг булааж авах вэ гэдэг ийм БЭТ-ээр хүртэл хийж болохоор байгаа юм.

Бүрэн эрхт төлөөлөгчийг томилоод хэний бизнесийг үйл ажиллагааг нь алдагдуулж болох вэ гэдэг, хэний хувийн бизнес рүү чөлөөтэйгөөр хуулийн доор халхавчлаад орж болох уу гэдэг энэ хууль өөрөө бий болгож өгч байгаа юм.

Чөлөөт эдийн засагтай ардчилсан нийгэмтэй улсад ийм хууль байж болохгүй.

Одоо Үйлдвэрчний эвлэлийн хуулийг хүртэл харах хэрэгтэй.

- ▶ Худалдаа, аж үйлдвэрийн танхим,
- ▶ Үйлдвэрчний эвлэл,
- ▶ Залуучуудын холбоо

-гурав л тусдаа хуультай, байртай.

Хоёр нь Улсын Их Хурлын гишүүн болоод эрх барьж байгаа намын урилгыг аваад ороод ирсэн.

Тэгэхээр энэ хуулийг дэмжиж байгаа.

**С.Бямбацогт:** Үг хэллээ. Тийм үү? Санал хэллээ.

Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн. Алга байна. /алх цохив/

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Да.Цогтбаатар:** Баярлалаа. Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Ер нь нөгөө “зуд болохоор нохой зоолдог” гэж Монголын төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр БЭТ томилохоор БЭТ-үүд нь баяждаг, эсвэл улаан намын цагаан байрныхан сонгуулийнхаа мөнгийг хийдэг нэг тод жишээ нь л энэ.

Тэгээд одоо үүнийг хүчингүй болгоё гээд орж ирж байгаа, санаачилж байгаа С.Цэнгүүн гишүүнд талархал илэрхийлье.

Ер нь энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа.

Тэгээд ер нь Эрдэнэт үйлдвэр, “Эрдэнэс Тавантолгой”, Монрос гээд тухайн үеийн Монголыг чирч явдаг байсан тоотой хэдэн компаниуд дээр БЭТ томилогдоод ямар үр дүнд хүрсэн талаар нэг тайлбар мэдээлэл байвал товчхон өгөөдхөөрэй гэж байгаа юм.

Ер нь төрд ямар нэгэн байдлаар бизнес эрхлээд байж болохгүй. Дуртай үедээ очиж хулгай хийдэг гэдгийн сонгодог жишээ энэ БЭТ-ээр илэрхийлэгдэж гарч байгаа. Үеийн үед гарч байсан.

Тэгэхээр Төрийн өмчийн хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар энэ ажлын хэсэгт орсонд нь талархаад байна. Яагаад гэхээр би хоёр асуулт асуух гэсэн юм.

- ▷ **Нэгдүгээрт**, БЭТ томилогдоод гарсан хариуцлагагүй, үр дүнд нь хариуцлага хүлээж байсан хүн байна уу гэж.
- ▷ **Хоёрдугаарт**, БЭТ очоод хэдий хэмжээний үнийн дүнтэй асуудал шийдэж, ямар үр дүнд хүрч байсан бэ гэдэг талаар тодорхой хариултууд өгөөч ээ.

Энэ хоёр асуултад хариулт авъя.

**С.Бямбацогт:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар. Ажлын хэсэг хариулъя. 3 дугаар микрофон.

БЭТ томилоод ямар үр дүн гарсан талаарх бодитой мэдээлэл өгнө үү гэж байна.

гишүүний асуултад хариулъя.

**Ц.Баяр-Эрдэнэ:** Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэ байна.

Ер нь нэр бүхий 6 компани дээр “бүрэн эрхт төлөөлөгч” томилох, онцгой дэглэм тогтоох асуудал өнгөрсөн хугацаанд хийгдсэн.

Тэгээд тухайлбал “Монголросцветмет” ХХК-г төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтад оруулаад, тухайн үед Засгийн газрын 2019 оны 103 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Б.Мөнхбат гээд хүнийг томилсон.

Энэ бол БЭТ томилох процессоор биш зүгээр төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг томилох хэлбэрээр явсан байгаа.

Тэр Б.Мөнхбат захирал үндсэндээ энэ онцгой байдал тогтоосон хугацаанд 4 жил энэ үйлдвэрийн газрыг удирдаж ажилласан байдаг.

Ер нь нийт улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж тухайн үеийн онцгой байдал тогтоохын өмнөх жил буюу 2018 онд 12.3 тэрбум байсан. Онцгой байдал тогтоосон жил 28.7 тэрбум болсон. Онцгой байдал тодорхой хугацаанд үргэлжилсэн буюу 2020 онд 38 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлж байсан байдаг. Онцгой байдлын дараах жил 2021 онд 92.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байдаг.

Тэгэхээр энэ бас нэлээдгүй үр дүн гарсан гэж үзэж болохоор байгаа.

Ер нь төрийн өмчит үйлдвэрийн газар ийм зохион байгуулалтад орсноор жишээ нь Монголпросцветмет дээр төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэцгүй. Гүйцэтгэх удирдлага, удирдлагын баг үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд явж байсан.

Яг очоод ажлын хариуцлага тооцсон байдлаар хүмүүс чөлөөлж бариагүй, бүтцийн өөрчлөлтүүд тодорхой хүмүүс чөлөөлөгдсөн асуудал байгаа. Эрдэнэт үйлдвэр мөн адил.

Ер нь Их Хурлын 23 дугаар тогтоолоор 2017 онд төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтад оруулах шийдвэр гараад 2019 оны Засгийн газрын 102 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэрийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан.

Ингээд энэ онцгой байдал тогтоосон шийдвэр үндсэндээ Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолоор хэрэгжээд 2019 оны 3 сарын 06-наас 2019 оны 9 сарын 06-н хүртэл явсан.

Энэ үед тус үйлдвэрийн газрын захирлаар Засгийн газраас баталсан дүрмийнх нь дагуу Х.Бадамсүрэн гээд захирлыг томилоод... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Тодруулж асууя. Даваагийн Цогтбаатар гишүүн.

**Да.Цогтбаатар:** Тухайн процессыг нь энд асуугаагүй юм. Их Хурлын дарга энэ дээр анхаарч өгөөрэй.

Зүгээр үнийн дүн, хариуцлага хүлээсэн хүн байна уу л гэж асууж байгаа юм.

Тэгээд ер нь яах вэ, Ерөнхий сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нар, ийм улсууд ажилд ийм хариуцлагагүй хандаад. Энэ чинь тухайн үеийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас гаргасан тогтоол төрийн өмчтэй холбоотой асуудал орж ирээд байхад чинь үүнтэйгээ холбоотой судалгаа хийчхээгүй л Улсын Их Хурлын чуулганд орж ирж байна гэдгийг цаашид анхаараарай.

Тэгээд ер нь одоо энэ тогтоолтой холбогдуулаад үе үеийн тэр БЭТ-үүдэд хариуцлага тооцох асуудлыг нь дагалдуулаад оруулаад ирж болох уу гэж санаачилж байгаа гишүүнээс асууя.

**С.Бямбацогт:** Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултад хариулъя. Хууль санаачлагч.

**С.Цэнгүүн:** Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн үндсэн агуулга маань ер нь Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа батлаад социализмын эдийн засгаас чөлөөт эдийн засаг руу шилжсэн байгаа.

Үүнтэй холбоотойгоор бид бүхэн маш олон олон улсын фактуудад гэрээ, хэлэлцээрт орж олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй. Тэр маань “хувь хүний эрх чөлөө болон хувийн өмчийг хамгаална” гэж заасан байдаг.

Тэгтэл энэ хувийн өмчийг хамгаалах болон хувь хүний эрх чөлөө болон хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах ёстой үндсэн фактаа бид бүхэн зөрчиж байгаа илрэл маань энэ хууль дээр тухайн онц байдал зарласан үйлдвэр болон байгууллага гэсэн нэрийдлээр тэр маань дан ганц төрийн өмчит үйлдвэрийн газрууд биш, мөн нээлттэй хувьцаат компаниуд, ХХК гэх мэт байдлаар төрийн бус байгууллагууд гээд маш олон бүх төрлийн байгууллагууд дээр энэ БЭТ-ийг томилох хаалга нь нээлттэй байгаад байгаа. /минут дуусав/

**С.Бямбацогт:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/  
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна. Алга байна. /алх цохив/

Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

**М.Ганхүлэг:** Өдрийн мэнд хүргэе.

Ер нь болиулах, зогсоох бол амархан. Аливаа юмыг шууд ингээд ер нь больё гээд, эсвэл томоохон төслүүд явж байгаа асуудлуудыг “за больё, больё”, энэ болохгүй юм байна гэдэг ийм хандлага руу улсаараа сүүлийн үед орох вий дээ гэдэг ийм байдал ажиглагдаж байна.

Түгжрэлийг бууруулах төслүүд ч тэр, нийслэлийн томоохон төслүүд ч тэр, мега төслүүд ч тэр ерөөсөө юм хийе гэдэг нэг талын ойлголтууд байгаад байдаг. Дандаа улс төрийн тодорхой асуудлаас болоод нүүр тулдаг нөхцөл байдлууд бий болж эхэлж байна. Энэ дээрээ гишүүд маань доор бүрнээ дүгнэлт хийх нь зөв байх гэж бодож байна.

Ер нь ч Монгол Улс эдийн засгаа хөгжүүлэх юм уу, үгүй юм уу? Тодорхой энэ төрийн өмчит компаниудын засаглал юмнуудаа сайжруулах юм уу, үгүй юм уу?

Ерөнхий сайд маань өөрөө нэг бие даагаад үйл ажиллагаагаа явуулах боломж, бололцоонуудыг нь олгох юм уу, үгүй юм уу? Тэгээд бүх зэвсэг, бүх юмыг нь хурааж аваад өөрт нь байгаа боломжуудыг нь ингээд авахаар яах юм доо гэсэн ийм ерөнхий ойлголт байна.

Зөвхөн нэг талаас нь хараад хэрэггүй байх. Яах вэ, энэ хуулийн хэрэгжилттэй холбогдолтой хоёр хувааж хармаар юм шиг байгаа юм.

Ерэн хэдэн оны тэр өмч хувьчлалтай холбогдолтой асуудал дээр БЭТ-үүд томилж, хувийн ашиг сонирхлоор шилжүүлэхээс авхуулаад олон асуудал үүссэн. Энэ тухай бид янз янзын л мэдээлэлтэй байгаа.

Тэгээд үүнийг ер нь тэгэхдээ цаашдаа шалгадаг, ил тод болгодог энэ асуудал дээр явах нь зөв. Тухайн үед илүү мэдээлэл ойр байгаа байдал, давуу байдал олгосон зүйлүүд байгаа. Үүнийг бүгд мэдэж байгаа.

2019 оноос хойш 9 газарт очсон. Энэ дээрээ маш нарийн дүгнэлт Та хэд маань хийгээч ээ.

Ер нь ковидын хүнд үе болон сүүлийн жилүүдийн эдийн засгийн тодорхой өсөлтүүд бас энэ онцгой арга хэмжээнүүд авснаас үүдэж эерэг гарсан зүйлүүд бас байгаа. Та хэдийн үзэл баримтлал дээр ч гэсэн орсон байна.

- “Эрдэнэс Тавантолгой” компани 1.3 сая тонноос 3.2 сая тоннд хүрч экспортын хэмжээ нэмэгдэхэд нэлээн түлхэц өгсөн байна.
- Эрдэнэт үйлдвэрийн төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн 2019 онтой харьцуулахад 1.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Бас яах вэ, ингээд сайн давуу талууд байна.

Тэгэхээр би дэмжих, үгүйгээ хэлэлцүүлгийн шатад шийднэ. Одоогоор би тодруулж асуух зүйлүүд байгаа юм.

Нэмэлт минутаа авна.

Нэгд, одоо ер нь төрийн өмчит компаниудын бүтээмж сайжруулахтай холбогдолтой зөвхөн энэ болиулахаас гадна өөр ямар шийдлүүд байх вэ? Цаашдаа хяналт тавих асуудлууд дээрээ бид ер нь ямар гарц гаргалгаа гаргах вэ гэдэг дээр бодож судалсан зүйлүүд байна уу?

**С.Бямбацогт:** Саруулсайханы Цэнгүүн гишүүн. Хууль санаачлагч хариулъя.

**С.Цэнгүүн:** Тэгэхээр энэхүү хуулийн агуулгаар нь бид бүхэн хараад үзэх юм бол эдийн засгийн агуулгаараа нэг талаасаа харж болж байгаа.

Нөгөө талаасаа хувь хүний эрхэд яаж энэ хууль маань зөрчилтэйгөөр үйлчлээд Монгол Улсын нийтлэг хэрэглэгдэж байгаа хууль тогтоомжуудаас хэрэгжихгүйгээр зөвхөн БЭТ-ийн гаргасан шийдвэр нь өөрөө хүчин төгөлдөр юм гэдэг энэ маш том ноцтой Үндсэн хуулийн зөрчил гарч ирээд байгаа нь бид бүхний анхаарах ёстой нэг зүйл байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэц дээр маргаанууд дэгдээж явсан. Тэрний нэг илрэл маань бол ер нь 1992 оны Үндсэн хууль батлагдсаны дараагаар ер нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үед ашиглаж байсан бүх хууль тогтоомжууд хүчингүй болоод Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцсэн байдлаар шинээр бид бүхэн хуулиудаа санаачлаад явсан.

Энд үүсэж байгаа үндсэн том асуудал маань Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль өөрөө БЭТ-ийн шийдвэрүүд дээр одоо жишээ нь хэрэгжихгүй явсан байгаа явдал нь өөрөө цаашдаа маш том эрсдэл байх үүд хаалгыг нээгээд байгаа юм.

Бид бүхэн БЭТ-ээр томилогдсон хүн хэн байхаас үл шалтгаалаад дараагийн ээлжид өнөөдөр тэр эрсдэл үүсээгүй ч гэсэн дараа дараагийн ээлж дээр ямар хүндрэлүүд гарч болох вэ гэдэг эрсдэлээ хараад өнөөдөр Үндсэн хуулийн эсрэг байгаа тэр зүйл дээрээ засаад явах шаардлагатай гэж харж байгаа.

Энэ хуулийг Үндсэн хуулийнхаа дагуу болгож хүчин төгөлдөр бус байдал нь болгоод, хүчингүй болгоод, үүнийхээ дараагаас бид төрийн өмчит компаниудынхаа засаглалыг сайжруулах дээр ажиллах ёстой.

Тэгээд энэ маань болохоороо Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар буюу төр маань өөрөө хувьцаа эзэмшигчийнхээ хувиар хяналтаа тавьж байгаа юм. Дээрээс нь ТУЗ-ийг томилж байгаа юм.

Тэгээд энэ “**гөлөөлөн удирдах зөвлөл**” нь өөрөө гүйцэтгэх захирлаа томилох буюу энэ төрийн өмчит үйлдвэрийн газрууд дээр ажиллаж байгаа бүх удирдлагыг томилж байгаа этгээд нь өөрөө төр байгаа. Тэр утгаараа төрд эрх мэдэл багадаагүй гэдэг агуулга эндээс харагддаг.

Мөн адил БЭТ-ээр томилогдож байсан хүмүүс маань ч гэсэн өмнө нь ТУЗ-ийн гишүүн байж байгаад тухайн газраа БЭТ-ээр томилогдсон гэх мэт жишээнүүд харагддаг.

Ингээд ирэхээр манай төр маань өөрөө ямар нэгэн байдлаар засаглаж чадахгүй байгаад байна. Төрийн өмчит компаниуд дээр үүссэн энэ их өр, авлага гэх мэт асуудлуудаа цэгцэлж чадахгүй байна гэдэг нь бид ер нь энэ төрийн өмчит компаниудаа яаж цаашид удирдах юм бэ гэдгийн хамгийн том асуудал.

Үүнийг бас үүсгээд байгаа нэг том илрэл нь энэ БЭТ гэдэг давхар тогтолцоо буюу давхар нэг үүд хаалгыг нээж өгөөд байгаа юм. Энэ маань өөрөө хариуцлага хүлээх этгээд биш болгоод явдаг.

Одоо бид ТЭЦ-3-ын жишээг харах юм бол хамгийн сүүлд 2025 оны 6 сард томилогдсон БЭТ-ийн үйл ажиллагаанаас харахад тухайн ТЭЦ дээр үйл ажиллагаандаа тухайн 6 сарынхаа хугацаанд тухайн дэлбэрэлт болсон ажлыг сайжруулна гэж очсон байдаг. 9 сард тухайн дэлбэрэлттэй холбоотой барилгын ажлыг бүрэн гүйцэд хийх зорилгоор тэр хүн томилогдсон.

Гэтэл 11 сар болоход ТЭЦ дээр нөгөө барилгын ажил дуусаагүй. Нөгөө эмэгтэй ажилчид нь турбинуудаа хучлага хийж оёод ингээд... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Тодруулъя. М.Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** БЭТ-ийн үйл ажиллагаан дээрээ зөв дүгнэлт хийгээсэй гэж бодож байна. Яг одоо сайн болон сул талуудыг нь ил гаргаад, шаардлагатай хариу арга хэмжээ авах зүйлүүд дээр нь анхаарах нь зөв гэж бодож байна.

Яах вэ, миний гол яриад байгаа зүйл бол ер нь бид зогсооно, болиулна гэдэг хандлагаас илүүтэй яг ямар шийдлүүдийг бид ер нь санал болгох вэ гэдгээ харж байж шийдвэрүүдээ бид гаргамаар байгаа юм.

Яалт ч үгүй тодорхой эдийн засгийн тоон үзүүлэлтүүд энэ дээр байж байна. Тодорхой үр дүнгүүд гаргасан боломжууд байж байна.

Ер нь хурдтай байх боломжийг олгож байгаа эерэг ийм зохицуулалтууд байна. Болиулах амархан. Энэ байгаа орон зайг бид юугаар яаж нөхөх вэ? Энэ дээр ямар шийдлүүд байж болох вэ гэдгийг тухай л голчилж асуугаад байгаа юм.

Яалт ч үгүй төрийн өмчит байгууллагуудыг бид сайжруулах шаардлагууд байна. Ганц хүн томилохоос илүүтэй бүр менежментийн олон улсын хараат бус багуудыг аваачиж ажиллуулах ийм хэрэгцээнүүд байна.

Тэгэхээр энэ шийдлүүдийг хэрхэн хийх, одоо байгаа... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч хариулах уу? Үг хэлсэн үү? Тийм ээ? Ажлын хэсгээс хариулъя. 3 дугаар микрофон.

**Э.Сундуй:** Сайн байцгаана уу? “Төв тусгал” судалгааны байгууллагын судлаач Э.Сундуй гишүүний асуултад хариулъя.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээрээ 1996 оноос өмнө Үндсэн хуульдаа нийцээгүй зүйл, заалтуудыг орчин үеийн хуулиараа зохицуулаарай гэдэг ийм зохицуулалт байгаа юм билээ.

Тэгэнгүүт энэ хуулийн үзэл баримтлал үндсэн зүйл, заалтууд нь Онц байдлын тухай хууль дээрээ орсон явж байгаа юм билээ.

Тэгэхээр энэ хууль маань нөгөө хоосон зохицуулалтгүй орон зай үлдэхгүй. Онц байдлын тухай хуулиараа зохицуулагдаад явах боломжтой юм билээ.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээрээ мөн төлөөлөгч томилж ажил үүргийг сайжруулах тухай зохицуулалт мөн байгаа юм билээ.

**С.Бямбацогт:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

**О.Номинчимэг:** Ер нь БЭТ-ийн хуулийг хүчингүй болгох хуулийг дэмжиж байгаа. Бидний хэдэн нөхөд ч гэсэн яг адилхан агуулгатай энэ хуулийг хүчингүй болгоё гэдэг хуулийг өргөн барьсан байгаа.

Тэгэхээр хүчингүй болгох нь зөв. Үүний учир шалтгаан нь яг сая хэлсэн. Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуульдаа нийцсэн зарчмаар хууль, тогтоолуудаа бид гаргаж явах ёстой.

Тэгээд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үеийн 1991 оны хуулийг бид хүчингүй болгох нь зөв.

Ер нь яах вэ сая олон л хүмүүс хэллээ. Манай Ардчилсан намынхан ч гэсэн хэллээ. Хувийн хэвшил рүү дайрсан ийм юм болох гээд байна. Хүний эрх гээд.

Гэхдээ яах вэ бид хууль санаачлагчийн өөрийнх нь мэдээлэл ч гэсэн байна. Яг ямар үед тогтоож байсан юм гээд харахаар бүгдээрээ л юу гэдэг юм “Улаанбаатар төмөр зам”, МИАТ, Монголросцветмет, Эрдэнэт үйлдвэр гээд бүгдээрээ төрийн өмчит, эсвэл орон нутгийн өмчит компаниуд руу л ярьсан.

Тэгэхээр бодит байдлыг бид хэлээд одоогоор сүртэй хувийн өмч гэж хэлээд байх компани дээр нэг их БЭТ томилсон юм харагдахгүй байна. Тавантолгой ХК-ийн хувьд орон нутгийн өмчит компани гэж явдаг. Яаж явж байгаад ийм нөхцөл байдалтай болсоныг нь зарим хүмүүс маш сайн мэдэх байх.

Хөрөнгийн биржээр юу болоод одоогийн байгаа Тавантолгой ХК-д ийм орон нутгийн өмчит болон хувийн өмчийн компани болсныг бүгдээрээ мэднэ.

Яагаад энэ төрийн өмчит компаниуд дээр ер нь БЭТ-ийг бид 2019 оноос хойш нэлээн их болсон байна гээд хараад үзэх юм бол ерөөсөө төрийн өмчит компаниудын асуудал байгаа юм. Төсвөөс гадуурх төсөв буюу Улсын Их Хурлын хяналтаас. Өөрөөр хэлбэл иргэдийн хяналтаас гадуур тусдаа төсөв энэ төрийн өмчит компаниудаар бий болсон.

Тэгээд сүүлдээ тэр маань Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрт ч ордоггүй. Тэгээд биелүүлдэггүй. Тийм ээ. Нэг ийм вант улсууд болоод хувирсан байхгүй юу. Ерөнхийдөө байгалийн баялаг тойрсон эдийн засаг, улс төрийн бүлэглэлүүдийн ийм л зодооны нэг. Тийм ээ. Баялаг хуваарилалтын нэг хэрэгсэл болсон.

Тэгээд яах вэ дээ, Улсын Их Хурлынхаа гаргасан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлдэггүй, эсвэл энэ тэрүүгээр нь нөлөөлдөг. Аргаа ядаад энэ БЭТ-ийн хуулиар БЭТ тавиад энэ асуудлуудыг нь цэгцэлье л гэсэн ийм үйл ажиллагаанууд явсан.

Тэгэхээр ер нь бид энэ төрийн өмчит компаниудыгаа цэгцлэх асуудлууд дээр анхаарах нь зөв. Одоо ч гэсэн Улсын Их Хурал дээр энэ хууль явж байгаа. Энд нь ч гэсэн менежмент сайжруулах. Тийм ээ. Засаглалын асуудлуудыг нь оруулах ёстой гэж бодож байгаа.

Хууль санаачлагчаас нэг асуулт байна. Энэ БЭТ-ийн хуулийг хүчингүй болгож байгаа. Дэмжиж байгаа. Үүнийг дагасан хуулиар Онц байдлын тухай хууль дээр төрийн өмчит компаниудтай холбоотой бас нэг тодорхой заалтууд орж ирсэн байна л даа.

Тэгээд Онц байдлын хууль бол өөрөө Улсын Их Хурал гаргаад явдаг маш том дэглэмтэй хууль. Зөвхөн төрийн өмчит компанид гэхээсээ илүү нутаг дэвсгэрээр нь гаргаад онц байдал зарлаад дэглэмээ тогтоогоод явдаг.

Тэгэхээр энэ онц байдлын үед тусгайлан төрийн өмчит компаниудаар авах арга хэмжээг ингэж нарийвчилж өгөх нэгдүгээрт хэрэгцээ байгаа юу? Байгаа бол яагаад гэж бодож байгаа вэ гэдэг.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагчид хариулъя. Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

**С.Цэнгүүн:** Гишүүний асуултад хариулъя.

Тэгээд О.Номинчимэг гишүүнтэй санал нийлж байна.

Тэгэхээр Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын эрх олгох тухай хуулийг 1992 оны Үндсэн хуулиар хүчингүй болгоод миний ойлголтоор 1995 оны Онц байдлын тухай хууль дээр энэ үзэл санаа маань өөрөө бүтнээрээ ороод өгсөн байгаа.

Тэгэхээр энэ үндсэн байдал нь бид бүхэн Үндсэн хууль дээрээ ямар нөхцөл байдлыг онц байдал гэж зарлах вэ гэдгийг Үндсэн хууль дээрээ зааж өгсөн.

Тэгэхээр тухайн нөхцөл байдал хүнд байдлууд үүссэн тохиолдол дээр онц байдлын үеийн журмуудыг одоо жишээ нь Дайн байлдааны тухай хууль дээр мөн оруулаад өгсөн.

Өнөөдөр миний оруулж ирсэн дагалдах хуулиар оруулж ирж байгаа нь тухайн заалтуудыг илүү тодруулж өгч байгаа гэдэг агуулгатайгаар.

Түүнээс биш цоо шинэ үзэл санаа Онц байдлын тухай хууль дээр нэмж оруулаагүй. Эндээс манай ажлын хэсгээс нэмээд тайлбарлалаа өгье.

**С.Бямбацогт:** Ажлын хэсэг. 3 дугаар микрофон.

**Э.Сундуй:** Судлаач Э.Сундуй.

Энэ дээр Онц байдлын тухай хууль дээр тухайлбал Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль дээрээ зөвхөн өмчийн харилцаанаас илүү олон хүний эрхтэй холбоотой зохицуулалтууд байгаа.

Онц байдлын тухай хууль дээр тухайлбал онц байдлын үеийн нөхцөл байдлыг гаргасан шийдвэрийг дагаж мөрдөөгүй албан тушаалтныг огцруулна гэдэг зохицуулалт байсан.

Тэгэнгүүт тухайлбал онц байдлын хугацаагаар түдгэлзүүлэх гэдэг байдлаар илүү эрхийг нь илүү нээж, хүний эрхийг хамгийн бага хэмжээнд хязгаарлах зарчмыг оруулж ирсэн байгаа.

Мөн хөдөлмөрийн хуваарь, нормыг тодорхойлж өгөөгүй. Нэмж ажиллуулж болно гэдэг зохицуулалт байсныг мөн Хөдөлмөрийн хуулийн 84.4-д байсан долоо хоногийн ажлын дээд хязгаарыг 1.5 дахин нэмэгдүүлэх байдлаар зохицуулж оруулж ирсэн.

Мөн хамгийн том зохицуулалт нь бид цаазаар авах ялыг хориглосон ийм улс. /минут дуусав/

**С.Бямбацогт:** О.Номинчимэг гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Онц байдлын тухай хууль маш нарийн дэг журамтай.

Тэгэхээр яах вэ бид онц байдлын үед ингээд ерөнхий нутаг дэвсгэрийн хүрээнд энэ асуудлуудаа Онц байдлын хуулиар яадаг.

Зүгээр миний хэлээд байгаа нь баялаг дагасан ийм бүлэглэлүүдэд баялгийн хуваарилалтын нэг хэрэгсэл болоод, энэ компаниуд өөрийн гэсэн вант улс болчихоод байгаа. Яах вэ, бид төрийн өмч, нийтийн өмчийн хууль болон төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын хууль дээр энэ асуудлуудыг зарчмыг нь оруулж задлах гэж хуулиуд дээр ажиллаж байгаа.

Гэхдээ яг энэ шилжилтийн үеийн гэдэг юм уу, одоо энэ төрийн өмчит компаниуд дээр төвлөрсөн байгаа энэ эрх мэдлийг задлахад тусгай дэглэм, онц байдал зарласнаас өөр шүү. Одоо тэр гамшиг байдаг юм уу. Тийм ээ. Үндсэн хуулийн дэг журам алдагдсан, нийгмийн тогтворгүй байдал гэдэг маш том ийм үндэслэлээр л бид онц байдалд ордог. Бас тийм амархан зарладаг нөхцөл байдал биш.

Тэгэхээр ийм нэг тусгай шилжилтийн үед Засгийн газар өөрөө энэ төрийн өмчит зөвхөн компаниуд дээрээ бас нэг арга хэмжээ авах дэглэмийн... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Анхаарах ёстой санал хэлж байна. Санал хэллээ.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/  
Ж.Баярмаа гишүүн. Алга байна. /алх цохив/  
Батбаярын Жаргалан гишүүн. Алга байна. /алх цохив/

Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн.

Уучлаарай 2 гишүүн асуулт асуугаад үндсэндээ энэ асуудал дуусахаар байна. Тийм болохоор үүнийг дуустал цагаа сунгая. /алх цохив/

**П.Наранбаяр:** Баярлалаа.

Тэгэхээр Бүгд Найрамдах Монгол Ард Улс гэсэн нэртэй бараг сүүлчийн хууль байх. Тийм ээ. Өнөөдөр хүртэл хүчин төгөлдөр хэрэглээд явж байсан Засгийн газарт эрх олгох тухай.

Энэ дээр бүрэн эрхт төлөөлөгч буюу БЭТ-ийг томилдог харилцаа 1991 оноос хойш хуульчлагдаад, үүнээс хойш 9 удаа хэрэглэжээ.

Ингээд хараад байхаар сүүлийн жилүүдэд томилогдсон БЭТ нь их олон удаан хугацаагаар сунгаж сунгаж ажилласан. Уг хуулийг нь харахаар 6 сарын хугацаатай л томилогдож байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ учир шалтгаан нь юу байсан юм? Энэ хуулийг санаачилсан улсуудаас асууя. Ямар онцлог харагдаад байна.

Хоёрдугаарт, ер нь зүгээр цаана нь төрийн өмчит үйлдвэрийн газрууд, төрийн өмчит компаниудын хариуцлагын асуудал яригдана. БЭТ томилоод тэгээд нөгөө хуучин удирдлага нь ажлаа хийдгээрээ л хийж л байдаг шүү дээ.

Тэгээд хэн нь ч хариуцлага хүлээхгүй. Тэгээд жишээлбэл ТЭЦ-3-ын удирдлага нь байсан уу. Байсан хэвээрээ. БЭТ нь очиж ажилласан. “Эрдэнэс Тавантолгой” ч гэсэн тэр. Ийм л нөхцөл байдалтай.

Уг нь үүнийг чинь тэр байгаа төрийн өмчит компани хувьцаат компани байдаг юм уу, үйлдвэрийн газрынх нь удирдлагуудтай шууд хариуцлагыг нь тооцоод үйл ажиллагаа явуулах эрх нь Засгийн газарт байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ хууль өөрөө хүчингүй болсноороо тэр Онц байдлын тухай хууль руу шилжинэ гэж байна.

Гэхдээ ер нь БЭТ томилоод л энэ харилцаа хэвээр үлдэх юм уу? Энэ харилцаа хэвээр үлдэх юм бол тэр төрийн өмчит үйлдвэрийн газар, компаниудад өнөөдөр байж байгаа удирдлага дээр нь хариуцлага тооцох энэ механизм чинь сул хэвээрээ байх юм шүү. Энэ асуултыг асуух гэсэн юм.

Ер нь цаашдаа олон улсад ийм жишиг байна уу гэдгийг бас асууя. Зүгээр миний мэдэхийн жишээлбэл “Alitalia” ч юм уу, Японы “JAL” ч юм уу, яг одоо манай “МИАТ” шиг компаниуд нь дампуурах болохоор ийм төлөөлөгч маягийн хүн томилоод ажиллуулаад.

Тэгэхдээ тэр нь ерөөсөө шууд тэр удирдлагуудыг нь өөрчлөөд л Засгийн газраас томилогдсон хүн нь очиж ажлыг сайжруулсан ийм туршлага байдаг.

Дампуурах гэж байгаа газрууд дээр төлөөлөгч явуулж аж ахуйн нэгжийгээ дампуурлаас нь аварсан ийм тохиолдол харагддаг юм билээ.

- Манай дээр энэ нь яадаг юм?
- Манай дээр ямар байдаг юм?
- Хэдэн компанийг дампуурлаас нь аварсан юм?
- Ямар үр дүн гаргасан юм?

Энэ зүйлийг асуух гэсэн юм. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Хууль сануулж хариулах уу? Хэн хариулах вэ? Ажлын хэсэг. Индрийн 3 номерын микрофон.

**Э.Сундуй:** Гишүүний асуултад хариулъя.

Энэ дээр манайх Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт юу гэж заасан гэхээр “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль

болон бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно.” гэж заасан юм билээ.

Тэгэнгүүт бид үндсэндээ Онц байдлын тухай хуульд оруулсан нь миний ойлгож байгаагаар зөв юм байна гэж судалгааны ажлын хэсэг үзсэн юм.

Тэгээд түүнээс цааш авч үзэх юм бол гаднын жишгүүд нь тухайлбал Герман, Польш зэрэг тохиолдлууд дээр бүрэн эрхт төлөөлөгч томилдог тохиолдлууд байна л даа.

Тэгэхдээ эд нар мөн адил нөгөө онц байдлын нөхцөл байдлаа үнэлж үздэг ийм тохиолдлууд байдаг юм билээ.

Манай дээр “Эрдэнэс Тавантолгой” дээр жишээлбэл 2 удаа онц байдал тогтоогоод 2 удаа сунгасан байгаа юм. Тэгэнгүүт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль дээрээ нэг удаа сунгаж болох зохицуулалт.

Тэр нь яагаад гэхээр дундаа үндсэн 2 удаагийн 6 сар нь дуусаад бүрэн эрхт төлөөлөгч томилоогүй байж байгаад ахиж томилж байгаа гэдэг ойлголт явсан ийм юм билээ.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Тодруулъя. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн.

**П.Наранбаяр:** Тэгэхээр ажлын хэсэг яг асуултад хариулаарай. Би хүний эрхтэй нь холбож асуугаагүй шүү. Тэрийг асуултад яг товчхон хариулахыг хүсье.

Зүгээр яах вэ, энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үеийн хууль одоо хүртэл үйлчлээд явж байгаа. Энэ бол зохимжгүй зүйл.

Зүгээр нөгөө талдаа цаана байгаа тэр төрийн өмчит компаниудын удирдлагуудад ямар механизмаар хариуцлага хүлээлгэх юм. Ер нь БЭТ гэдэг энэ тогтолцоо цаашаагаа Онц байдлын хуулиараа үргэлжлээд явах юм уу, үгүй юм уу? Үүнийг л асуугаад байгаа шүү дээ.

Онцын шаардлагагүй гэж би хараад байгаа юм. Ямар ч онцын шаардлагагүй. Тэр төрийн өмчит компаниуд дээр нь хариуцлагыг нь тооцоод илүү чадварлаг хүмүүсийг нь шууд томилоод явахад яахаараа заавал үүнийг ингэж ийм юм хийдэг юм.

Тэгэхээр ийм систем нь амь бөхтэй үлдэх юм уу, үгүй юм уу л гэж асуугаад байгаа байхгүй юу. Асуултад шууд хариулахыг хүсэж байна.

**С.Бямбацогт:** Хууль санаачлагч Саруулсайханы Цэнгүүн гишүүн хариулъя.

**С.Цэнгүүн:** П.Наранбаяр гишүүний асуултад хариулъя.

Тэгээд яалт ч үгүй манай Засгийн газрын чадамжгүй байгаатай л ерөнхийдөө шууд холбоотой асуудал л даа. Манай Засгийн газар уг нь өөрөө Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраараа дамжуулаад гүйцэтгэх захирлуудаа томилдог.

Гэтэл өнөөдрийн Засгийн газар жишээ нь “Эрдэнэс Тавантолгой” дээр 2 удаагаар БЭТ томилоод, тэрийгээ 2 удаа сунгасан байгаа юм.

Тэгэхээр 2 жилийн хугацаанд Гүйцэтгэх захирал томилж ажиллуулж чадах чадамжгүй байгаа гэдэг маань өнөөдрийн манай үүсээд байгаа үндсэн асуудал л даа. Яагаад гэхээр төрийн өмчит компани дээр чинь төр л өөрөө, Засгийн газар л өөрөө хүнээ томилох бүрэн эрх нь байж байгаа.

Тэгэхээр өөрсдөө хүнээ томилоод, өөрсдөө тэр хүндээ Компанийн тухай хуулийн дагуу, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажил, үүрэг дээр нь үнэлж тавьж явж чадахгүй байгаа нь өнөөдөр манайх тогтолцоогоороо засаглалынхаа хувьд чадамжгүй болсоны нэг илрэл нь харагдаад байгаа.

Түүнчлэн тухайн компаниудыг нь хараад үзэхээр дандаа маш ашиг орлого өндөр... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулъя. С.Цэнгүүн гишүүн.

**С.Цэнгүүн:** Үндсэн жишгийг нь хараад үзэх юм бол ашиг орлого өндөртэй уул уурхайн компаниуд дээр төрийн өмчит компаниуд дээр тавьдаг жишигтэй байсан.

Тэр маань өнгөрсөн жил эвдэгдсэн буюу эрчим хүчний компани дээр тавьж эхэлсэн. Энэ нь өөрөө маш том аюулын дохиог бас харуулж байгаа зүйл маань энэ янзаараа бид бүхэн маань бүх төрлийн компаниудын үйл ажиллагаан дээр оруулаад. Өмнө нь яагаад тэгвэл тухайн эрсдэл үүсэхэд, яагаад өмнө нь төрийн өөрийнх нь томилсон байгаа захирал нь ажлаа хийхгүй байхад тэр хүнтэй хариуцлага тооцож чадахгүй байсан юм. Аудитын дүгнэлтүүд яагаад хэрэгжихгүй байгаа юм гэх мэт хариуцлагын тогтолцоонуудыг байхгүй болгоод БЭТ томилсон гэдэг нэрийдлээр хариуцлагаас зугтах энэ хаалга болчихоод байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр бид энэ хаалгыг эхний ээлжид ямартай ч хаах зайлшгүй шаардлага үүсээд байгаа.

**С.Бямбацогт:** Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя.

**Ж.Золжаргал:** Төрийн өмчийн компаниуд дээр БЭТ томилогдоод тэгээд улсад төвлөрүүлсэн татварын орлого нэмэгдсэн, борлуулалт нэмэгдсэн гээд

түрүүн мэдээлэл хэлнэ лээ. Нүүрсний хулгай яриад, дараа нь “Эрдэнэс Тавантолгой” дээр жишээ нь иймэрхүү үзэгдэл болж л байсан л даа. Бусад компаниуд дээр ч гэсэн. Зарим дээр нь муу, зарим дээр нь сайн юм гарсан байна лээ. Тэгэхээр бүр нэг огт үгүйсгэсэн юм байхгүй.

Гэхдээ ийм яаралтай арга хэмжээ авах, бушуухан нэг юм хийх бүрэн эрхийг олгож байгаа буюу нийтээр нийтлэг мөрдөгддөг хуульд харьяалагдахгүйгээр үйл ажиллагаа явуулах онцгой эрх. Ийм онцгой эрхээр ажилладаг цаг хугацаа ер нь өнөөдрийн хүрээнд дуусаж байгаа. Цаг нь дууссан учраас ер нь дуусах нь зөв юм гэж бодож байгаа юм.

Онцгой бүрэн эрх өгөх нь яагаад эрсдэлтэй байдаг вэ гэхээр бид чинь ардчилсан нийгэм байгуулж байгаа. Хуулийн засаглал гэж зүйл байна. Хуулийн засаглал дээр зохицуулахгүйгээр шууд даргын чиг үүргээр гэсэн үг шүү дээ. Одоогийн хэллэгээр дарга бол сонгуулийн үр дүнд байсан намын томилгоогоор гарч ирнэ.

Тэгэхээр энэ бол ийм улс төрийн өнгө аястай ашиглагдах том эрсдэл хэвээр байгааг харуулж байгаа.

Анхны “бүрэн эрхт төлөөлөгч” гэдэг үг чинь угаасаа нөгөө ардын комиссариатаас гарсан агуулгатай утга. Энэ бол хувьсгал тэмцэл, нийгмийн журам өөрчлөгдөж байх үед юун хууль. Яаралтай тэр ард түмний төлөөлөл болсон комиссариатаас төлөөлөл гаргаж арга хэмжээ авах.

Тэгэхээр тэр цаг үе нь ч өнгөрсөн байна. 1991 оны хууль, тэгээд шинэ Үндсэн хууль. Үүнтэйгээ өөрөө агуулгын хувьд нийцэхээргүй болсон. Тийм ер нь өөрчлөх цаг нь болжээ.

Тэгээд онцгой байдал, гамшгийн нөхцөл байдал үүсэх, дайн тулаан юу болдог юм. Тэр үед мэдээж төрийн хяналт байх ёстой. Тэр нь онцгой байдлын тухай хуулиараа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиараа зохицуулагдах. Түүн дээр хэрвээ шаардлагатай зүйл байвал бид нэмэлт, өөрчлөлтийг бодох ёстой байх гэж бодож байна.

Тэгээд хуулийн энэ төсөл хэлэлцэх эсэх нь шийдэгдээд хэлэлцэхээр болох юм бол ажлын хэсэг гарч таарна. Би ажлын хэсгийг ахалж ажиллах саналтай байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Үг хэллээ.

Энэ хуультай ижил төстэй хууль П.Сайнзориг нарын гишүүн санаачилсан байгаа.

Тэгээд тэр хуулийн хэлэлцэх эсэх нь шийтгэсний дараа ажлын хэсэг байгуулах эсэх, нэгтгэж ажлын хэсэг байгуулахаар бол нэгтгэж хэлэлцэх асуудал

яригдана гэдгийг хэлье. Тэр үед Ж.Золжаргал гишүүний саналыг хүндэтгэн үзье. Харгалзан үзье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаг баг гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. /алх цохив/

Ч.Лодойсамбуу гишүүн. Алга байна. /алх цохив/

Х.Тэмүүжин гишүүн. Алга байна. /алх цохив/

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцогдох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалтыг 16.00 цагаас болгоё. Одоо гишүүдийн ирц хангалтгүй байна.

Тийм учраас 16.00 цагаас түрүүний хууль байж байгаа. Тийм ээ. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл. С.Цэнгүүн нарын гишүүдийн санаачилсан хуулийн төслийн санал хураалтуудыг 16.00 цагаас явуулна.

Гишүүдийг чуулганы хуралдаандаа идэвхтэй, цагтаа ирж оролцохыг хүсэж байна. Үдээс өмнөх чуулганы хуралдаан завсарлалаа. /алх цохив/

Үдээс хойш 14.00 цагаас Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл. Улсын Их Хурлын асуулга, сонсголын цаг 14.00 цагаас эхэлнэ.

14.00 цагаас Ерөнхий сайдын мэдээлэл, 16.00 цагаас үлдсэн асуудлаа санал хураалтаар үргэлжлүүлнэ.

## ЗАВСАРЛАГА

### Зургаа.Улсын Их Хурлын асуулгын цаг

**С.Бямбацогт:** Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.1-д ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайдад хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна гэж заасан.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна.

Энэ дэгийг уншаад танилцуулах нь зөв байх. Манай оролцогч нар дэгээ баримтлахыг хүсье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.1-д ээлжит чуулганы хугацаанд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаан гишүүдээс Ерөнхий сайд хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний биелэлт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар асуулт тавих Улсын Их Хурлын асуулгын цаг байна.

Мөн хуулийн 112.2-т гишүүд Ерөнхий сайд тавих асуултаа асуулга болохоос долоо хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлэх бөгөөд ирүүлсэн асуултыг нэгтгэн Улсын Их Хурлын дарга Ерөнхий сайдад ажлын 2 өдрийн дотор хүргүүлж асуултыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулна.

Мөн процессууд хийгдсэн байгаа.

Мөн хуулийн 112.3-д Улсын Их Хурлын асуулга, түүнд өгөх Ерөнхий сайдын хариултыг Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

Мөн хуулийн 112.4-д Улсын Их Хурлын асуулгын цагт Ерөнхий сайд өөрөө биечлэн хариулт өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газрын гишүүн нэмэлт хариулт өгч болно.

Мөн хуулийн 112.5-д Улсын Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75 минутаас, олонхын бүлэгт 15 минутаас, цөөнхийн гишүүд 30 минутаас хэтрэхгүй байна гэж тус тус заасан.

Ийм дэгээр асуулгын цаг асуудлаа хэлэлцэх нь.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал нарыг тусгайлан бэлдсэн индэрт урьж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавьж мэтгэлцэнэ.

Бүлгийн цуварсан асуултын тоо 9-өөс хэтрүүлэхгүй.

Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. /алх цохив/

Асуулт асуух зөвшөөрлийг өгч мэтгэлцээнийг эхлүүлье.

**О.Цогтгэрэл:** Гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Өнөөдрийн Улсын Их Хурлын асуулгын цаг “АВЛИГАЛ” гэсэн сэдвийн хүрээнд товлогдсон.

Сүүлийн үеийн магадгүй 10 жилийн нөхцөл байдлыг үнэлэхэд Монгол орныг дэлхий нийтээрээ ардчиллын нэг арал гэж үздэг байсан бол одоо энэ “Ардчилсан Монгол Улс” биш, “Авлигажсан Монгол Улс” гэж үзэхээр түвшинд Монгол Улс очлоо.

Энэ нь олон улсын үнэлгээ, индексүүдээр ил тод харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд авлигалын индекс, төсөөллийн индексүүдээр олон арван байраар ухарч байна.

Дотоодод гарч байгаа авлигалын тоо хэмжээ, хэргийн тоо, мөнгөн дүнгийн асуудал, энэ бол зах замбараагаа алдлаа. Авлигал гэдэг зүйл Монгол Улсад хэвийн соёл болж хувирлаа.

Сүүлдээ бид бүгд цочирдохоор ч байсан. 60 тэрбумаар эхэлсэн авлигалын хэрэг, сүүлд нь ногоон автобус, нүүрсний хулгай, ЖДҮ, концесс. Одоо сүүлд нь 110 сая доллар. Эзэн биетэй Ерөнхий сайд байсан хүн гарч ирээд хэлж байдаг. Цаг хугацаатай, эзэн биетэй ярьж байдаг. Тэрийг тоож байгаа амьтан ч алга.

Авлига Монгол Улсад одоо энгийн хэм хэмжээ, соёл, амьдралын нэг хэсэг болоод хувирлаа. Энэ одоо юу болж байна вэ?

Монгол Улс авлигажсан Монгол орон болж хувирч байгаа олон улсын болоод дотоодын нөхцөл байдал, энэ зүйлтэй Монгол Улсын Ерөнхий сайд Та энэ дүгнэлттэй санал нийлж байна уу?

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд Н.Учрал хариулъя.

**Н.Учрал:** Авлига бол бүх ард түмний эдлээгүй боломж, идээгүй талх, биелээгүй мөрөөдөл.

Тийм ч учраас эрх чөлөөний 4 зам, 4 чөлөөлөлт гэдэг бол авлигыг уг үндсээр нь устгая л гэсэн санаачилга байсан.

Тэгээд би яг Танд үнэнийг хэлэхэд авлигын гэмт хэргийг бууруулах, авлига дээр дорвитой өөрчлөлт гаргая гэвэл би өнөөдрийн тогтолцоогоор үр дүнд хүрэхгүй гэж үздэг.

Тийм ч учраас бид нэг зүйлийг ойлгох ёстой. Авлигатай тэмцэх газрын ганцхан ажил биш. авлигатай тэмцэх санал санаачилга бол.

Авлигын төсөөллийн индексийг 10 байраар ухарсан дээр дүгнэлт хийгээд үзэхэд 8 ресурс л байгаа юм билээ.

Тэгэхээр бид авлигыг уг үндсээр нь устгахын төлөө ажиллах нь өөрөө төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд, бүх ард түмний санал санаачилга, хүсэл эрмэлзэл байх ёстой.

- Авлигатай тэмцэх газар авлигатай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээж авдаг, хянан шалгадаг, мөрдөн шалгадаг байгууллага.
- ▶ Прокурор бол хяналтаа тавьдаг.
- ▶ Шүүх бол гэм буруутайг нь тогтоодог.

Засгийн газар гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэгтэй. Засгийн газар мэдээ мэдээллээр хангаж, уг үндсээр нь устгахын төлөө бодитой санал, санаачилгыг гаргаж ажиллаж байж үр дүнд хүрнэ.

Тийм ч учраас өнгөрсөн хугацаанд Засгийн газрын зүгээс хууль хяналтын байгууллагууд руу маш олон нотлох баримттай, үндэслэлтэй мэдээ, мэдээллүүдийг илгээж байсан нь өөрөө тэр хууль хяналтын байгууллага дээр очоод гацдаг, шийдэгддэггүй байдаг гэдэг ийм асуудал үүсдэг.

Тийм учраас Ерөнхий сайдын хувьд дэвшүүлж байгаа бодлогынхоо хүрээнд энэ зөвшөөрлийн хууль, 110 зөвшөөрлийг мэргэжлийн холбоодод өгөх. Эрх мэдлийг сааруулах.

Тэгэхээр Засгийн газар эрх мэдлийг төвлөрүүлдэг биш иргэдийнхээ эрх чөлөөг хамгаалдаг эрх мэдлийг сааруулсан бодлогыг хэрэгжүүлэхээ би ажил хэрэг болгоод ажлаа эхлүүлж байгаа.

**О.Цогтгэрэл:** Монгол Улсад авлигал амьдралын нэг хэсэг, ардчилсан Монгол орон биш, авлигажсан Монгол орон болжээ гэдэгтэй Та санал нийлж байна уу гэж уг нь тодорхой асуусан. Та тойруулаад өөр юм яриад явлаа.

Би Таны өмнө нь бас нэг хурал дээр хэлж байсан үгийг чинь энд сануулъя. Та “Авлигал Монгол Ардын намыг идлээ”, авлигал нь билүү, Монгол Ардын нам билүү энэ улсаа идлээ гээд нэг үг хэлж байна лээ.

Тэгэхээр бүгдийг дүгнэхэд Таныг би авлигал, авлигажсан Монгол орон болжээ гэдэгтэй санал нийлж байгаа байх гэж бодож байна.

Тэгээд дээрээс нь Таны хувьд гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг Ерөнхий сайдын хувьд ногдож байгаа.

Нөгөө талаасаа сүүлийн 3 парламентын сонгууль дамжаад үнэмлэхүй засаглаж байгаа эрх баригч намын даргын чинь хувьд “авлигал” гэдэг зүйл Таны чиг үүрэгт онцгойлон хамаарна гэж бодож байна.

Тэгээд дээрээс нь өнөөдрийн асуулгын болоод мэтгэлцээний сэдэв өөрөө “авлигажуулсан” гэж.

Авлигажсан Монгол, авлигажуулсан гэдэг хоёр үгэнд арай өөр утга байгаа байх гэж бодож байна.

“Авлигажуулна” гэдэг нь –

- санаатай,
- зохион байгуулалттай,
- системтэй үйл явц чинь явжээ.

Санамсаргүйгээр хэдэн хулгайч авлига авсан асуудал энэ жилүүд чинь биш ээ. Санаатай юм байна.

Санаатай гэдэг нь жишээ нь Нууцын хууль. Яг одоо энэ төсвийн тэлэлт, авлигын гэмт хэргийн тоо гээд хоёр зүйл графикийг нь UBN сайт гаргасан байна лээ.

Санаатайгаар Нууцын хуулийг өөрчилж, хаалттай, нууцаар авдаг, шууд гэрээ хийдэг нөхцөл бололцоог эрх баригчид бүрдүүлээд, санаатайгаар авлигажуулах үндэс суурийг тавьж 2017 оноос эхэлж авлигын гэмт хэргийн тоо энэ хойно нь байгаа хар багана төсвөөс үндсэндээ ингэж эрс өсөж эхэлжээ.

Тэгэхээр үүнтэй Та санал нийлж байна уу?

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд Ням-Осорын Учрал хариулъя.

**Н.Учрал:** Тийм. Авлигын эсрэг тэмцэл бол авлига ч гэж хэдэн хүн цохож тэмдэглэхдээ биш.

Тийм ч учраас би авлигатай тэмцэх бодлого бол Засгийн газрын тэргүүлэх ажил байна гэдгийг би Танд хэлье.

Тийм ч учраас авлига нөгөө Ардын намын дайсан, Ардчилсан намын дайсан ч биш. Бүх ард түмний Монголын дайсан.

Тэгэхээр авлигатай тэмцэх тэмцлийг бодит үр дүнд хүргэхгүйгээр урагшлахгүй.

Тийм ч учраас тогтолцооны хувьд би 2016 онд Их Хуралд орж ирснээсээ хойш авлигатай тэмцэх ажил дээр үр дүн гаргаж ирсэн.

Өнөөдрийн хэрэгжиж байгаа Улсын бүртгэлийн багц хууль. Өнөөдөр иргэд авлига, ашиг сонирхлын холбоотой хэн энэ тендерт ялсан байна вэ гэдгийг **OPEN DATA** дээрээс хардаг болсон. Энэ хуулийг ахалж ажиллаж байсан.

- ◆ Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулиар 680 төрлийн мэдээллийг ил болгосон.
- ◆ Шилэн ажиллагаагаар 820 мянган мэдээллийг ил болгосон.

Түүний хүчинд өнөөдөр **ChatGPT**-гээр кирилл үсгээр бичээд ард түмэн хайлт хийж байгаа. Дүн шинжилгээ хийлгэж чадаж байгаа.

Эхлүүлсэн ажлаа үр дүнд хүргэх гэж би Ерөнхий сайд болсон.

Тийм ч учраас авлигатай тэмцэх бодлого гэдэг бол уг үндсээр нь шийдвэрлэх бодлого юм.

Тэгэхээр Таны хэлсэн би тэр намынхаа хурал дээр хэлж байсан. Бодол санаанаасаа хэзээ ч ухраагүй. Өнөөдөр Монголд юуг ч нууцлах эрх байхгүй.

Тийм учраас өнөөдөр Засгийн газраас Их Хуралд барьсан байгаа Төрийн албаны нууцын хуулиар ил болох ёстой.

Цахимжилтын төлөө, ил тод байдлын төлөө санал санаачилга гаргаж ирсэн хүний хувьд үр дүнгээ ахиулах гэж байгаа юм. **E-mongol** дээр 1480 үйлчилгээ бий болсноороо **“Нээлттэй засгийн түншлэл”** Эстонид очиход танай авлигыг бууруулах хамгийн зөв шийдэл чинь энэ шүү гэж хэлж байсан.

Тийм ч учраас цаашдаа **“Шилэн ажиллагаа”**-г илүү үр дүнд хүргэнэ.

Сая 146 зөвшөөрлийг 5 даваа давдаг байсныг болиулахад маш олон хүн эрх мэдлээсээ салж бухимдаж байгаа. Гэсэн хэдий ч үүний цаана нөгөө авлига,

албан тушаалын хэрэг, нөгөө бие биеэ заавал найрч 5, 10 цаас өгч асуудал шийддэг байдал таслан зогсож байгаа.

**О.Цогтгэрэл:** Би уг нь өнгөрсөн хугацааны л асуулт л Танд тавиад байна л даа. Яагаад ийм системийн авлига бий болчихов оо?

Үүнийг чинь—

- системтэйгээр,
- зохион байгуулалттайгаар,
- санаатайгаар—

-авлигалын тогтолцоог чинь эрх баригч танай нам өнгөрсөн 10 жилд бий болголоо.

Хуулийн хулгайг хулгайчидтайгаа нийлж хийнэ гэдэг чинь энэ чинь мафижсан тогтолцооны 10 жил байсан юм биш биз дээ гэдэг өнгөрсөн хугацааг асуусан. Та ирээдүй цагийн өөрчлөлтийн тухай яриад байна.

Тэгэхээр ирээдүй цаг дээр гэвэл бид эхлээд шалтгаанаа оношлох ёстой. Шалтгаанаа оношилж байж эмчилгээгээ хийгдэх ёстой.

Тэгвэл энэ авлигалын шалтгаан маань юу вэ гэдэг асуултад оношоо бид эхлээд зөв тавих ёстой гэж бодож байна. Шууд эм тариа болж гүйвэл үр дүнд хүрэхгүй.

Тэгэхээр авлигалын шалтгаан маань хаана байна гэж Та дүгнэдэг вэ? Миний хувьд авлигалын шалтгаан нь төрийн эдийн засаг дахь оролцоонд байна.

Одоо яг энэ график дээр их тодорхой харагдаж байна лээ. 2017 оноос эхлээд, 2018 оноос эхлээд өмнөх жилд нь авлигалын гэмт хэргийн тоо 400 байсан бол шууд даблдаад мянга гараад эхэлсэн. Яг үеэс эхлээд төсвийн тэлэлт ийм хэмжээгээр явагдаж эхэлсэн.

Тэгэхээр авлигалын үндсэн шалтгаан чинь —

- ▷ **Нэгдүгээрт,** —эдийн засаг дахь төсвийн хэмжээ;
- ▷ **Хоёрдугаарт,** —төрийн өмчит компаниудын эдийн засагт эзэлж байгаа тоо хэмжээ;
- ▷ **Гуравдугаарт,** —тусгай зөвшөөрлийн тоо хэмжээнүүд нийлээд эдийн засагт эргэлдэж байгаа 10 төгрөгийн бараг 8 төгрөг нь болж байна.

Энэ 8 төгрөгийг буулгахгүйгээр бид хэчнээн гоё лоозон, олон олон зүйл яриад ямар ч үр дүнгүй. Өөрийгөө хуурч байгаа, бусдыг хуурч байгаа, бусдад шилний цаанаас чихэр долоолгож байгаа ийм л үйл явц.

Тэгэхээр энэ дээр бид лоозогнохгүйгүйгээр гоё сайхан зүйл ярьцгаах биш, энэ дээр бодит өөрчлөлт хийхгүй юм бол бүх зүйл худлаа шүү.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд түр хүлээж байхгүй юу.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний урилгаар Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, амьдралд нь бүх сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** О.Цогтгэрэл дарга Та өөрөө хувийн хэвшлийн төлөөлөл хүн.

Тэгэхээр өнгөрсөн 10 жил, өнгөрсөн 20 жил, 30 жил гэж хоёулаа ярих нь зохимжгүй. Би зөвхөн ирээдүйг яриагүй, би өнгөрсөн, өнөөдөр ирээдүйг ярьж байна. Өнгөрсөнд хийж хэрэгжүүлсэн ажлаа цаашид ямар үр дүнд хүргэх вэ гэдгээ ярьж байгаа.

Тийм учраас энэ авлигын уг үндсийг устгах ажлуудыг Цахим хөгжлийн сайд байхдаа тэр 820 мянган мэдээллийг ил болгосон. Хэрэг эрхлэхийн дарга байхдаа ч тэр төрийн өмчит компанийн хууль, бүтээмж, засаглал, ил тод байдлын хуулийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Өнөөдөр Та бүхэн хэлэлцэх гэж байгаа төрийн албаны нууцаар би 894 албаны нууц гэсэн шошготой нууцуудыг ил болгох гэж байна.

Энэ бол авлигыг уг үндсээр нь шийдэх гэж байгаа асуудал. Хоосон ярих биш.

Тэгэхээр Та бизнесийн төлөөллийн хүн. Та бид хоёр яагаад улс төрд орсон бэ гэвэл өнөөдөр иргэд, аж ахуйн нэгжүүд тэр авлигын системд өртөөгүй хэн нэгэн иргэн байхгүй, хэн нэгэн аж ахуйн нэгж байхгүй, энэ хүнд суртал, дүрэм журам, саад тээгтэй учраагүй хэн ч байхгүй. Монголд тийм аж ахуйн нэгж байхгүй. Энэ болгоныг өөрчилье гэж, энэ болгоныг чөлөөлье гэж Та бид улс төрд орсон.

Тийм учраас манай, танай гэж ярих юм байхгүйгээр Ардчилсан нам засагт хамтраагүй ч гэсэн Авлигын эсрэг тэмцэлд хамтрах зөв санаа санаачилга гаргаж байгаад бол би Цогоо даргад их баярлаж байгаа. Та бид хамтдаа энэ асуудлыг уг үндсээр нь шийдэх ёстой.

Тийм ч учраас энэ төрийн албаны нууц, өнөөдөр 39 оффтэйкийн гэрээ ил болсон.

Цаашдаа гэрээ болгон ил тод, нээлттэй, олон нийтээр хэлэлцүүлж зөвшилцөж байж явдаг байхгүй бол бид том том төсөл нэрийн доор том том тендер хулгайлдаг, том том гоё гоё нэрний доор цаана нь ашиг сонирхол нь үнэртэж байдаг энэ байдлаар цаашаа урагшлахгүй.

Тийм учраас уг үндсээр нь устгая. Тэгээд тантай би санал нэг байна.

Одоо сая 146 зөвшөөрлийг зөвшөөрлөөс авч хаясан. Ард түмэн, иргэд юу хүссэнээ хөдөлмөрлөө хийе бүтээе гэдэг хүмүүс... /минут дуусав/

**О.Цогтгэрэл:** Саятай та Нууцын тухай хуулийг ярьж байна. Өнгөрсөн долоо хоногт Нууцын тухай хуулийг би бас өргөн барьсан. Засгийн газраас өргөн баригдаж байгаа гэж ойлгож байгаа. Хэлэлцүүлэгт ирэх долоо хоногоос орох нь уу. Бас хүлээгдэж байна.

Зөвхөн Нууцын тухай хуулийг гэхэд 2016 оны 12 дугаар сард батлаад тэр үед ямар улс төрийн хүчин ялаад гэдэг цаг хугацааг харж болно.

Төрийн нууцын тухай хууль байсныг “албаны” гэж нэмээд тухайн үед 60 орчим баримт бичгийг 60 орчим агуулгын хүрээнд парламентаас зөвшөөрч нууцад авдаг байсныг “Засгийн газар авдаг” болгож, хэмжээ хязгааргүй авдаг болгож, “албаны нууц” гэж нэмээд одоо тэр 60 байсан баримт бичиг, нууцын асуудал одоо 400 болоод “төрийн нууц” нь.

Албаны нууцын хүрээнд дахиад 400, 800 материал нууцад авагдсан байгаа. 60 байсан нь 800.

Тэгэхээр сөхөгдөж байгаа авлигалын асуудлуудад хэд нь ил болсон. Тэр 800-аас одоо хэчнээн асуудал нууцаас гараагүй байна гэдэг өөрөө дахиад л том асуултын тэмдэг.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр яаралтай энэ хуулийг нэгтгэж хуулийг хэлэлцээд, шаардлагатай бол нэгтгэж хэлэлцээд, яаралтай үнэхээр л авлигалтай тэмцэх гэж байгаа бол бид үндэс сууриар нь, шалтгаанаар асуудлыг хэдүүлээ ярихгүй бол хүн бид нарын уриа лоозон үнэхээр хэтэрч байгаа.

Авлигалыг хорт шарилж гэж үзвэл үржил шимтэй хөрс нь хэвээр, гарч ирсэн нэг жоохон оройн хэсгийг нь бид хадчихаад авлигалтай тэмцэж, улс төрийн шалтгаанаар хүссэн хэдэн нөхдүүдийгээ цовдолж харуулдаг. Хүсээгүй нь тэнд үржил шимтэй хөрсөнд ургаж байдаг энэ тогтолцооны нэг томоохон хэсэг нь дахиад тэр авлигажсан тогтолцоог бий болгосон нэг хэсэг нь тэр 2017 оноос эхэлж хэрэгжсэн Нууцын тухай хууль.

Тэгэхээр энэ хүрээнд учир шалтгаантай хийх бид нарт маш олон зүйлүүд байгаа. Энэ дээр хамтарч ажиллана гэдгийг хэлэх нь зүйтэй байх.

**Н.Учрал:** Өнөөдөр бол 2026 он.

2015 онд энэ Нууцын хуулийг өргөн барьж батлуулж байсан юм билээ. Тийм. 2016 онд.

Тэгвэл түүнээс хойш бид ямар олон асуудлыг нууц гэж тамга дарж хаав аа.

Тэгэхээр мэдээллийг ил тод, нээлттэй болгох нь асар их чухал.

Тэгэхээр авлигын төсөөллийн индекс чинь толь шүү дээ. Толь руу хараад өөрийгөө муу сайхан байна гэж хэн ч хэлдэггүй.

Тэгэхээр бид цаашдаа төрийн албаны нууцаараа энэ 800 гаруй мэдээллүүдийг ил болгох үүргийг өгөх ёстой.

Тухайн үед би санаачилж байсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) дээр ороод үзвэл Их Хурлын даргаар 4 сар ажиллахдаа би энэ Их Хурлын бүх мэдээллийг шилэн дээр байршуулсан.

Тэгэхээр энэ бол бодитой санал санаачилга. Та намайг уриа лоозон ярьж байна гэж бодож байх шиг байна. Би бодитой ажлуудыг хийж ирсэн хүн. Энэ ажлуудаа үр дүнд хүргэх гэж өнөөдөр Ерөнхий сайд болсон. Өнөөдөр 26 хоногтойгоо л би золгож байна шүү дээ.

Тэгэхээр энэ мэдээ, мэдээллүүдийгээ ил тод болгох ажлуудаа үе шаттай хийнэ.

Тэгээд Танд нэг зүйлийг хэлэхэд Та их ярьдаг. Эдийн засгийн харьцаа. Өнөөдөр манай дотоодын нийт бүтээгдэхүүн 10 жилийн өмнөхтэй харьцуулахад 5 дахин өсөөд байна.

Гэтэл манай дотоодын нийт бүтээгдэхүүний эдийн засгийн харьцаа буюу төрийн өмчит компани, төсөв хоёр нийлээд 61 хувь байхгүй юу.

Тэгэхээр хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүд төртэй хамааралгүйгээр бизнес хийж баялаг бүтээх ямар ч бололцоо байхгүй. Төрийн өмнө очоод хүнд сурталтай нүүр тулдаг.

Тэгэхээр энэ эдийн засаг дахь харьцааг өөрчлөхгүйгээр урагшлахгүй учраас Төрийн өмчит компанийн хууль, Бүтээмж, засаглал, ил тод байдлын хуулийг өргөн барьсан.

Ингэснээр улсын хэмжээнд байгаа 600 гаруй төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компаниуд 50 дахин буурна. Засаглалыг нь сайжруулна гэдэг энэ санаа санаачилгыг амилуулахын төлөө явна. –

- ▶ **Нэгд**, —Төрийн өмчит компани.
- ▶ **Хоёрт**, —blockchain дээр суурилсан data хяналтыг бий болгоно.
- ▶ **Гуравт**, —хиймэл оюунаар хяналтуудыг хийдэг болгоно.

Энэ бол эхлүүлсэн ажил. Үр дүнгээрээ Та бүхэнд хэмжүүлнэ.

**О.Цогтгэрэл:** Хамгийн гол нь эдийн засгийн оролцоо, саяын хэлдэг Та хэд төсөв болоод төрийн өмчит компани 60-аад хувь хүрсэн. Дээр нь нэмээд тусгай зөвшөөрлөөр ажил хийдэг. Дарга нарын гарын үсгээр ажил хийдэг гэсэн бизнес чинь нэмэгдээд бараг 80 руугаа явсан.

Цаана нь хувийн хэвшилд чинь үндсэндээ чөлөөт эдийн засгийг тунхагласан оронд 20-хон хувийн орон зай бүхий. Үүнийг эсрэгээр нь л бид бий болгохгүй юм бол энэ улс оронд чинь ирээдүй байхгүй болж хувирлаа.

Зөвхөн эдийн засгийн оролцооноос гадна энэ чинь дахиад иргэдэд очдоггүй, бизнесүүдэд очдоггүй ийм бизнесийн зохион байгуулалт л болоод хувирсан.

Эдийн засаг өсөж байна гэдэг. 4 хувиар өсөж байна, 5 хувиар өсөж байна гэдэг энэ өсөлт иргэдэд очдоггүй ийм л хулгайн эдийн засаг болоод хувирчхаж.

Түүний нэг нь одоо энэ зарим тоог харахад 2025 оны [tender.gov.mn](https://tender.gov.mn)-ийг харахад 43 их наядын үнийн дүн бүхий 18 мянган тендер зарлагдаж.

43 их наяд төгрөг гэдэг өнөөдөр байгаа эдийн засгийн 40 гаруй хувь нь. 40 гаруй хувь нь зөвхөн тендер зарлагдаж байна.

Зөвхөн 2023 оны тендертэй холбоотой гэхэд 100 гаруй эрүүгийн гэмт хэрэг шалгагдаж шалгалтын шатандаа явж байна гэдэг тоо байгаа юм байна. Энэ тендертэй холбоотой, төрийн худалдан авалттай холбоотой. Одоогийн байдлаар 100 орчим эрүүгийн шинжтэй гэмт хэрэг шүүх шатандаа явж байна.

Тэгвэл энэ тогтолцооны өөрчлөлт яг яаж хийгдэх вэ? Зөвхөн эдийн засагт төрийн худалдан авалттай холбоотой ийм худалдан авалт, үүнийг дагасан ийм тооны эрүүгийн гэмт хэрэг өнөөдөр шууд бүртгэгдээд л явж байна.

**Н.Учрал:** Тийм. Хувийн хэвшлийг дэмжихэд манай Засгийн газрын гол бодлого оршино. 10 төгрөг тутмын 7, 8-ыг хувийн хэвшилд шилжүүлэх нь “ЧӨЛӨӨЛБЕ” санаачилгын гол зорилт. Энэ тэгэхдээ бодитой ажил хэрэг.

Өнгөрсөн хугацаанд дүрэм, журам, саад, тээглэдэг байсан асуудлуудыг Зөвшөөрлийн хууль батлагдсаны дараа би зоригтойгоор 110 мэргэжлийн холбоонд шилжүүлнэ.

- 20 гаруй “тусгай зөвшөөрөл”-ийг “энгийн зөвшөөрөл” рүү хөрвүүлнэ.
- 146 үйлчилгээг чөлөөтэй явуулах эрхээр нь хангалаа.

“Ай Ти”-ийн (Information Technology) компаниудад “Ай Пи” (IP service, Internet Protocol) сервисээ бүгдийг нь нээж өгсөн.

Төр иргэндээ очиж үйлчилнэ. Энэ бол бодитой санал, санаачилга. Үр дүнгээ үзүүлнэ.

3 сарын дотор 146 үйлчилгээг хувийн хэвшилд аваачсанаараа ямар үр дүн гардаг вэ гэдгийг харуулна.

- Дүрэм засагладаг биш дата засагладаг болно.

— 820 мянган мэдээлэл дээр би 30 гаруй мянган өгөгдлийг боловсруулсан.

Орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан хүний оролцоогүй шийдвэр гаргадаг орчин үеийн кабинетыг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байгаа.

— 800 гаруй мэдээллийг би [e-cabinet](http://e-cabinet.gov.mn) (e-cabinet.gov.mn) дээр байршуулсан.

Тийм учраас төрийн албыг тайлангаас чөлөөлнө гэдэг бол эрх мэдлийн бууралт. Эрх мэдлийг сааруулах нь өнөөдөр улс оронд гэрэл гэгээ авчирна.

Эрх мэдлээ алдахад их олон хүн дургүй байдаг учраас их олон бухимдал үүснэ.

Тийм учраас Таны хэлж байгаа Тендерийн хуулийг би Хэрэг эрхлэхийн дарга байхдаа ахалж байсан. Одоо Их Хурлын гишүүдтэй хамтарч Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Хуультай хуульгүйгээр “Эрдэнэт” дээр хийсэн хиймэл оюуны тендерийн үйл ажиллагааг “Эрдэнэс Монгол” дээр нэвтрүүлэх ажлыг Цахим хөгжлийн зөвлөлийг байгуулж 2 жил бэлтгэл ажлыг хангуулсан. Бараг бэлэн болсон байна.

- ▶ “Эрдэнэс Монгол” компани дээр хиймэл оюун ухаанаар тендер зарладаг болно.

Энэ ажлууд бодитой ажил хэрэг болно. Хүний оролцоо хаана буурна тэнд авлига буурна.

Тэгэхээр эхлүүлсэн ажлынхаа үр дүнг үр дүнгээрээ хэмжүүлнэ.

Тийм учраас энэ Тендерийн хуулийг би онцолмоор байна.

Дээрээс нь түрүүн хэлсэн.

- Бүртгэл;
- Ашигт малтмалын лиценз;
- Газар олголт.

Бүгдийг нь “Шилэн ажиллагаа”-н (<https://shilen.gov.mn>) дээр нээлттэй болгож байсан.

**О.Цогтгэрэл:** Өөр авлигалын бас нэг үндсэн шалтгаануудын нэг нь яг одоо танай коммунист угшилтай намын ажлын арга барил.

Хуучин тэгж нэг ярьдаг байсан. Зорилго нь аргаа зөвтгөдөг юм. Үр дүнд хүрч байвал ямар аргаар яаж хэдэн хүн хэлмэгдүүлж, яаж хүрэх нь ямар хамаатай юм гэдэг нэг ийм коммунист угшил яг энэ том гэгдэх төслүүд дээр гарч байна.

Одоо энэ Туулын хурдны зам гээд. Туулын хурдны замыг яг бүтээн байгуулалтынхаа хувьд эсэргүүцэж байгаа хүмүүс хэр олон байгааг би сайн мэдэхгүй байна.

Агуулгынхаа хувьд “түгжрэл бууруулах” гэж байхад үүнийг хэдэн төгрөгөөр босгож байгаа нь хэнд хамаатай юм. Тэр хэдэн бургас хэнд хамаатай юм. Тэр төсөл, ТЭЗҮ нь ил тод байгаа эсэх нь ер нь бусад хүмүүс үүнийг мэдэж хэнд хамаатай юм.

Бүтээн байгуулалт эсэргүүцсэн хэдэн гар гэдэг хандлагаар. Тэр түгжрэл бууруулах гэж байхад энэ дундах бүгд ил тод байх, нээлттэй байх, төсөл, тендер, шалгаруулалт, олон нийтийн оролцоо мэдээлэл. Ардчилсан улсад байдаг бүх үе шатыг л үгүйсгэж байгаа. Энэ хэнд хамаатай юм. Гоёо үр дүнд хүрч байхад хэдэн хулгайч, луйварчин, хэдэн үгүйсгэгчид, бүтээн байгуулалтыг үгүйсгэгчид.

Ингэж тайлбарлаж уг нь энэ ардчилсан улс оронд чинь ажил урагшаа явахгүй шүү дээ.

Үүнийг анхнаас нь ил тод, нээлттэй зарлаад, аль нэг компани шалгарч байгаа бол шалгарч байгаа үндэслэл, норм, дүрмээ танилцуулаад төсөл, ТЭЗҮ, үнэлгээ, байгаль орчны сөрөг, эерэг нөлөөллөө танилцуулаад энэ чинь уг нь явбал энэ магадгүй улс оронд. Улс орон чинь бас төслөө, бүтээн байгуулалтаа хийх л ёстой байх. Яг л энэ хандлага дахиад тэр Харбины гэрээ ч гэсэн тэр. Хил холбож байвал үүний наадах тэр үр ашиг, бусад хулгай зэлгий бусад зүйл хэнд хамаатай юм бэ.

Яг л одоо нөгөө зорилго нь аргаа зөвтгөдөг. Зорилгод хүрэхийн тулд хэдэн мянган хүн буудаж алсан ч хамаагүй гэдэ яг коммунист угшил.

**С.Бямбацогт:** Уучлаарай, Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаагийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 9-ийн “б” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүүхэд багачууддаа Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс онц сураарай, аав, ээжийнхээ үгэнд сайн орж байгаарай, хичээлээ сайн хийж байгаарай. Дээрээс нь эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Би авлигын эсрэг тэмцэл дээр О.Цогтгэрэл даргатай улс төр огт хийхгүй.

Танай, манай гэж ярих огт шаардлага байхгүй. Яагаад гэвэл танайд ч авлигыг өөгшүүлсэн нөхдүүд байна, манайд ч байна.

Энэ нөхдүүдээсээ салж яаж урагшлах вэ гэдэг дээр хоёулаа жоохон золбоотой ажиллая гэж би бодоод байгаа юм. Таныг хувийн хэвшилд байсан. Зовлон жаргал үзсэн хүн. Би бас унаж босоод, уруудаж өгсөөд үхэл амьдралын заагаас өнөөдөр ирсэн хүн учраас надад тийм элдэв шунал тачаал байхгүй хүн.

Тийм учраас би жоохон золбоотой ажиллана. Дээрээс нь би бас атаман таньдаггүй. Тийм. Янз бүрийн кинон дээр гардаг тэр кино драм үзүүлэхгүй. Би тэр компанийг муулж, нөгөө компанийг нь магтаж хэн нэгнийг цоллож өргөмжилж явахгүй. Ажлаараа харуулна.

Тийм учраас танайд ч байгаа, манайд ч байгаа юмтай хамтдаа нийлээд тэмцвэл Ардчилсан нам засагт хамтраагүй ч гэсэн авлигын эсрэг тэмцэлд хамтаръя гэж би уриалж байна.

Би тантай санал нэг байна. Миний үзэл санаа, итгэл үнэмшил бол би зах зээлийн нийгэмд өссөн хүн.

Тийм учраас би үзэл санааны хувьд чөлөөлөлтийн бодлого дээр үргэлж оршино. Энэ бол хэн нэгний сэдэв биш. Та бидний хамтын сэдэв. Төсөл гацааг ч биш. Би төслийн гарцыг гаргаж ирсэн. Дуусдаггүй олон яриаг дуусгасан.

“ОРАНО МАЙНИНГ”-тай хийх хэлэлцээрийг би орчин үеийн боловсролтой залуусыг урьж, санхүүгийн хэлэлцээр хийж, ирээдүйд ямар ч өр төлбөр ногдохгүй олон улсын “корпорэйт гэрээ” хийсэн хүн.

Тийм учраас би төслийг явуулахад буруу арга хэлбэр ашиглахдаа эвлэрэхгүй.

Тийм учраас би Засгийн газрын хурал дээр “Туулын хурдны зам” дээр хууль хяналтын байгууллага эцсийн цэгийг хатгатал зогсоолоо гэж хэлсэн.

Тэгэхээр “эцсийн цэг хатгана” гэдэг бол их айхтар үг. Хууль хяналтын байгууллага тэнд ямар нэгэн –

- авлига, ашиг сонирхлын ийм асуудал байсан уу.
- Гоё нэрийн цаана мега тендер, мега хулгай байна уу.

- ♪ Түүнийг тогтоох ёстой.
- ♪ Олон нийтээр хэлэлцүүлэх ёстой.
- ♪ Үндэсний зөвшилцөл хийх ёстой.
- ♪ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулж болно. 1 минут.

**Н.Учрал:** Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хуулийн дагуу олон нийтийн хэлэлцүүлэг хийх ёстой.

Нэг ёсондоо энэ үгийн цаана юу нуугдаж байна вэ гэвэл иргэдийн дунд байгаа эргэлзээ, тээнэгэлзээг тайлах ёстой.

Түүнээс биш би түгжрэлийг бууруулах, энэ том том төслүүдийг үргэлж дэмжинэ. Манай Засгийн газар ард түмэнд ивээлээ өгөх эдийн засгийг эрүүлжүүлэх төслүүдийг явуулна.

Харин ард түмний дунд эргэлзээ, тээнэгэлзээ үүсгэж байгаа асуудал дээр цэг хатгаж байж урагшаа явна.

Тийм учраас энэ төсөл дээр нэг талаасаа энэ бол байгаль орчны асуудал. Нөгөө талаасаа энд хардлага, сэрдлэг байна. Үүнийг эцэслэх ёстой. Тэгээд явах нь нээлттэй.

Гэхдээ ямар ч тохиолдолд нэг юанийн эргэлзээгүй болж байж урагшилна гэдгийг би Танд хатуу хариуцлагатай хэлье. Нэг юанийн эргэлзээгүй болох ёстой.

Ард түмэн байгаль орчинд хор хөнөөлгүй гэдгийг нь дэмжих ёстой. Үндэсний зөвшилцөл хийх ёстой.

Би бас Туулын хөвөөнд өссөн хүүхдийн хувьд энэ төсөл дээр хатуу байр суурьтай байгаа.

**О.Цогтгэрэл:** Улс орны эрх ашгийн үүднээс аль нам, танай манай нам ч хэлгүйгээр ярилцах ёстой үндсэн асуудал эдийн засгийг өсгөх, өсөлтийг улам хурдасгах. Энэ өсөлт нь олон нийтэд хүртээмжтэй байдаг. Хэдэн авлигачийн карманд ордог, ард түмний бухимдал нэмэгддэг. Энэ чинь өөрөө жинхэнээсээ манай улс үндэстний үндэсний аюулгүй байдлын асуудал болж хувираад байна.

Авлига, авлигажсан тогтолцоог өөгшүүлдэг, авлигажуулдаг үндэс суурь хөрс чинь манай үндэсний аюулгүй байдал, нөгөө ардчилал ч бүр дүүрсэн. Үндэсний аюулгүй байдлын асуудал болж хувирч байгаа.

Тэгэхээр үүн дээр ус төрийн үүднээс биш, энэ дээр улс төрийн хүчнүүд хамтарч ажиллахаас өөр аргагүй.

Тэгээд өнгөрсөн 10 жилийг дүгнээд хэлбэл алдагдсан шударга ёстой, хавчигдсан дундаж давхаргатай, авлигажсан 10 жил байлаа.

Та тэгээд эрх баригч намын даргын чинь хувьд бас энэ хуулийн хэрэгжилт, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий Ерөнхий сайдын чинь хувьд энэ ажил дээр бодлогын томоохон өөрчлөлт гаргаж, үндэс суурь шалтгаан руу нь дэмжсэн үйл ажиллагааг зоригтой явуулахыг Танаас хүсье.

Яг үнэхээр улс орны эрх ашиг, ардчилсан тогтолцооны төлөөх зүйлс бүхэн дээр Ардчилсан нам дэмжиж хамтарч ажиллах болно гэдгийг төгсгөлд нь хэлье.

**Н.Учрал:** Мега төслүүдийн сайн засаглал, хяналт бүхий чадамжтай, зөв институцийг бүрдүүлэх, тэр дундаа иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангуулахгүйгээр том төсөл урагшилдаггүй.

Энэ бол үндэсний зөвшилцөл. Их Хурал бол мэдээллийг нээдэг байгууллага. Хаана нууц байна тэнд авлига байдаг.

Тийм учраас мэдээллийг ил тод, нээлттэй болгосон орон хөгжлийнхөө зөв замд ордог.

Бид цахим засаглалын индексээр 28 байр урагшилж байсан шигээ авлигын төсөөллийн индекс дээр ухрах биш урагшилж үзүүлнэ. Авлигын төсөөллийн индекс бол бүх ард түмний санал, санаачилга. Өдөр тутам ирж байгаа иргэдийн мессеж, хандлага шударга ёсыг хүсэж байна, авлигыг бууруулахыг шаардаж байна. Хоосон хэрэглэлээр биш, улс төрийн попролоор биш, илүү шинжлэх ухаанчаар их өгөгдөл дээр суурилсан шийдвэр гаргалт хийх нь шинэ Засгийн газар, шинэ Ерөнхий сайдын бодлого, үйл ажиллагаа байна гэдгийг Танд хэлье.

Тийм ч учраас О.Цогтгэрэл даргатай болоод Ардчилсан намынхаа гишүүддээ авлигын эсрэг тэмцэлд хамтарч ажиллахдаа үргэлж таатай байна.

- Бурууг нь буруу гэж, зөвийг нь зөв гэж хамтдаа урагшлахын төлөө илүү

хичээл зүтгэл гаргая.

- Их Хуралд барьсан Төрийн албаны нууцын хуулиа батлан гаргаж, 800 мянган мэдээллийг ил болгоё.
- Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг гаргаж, энэ олон компаниудын 500-г нь цэгцэлье. 50 хувийг нь цэгцэлье.
- Нийтийн өмчийн хуулиа гаргаж, өмчийг эзэнтэй болгоё.
- Өмч эзэнгүй явж ирлээ. Өмчийг эзэнтэй болгоё. Энэ бол зөв санал, санаачилга.
- Төрд байгаа эрх мэдлийг задалж, эдийн засгийн харьцаа 61 хувийг бууруулъя.

Дотоодын нийт бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн орлогын харьцаа 37 хувь байсныг 28 хувь болгож, намайг Эдийн засгийн сайдаар байхад төсвийн хүрээ оруулж ирж байсан. Би энэ 28 хувь дээрээ хатуу зогсоно.

- ◆ Хувийн хэвшилд орон зайг тэлнэ.
- ◆ Баялаг бүтээгчдээ дэмжинэ.

Хэн нэгнийг цоллохгүй, өргөмжлөхгүй ухаалгаар ажил хийхийн төлөө...  
/минут дуусав/

**С.Бямбацогт:** О.Цогтгэрэл дарга аа, Танд нэмж асуух боломж байгаа. Шаардлагатай бол. Болсон уу? Тийм ээ.

О.Цогтгэрэл даргад баярлалаа.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Асуулт асууж хариулт авах хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй. /алх цохив/

Ганбатын Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн дагуу 3 асуулт явуулсан байгаа. Мэдээж Ерөнхий сайд үзсэн байх гэж бодож байна.

Энэ асуултыг би асуугаагүй. Энэ асуулгад оролцохын өмнө Улаанбаатар хотын 4 дүүрэг, орон нутгийн 5 аймгаас ирсэн 80 орчим саналуудыг нийлүүлж байгаад 3 санал болгоод явуулсан байгаа.

Тэгээд эхний асуултаа асууя.

Та авлигыг дээд шатад удирдаж, дунд, доод шатад хэрэгжүүлдэг тогтолцоо Монгол Улсад бий болсон гэдэгтэй санал нийлэх үү гэсэн асуулт байгаа. Таныг хариулсны дараа нэмэлтээр асууя.

**Н.Учрал:** Би түрүүн О.Цогтгэрэл даргад байр сууриа хэлсэн. Яг өнөөдрийн тогтолцоогоор бид авлигыг бодитойгоор бууруулж чадахгүйтэй би санал нэгддэг.

Тийм учраас Таны асууж байгаа авлигыг дээд шатад удирдаж, дунд шатад хэрэгжүүлдэг тогтолцоо Монгол Улсад бий болсон гэдэгт итгэдэггүй. Эргэлздэг.

Тийм учраас тогтолцооны хувьд шинэчлэх нь авлигыг уг үндсээр нь устгах хамгийн зөв механизм байна гэдэгтэй итгэж, үнэмшиж 2016 онд Их Хурал сонгосноосоо хойш бүртгэлийн багц хуулиас авхуулж, Нийтийн мэдээллийн хууль, Цахим гарын үсгийн хууль, Зөвшөөрлийн хууль, цахимжилтыг ил тод байдлыг нээхийн төлөөх олон санал, санаачилга өнөөдөр үр дүнгээ өгч, үүнийгээ амилуулж, эрх мэдлийг задлах гэж би Ерөнхий сайд болсон.

Тэгэхээр энэ бол илүү хоосон ярихаас илүүтэйгээр үр дүнгээр хэмжигдэх ажил.

Тийм учраас системийн хувьд тогтолцоогоор нь харсны үндсэн дээр сая гэхэд 146 үйлчилгээг ард түмэн, иргэддээ нээлттэйгээр эрхэл гэсний дараа үүнийг нь мушгин гуйвуулах тохиолдол гардаг.

Тэгэхээр энэ тэмцэлд, энэ эрх мэдлийг задлах гэж байгаа санал, санаачилгад бол саад бэрхшээл байна. Гэхдээ үүний цаана өөрөө хувийн хэвшилтэйгээ хамтарч ажиллах бодол санаа байгаа учраас бид “Ай Пи” сервисийг нээсэн гээд байгаа нь юу вэ гэхээр төр дээр иргэд очдог биш, төр иргэндээ очиж үйлчилдэг шинэ систем буюу 2019 онд Эстонид харж байсан ажлаа өнөөдөр нүдэнд харагдаж, гарт баригддаг болгож, эхэлснээ дуусгах гэж өнөөдөр би энд зогсож байгаа юм.

**С.Бямбацогт:** Г.Очирбат гишүүн 1 минут.

**Г.Очирбат:** Иргэд бол үгүй гэж байгаа.

Яагаад гэхээр Та санаж байгаа бол субъектив битгий хүлээж аваарай. Манай сайд нар их субъектив хүлээж авч байх шиг байна лээ шүү. Субъектив хүлээж авч болохгүй. Жижиг, дунд үйлдвэрлэлийн сантай холбоотой Улсын Их Хурлын гишүүн болгонд тэрбум тэрбум төгрөгийг хуваарилж байсан тухайн үед.

Үүнийг хэн гардан гүйцэтгэсэн гэхээр –

- тухайн жилийн төсвийг мэдэж байсан хүмүүс,
- төсвийг баталсан хүмүүс,
- оролцсон хүмүүс,
- Их Хурлын гишүүд,

— мөн дээрээс нь хэрэгжүүлэгч агентлагууд,

— мөн дээрээс нь тэрийг хүлээж авах компани нь хүртэл тодорхой байсан.

Тэгэхээр иргэд үүнийг авлигалын систем өөрөө ингээд бүр институцийн хэмжээнд хөгжсөн явж байна гэдгийг ойлгоод байгаа.

Дараагийн асуултдаа оръё.

Хоёр дахь нь. Энэ бол өнгөрсөн цаг дээрх холбоотой асуудал. Яг одоо цаг дээрхтэй холбоотой асуулт бас байгаа.

Ирээдүйд цаг дээрх сүүлийн нэг асуулт байгаа.

Та авлигатай тэмцдэг Засгийн газар бүрдүүлж чадсан гэж үздэг үү? Танай Засгийн газраас хэн хэн, ямар сайд авлига, албан тушаалын хэргийн асуудалтай холбогдвол Та шууд огцорч чадах уу? Хариултаа авъя.

**Н.Учрал:** Монгол Улсын Ерөнхий сайдын онцгой бүрэн эрхийнхээ дагуу танхимаа бүрдүүлсэн.

Нэгд, Засгийн газрын тогтвортой байдал улс төрийн капиталд үндэслэсэн. Засгийн газар өөрөө улс төрийн капиталын нэгдэл.

Тийм ч учраас манай Засгийн газар хал үзэж, хашир суусан, орон нутагт ажиллаж байсан, төр захиргааны байгууллагад ажиллаж байсан улс төрийн ажил амьдралын туршлагатай кабинет.

Мэдээж сайн сайдын 32 шинж бүрдсэн супер хүн гэж хаана байх вэ. Улс төрд олон жил явж байгаа хүмүүс ард түмнээрээ шүүлгэдэг, ил тод, нээлттэй, ард түмэн шүүмжилдэг.

Тийм ч учраас улс төрд олон жил явж байгаа хүмүүс нэр бүтэн байна гэдэг бол ардчилсан нийгэмд тийм их амар зүйл биш. Энэ бол ардчилсан нийгмийн гол онцлог. Нээлттэй шүүх ёстой. Шүүмжлэх ёстой.

Тийм ч учраас манай Засгийн газар бол авлига, албан тушаалтай тэмцэнэ. Авлига албан тушаалын хэрэгт гэм буруутай нь тогтоогдвол... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Минут дууссан. Нэг бол 1 минутаар нэмж авах боломж байгаа.

Сүхбаатар Эрдэнэболд гишүүн.

Уучлаарай, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхарын урилгаар Монгол Оросын хамтарсан 3 дугаар сургуулийн 12-ын “г” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсье.

Эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Тэгээд бүгдээрээ онц сураад, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаарай, хичээгээрэй гэж Та бүхэндээ хүсье.

Цаг яваагүй ээ. Одоо С.Эрдэнэболд гишүүний цаг эхэлье.

**С.Эрдэнэболд:** Яг энэ мэтгэлцээний дундуур үүнийгээ явж хэрэггүй шүү. Мэтгэлцээний уур амьсгал шал өөр юм болоод хувирлаа.

Ерөнхий сайд аа, анхны мэтгэлцээнд Та оролцож байна.

Сая О.Цогтгэрэл дарга хэллээ. Та 4 талаар чөлөөлье гээд байгаа шүү дээ. Тэгэхдээ энэ чөлөөлье гэдгийг чинь нийт цохилтын тун чинь сүүлийн 10 жилийн авлигажсан тогтолцоо руу л явж байгаа.

Та сая 3 сарын 01-ний өдөр буюу өнөөдөр чинь хаврын адаг сарын шинийн 8 гэхээр сар гаруйн өмнө намынхаа их хурал дээр Та чөлөөлье гэж байгаад 4 хүний асуудыг оруулж ирсэн шүү дээ. Нам дотроосоо.

Тэгээд Таны шударга ёс илд чинь хэвээрээ байна уу, эсвэл Засгийн газар бүрдээд уусаад алга болсон уу? Одоо танай Засгийн газар чинь талцаад байсан хоёр талаас аль аль нь суусан. Засгийн хурал дээрээ хүртэл үзэлцээд байгаа сурагтай байна лээ.

- Танд яг одоо улс төрийн нөхцөл байдлын хувьд авлигатай тэмцэхэд ямар бэрхшээл байна?
- Ерөнхийлөгч талаас Танд ямар нэгэн дарамт шахалт байдаг юм уу?
- Бусад улс төрчдөөс Танд ямар нэгэн дарамт шахалт байдаг юм уу?

Таны ярьж байгаа зүйл яг онолын дагуу, залуу хүний хувьд итгэл үнэмшлийн юмыг чинь би ойлгоод байна л даа. Гэхдээ улс төр гэдэг чинь бас

хөлийг чинь тушаад чөдөрлөчхөөд байгаа юм байна уу, үгүй юу? Яг тодорхой л юм Та хариулмаар байна.

→ Яг одоо авлигатай тэмцэхэд Танд яг ямар саад бэрхшээл байгаа юм бэ?

Мэдээж түрүүний ярьдаг “Эй Ай”, хууль эрх зүйн орчин, улс төрийн зориг гээд олон юм хамаарна л даа. Гэхдээ яг өнөөдөр Та Монгол Улсын Ерөнхий сайд. Энэ бол түүхэн момент шүү дээ.

→ Танд яг одоо авлигатай тэмцэхэд ямар саад бэрхшээл байгаа юм бэ?

Ялангуяа Та сүүлийн 10 жил гэдэг чинь өөрийнхөө намын маш олон чинээндээ тултал хөлжсөн хувалзнуудтай үзэлцэх боломжтой түүхэн цаг үе байна шүү дээ.

- Танд зориг байна уу?
- Зүрх байна уу?
- Шийдэмгий чанар байна уу?

Түүх танаас асууна. Одоо бид танаас асууж байна шүү дээ.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Монгол Ардын намын дүрэмд заасны дагуу шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон бол намын гишүүнээс нь түдгэлзүүлдэг дүрэмтэй. Шинэ дүрмээрээ.

Харин намын хяналтын хороондоо намын гишүүн, намын дарга хэн ч бай ёс зүйн зөрчил гаргасан, авлига албан тушаалын хэрэгтэй холбогдсон байж болзошгүй хүмүүсийг хянан шалгуулахаар өгдөг.

Ингээд Хяналтын хороо 27 гишүүнийхээ бүрэлдэхүүнтэйгээр үүнийг нь шийдвэрлэдэг.

Тийм учраас намын даргын хувьд тэр нэр бүхий гишүүдийг ёс зүйн болоод авлига, албан тушаалын хэрэгтэй холбогдсон байж болзошгүй гэдэг үндэслэлээр Хяналтын хороонд өгсөн.

Улс төрийн намын даргын ажлаа бол хийж байгаа. Тэгээд гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй байхад хэн нэгнийг шууд гэм буруутай гэж зарлах нь зохимжгүй байх. Гэхдээ намын дүрмээ би хэрэгжүүлж байгаа.

Тийм учраас авлига, албан тушаалын хэрэг дээр, авлигатай тэмцэх тэмцэл дээр анд найз, ах дүү, амраг садан хэн ч байх ёсгүй.

- Надад зориг байна.

- Миний удирдах арга барил заримд нь таалагдахгүй байна.
- Заримд нь нийцэхгүй байна.

— Би хундаганы ард асуудал шийдэж үзээгүй хүн.

Тийм учраас зарим хүмүүст надтай уулзаад учраа олохгүй байх шиг байна.

Тийм учраас битгий уулзаарай гэж хэлье. Яагаад гэхээр хундага дарсны ард орой үдэш суугаад асуудал шийддэг, тендер наймаалцдаг, хуваадаг, хуваарилдаг тийм арга барил надад байхгүй.

Тэгээд Та бид хоёр хар багаасаа оюутны мэтгэлцээнээр мэтгэлцэж байсан. Өнөөдөр ингээд парламентын мэтгэлцээнээр мэтгэлцээд. Тэгээд Та миний суурь чанарыг мэдэх учраас бидний үеийнхэн өссөн, төрсөн, үзэж харсан зүйл өөр шүү. Өөр арга барилаар ажиллана.

**С.Бямбацогт:** Сүхбаатар Эрдэнэболд гишүүн.

**С.Эрдэнэболд:** Ерөнхий сайд гэхээсээ илүүтэй танхимынхаа сайд нарт хэлье. Сайд нараас зарим нь сууж байна.

Г.Дамдинням сайд аа. Хөөе. Г.Дамдинням сайд аа, сайд нартаа. Хоёр Энхбаяр сайд байж байна.

Та нар байна шүү дээ. Тийм ээ. Намын даргаараа дандаа туг тахидаг шүү. Ерөнхий сайдаараа дандаа туг тахидаг шүү. 21 сарын дотор 3 дахиа тахиж байгаа. Одоо намар дахиад дахих гээд байж байгаа.

Тэгээд нэгэнт энэ бол Ардын намын засаг биш Монгол Улсын засаг шүү. Ерөнхий сайд чинь ингээд нэг зориг гаргана гээд байж байхад нь Та нар жоохон олигтойхон шиг дэмжээд, нэг жоохон шударга ажиллачхаарай.

Та нарыг харахад тийм итгэл байхгүй байна шүү. Та нар шуудайд хийсэн эвэр шиг байна шүү. Хутгаа нуусан, ардаа барьсан хүмүүс шиг л харагдаж байна шүү.

Монгол Улсын Ерөнхий сайдын төлөө тэр LIVE дээр Г.Дамдинням сайд их хөөрхөн томоотой, за.., Ерөнхий сайд гээд байсан. Яг тэр маягаараа тэгээд нэг сайхан шударга ажиллачхаарай. Тэгж чадахгүй бол Та нар бүгдээрээ 2027, 2028 онд байхгүй шүү.

Тэгэхдээ энд Монгол Улс хохирно. Монгол Улс хохирно. Ерөнхий сайд хохирохгүй шүү дээ. Монгол Улс хохирно.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайдын микрофон.

**Н.Учрал:** С.Эрдэнэболд гишүүн хатуу бөгөөд зөв үгийг хэллээ.

Тэгээд танайд ч асуудал байна, манайд ч асуудал байна.

Тийм учраас хүүхэд байхдаа ярьдаг байсан ажлаа одоо дуусгая л гэж хэлье дээ. Авлигатай тэмцье. Үгүй үгүй, нээрээ авлигатай тэмцэх санал, санаачилга доор улс төрийн нам хамаагүй шүү.

Тийм учраас авлигатай тэмцэх тэмцэлд манай парламентад байгаа 5 улс төрийн нам хамтдаа оролцох ёстой. Хэн нэгнийг өөгшүүлж болохгүй. Бүгдээрээ арга барилаа өөрчилье. Орчин цагийн Засгийн газар шиг ажиллая. Заавал ийм байх ёстой гэсэн юм байхгүй. Одоо өөр байя.

Тийм учраас хууль, шүүхийн өмнө хүн бүр тэгш эрхтэй.

Тийм учраас авлигатай холбогдсон бол хариуцлагатайгаар явж чаддаг байгаасай гэж би хүсэж байна.

**С.Бямбацогт:** Өлзийхүүгийн Шижир гишүүнийг индэрт урьж байна. С.Эрдэнэболд гишүүнд баярлалаа.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. Ерөнхий сайд аа.

Монгол Ардын намын хамгийн анхны дарга Солийн Данзан **“Иргэн баян бол улс баян”** гэж хэлсэн.

105 жилийн дараа Н.Учрал даргын үед –

- иргэн ядуу,
- улс мөнгөтэй,
- Монгол Ардын намаас төсөв захиран зарцуулдаг дарга нь өнөөдөр баян болсон байна.

Төрөөс баяжиж байна. Иргэд олон нийт ч үүнд бухимдаж байна.

Танай намын зарим гишүүд өөрийгөө толинд хараад танихаа больсон.

- ▶ Хүссэн дүрээ хардаг болсон.
- ▶ Хүссэн үгээ л сонсдог болсон.
- ▶ 2016 онд Монгол Ардын нам засгийн эрх барихдаа тухайн үед хоёр хуваагдаж байхдаа хулгайгаа **сая саяар ярьдаг байсан.**

— 100 сая, 200 сая, 850 сая, 900 сая гэж.

▶ 2020 онд засаг авахдаа **тэрбумаар ярьдаг болсон.**

— 10 тэрбум, 20 тэрбум, 30 тэрбум.

▶ 2024 онд засаг авахдаа **их наядаар ярьдаг болсон.**

▶ Сүүлдээ 100, 100 сая **доллороор ярьдаг болсон.**

Одоо сүүлдээ хар тамхитай мафитай кино шиг магадгүй килограммаар ярьдаг болох уу? Надад жинхэнээсээ ийм айдас байна.

Энэ бол Та нарын хоорондоо ярьсан хуваагдлууд. Энд Ардчилсан намын нэг ч гишүүн энэ талаар огт яриагүй.

Өнөөдөр эрх баригчид Та бүхэн төсөвтэй болсон танай намын дарга нар –

- иргэдээ сонсохоо больсон байна,
- үл тоодог болсон байна,
- тэнгэрт ниссэн байна.

Тэгээд ер нь авлигатай тэмцэнэ гэдэг бол яг ний нуугүй хэлэхэд Та Монгол Ардын намынхаа гишүүдтэй тэмцэнэ гэсэн үг. Сүүлийн 10 жилийн.

Та өөрийн намын гишүүдтэйгээ тэмцэж чадах уу? Авлигатай тэмцэх дээр бодит үр дүн гаргаж чадах уу гэдэг асуудал байна.

Төрийн өмчит компаниуд төсөвтэй холбоотой, төртэй холбоотой бүх хөрөнгө гарын салаагаар захиран зарцуулдаг, урсдаг болсныг сүүлийн 2 жилийн парламент үүнийг хангалттай Та бүхэнд хэлж өгсөн.

Та залуу хүн. Арай өөр арга барилаар ажиллана гэдгээ илэрхийлж байгаа. Та өөрөө намынхантайгаа тэмцэж чадах уу гэдэг нэгдүгээрт асуулт байна.

Хоёрдугаарт, ер нь хулгайлахгүй л бол хүрэлцэнэ. Хулгайлахгүй л бол Монгол Улсад энэ бүх мөнгө хүрэлцэнэ. Хулгайлаад байгаа учраас хүрэлцэхгүй байгаа юм.

3.6 сая иргэд яг ний нуугүй хэлэхэд дарга нарын тансаглалын үлдсэн хариулт мөнгөн дээр амьдарч байна.

Энэ тансаглалын захиран зарцуулалтыг хэзээ болих вэ? Намтайгаа тэмцэж чадахгүй... /минут дуусав/

**Н.Учрал:** 10 жилийн өмнө манай дотоодын нийт бүтээгдэхүүний 22.9 л байсан шүү дээ.

— 5 дахин өсөөд байна. GDP 100 их наяд руу явсан.

10 жилийн өмнө бид мөнгө яаж олох вэ гэж боддог байсан. Өнөөдөр мөнгө олох нь буюу бонд босгоод байна уу, санхүүжилт босгоод байна уу, хөрөнгө оруулалт татаад байна уу мөнгө олох бололцоотой болсон. Өнөөдрийн цаг үед.

Гэтэл босгосон мөнгөө ард түмнийхээ хяналт доор шударгаар зарцуулах вэ гэдгээ ойлгохгүйгээр өнөөдөр бид хийрхсээр байгаад хэт баян, хэт ядуу гэдэг ийм хоёр бүлэгтэй болж байна. Би үнэхээр үүнд эмзэг ханддаг.

Тийм ч учраас би Ерөнхий сайдын ажлыг аваад тэр цаг мөчөөсөө хойш би 24 хоногт уг үндсээр нь устгахын төлөө үзэл санаа, үйл хэргээ чиглүүлж байгаа юм.

Тийм учраас миний зоригт бол бүү эргэлз. Миний зоригт бол эргэлзэх юм байхгүй.

Тийм учраас энэ зориг, үйл хэрэгт Та бүхэн л хамтдаа байх ёстой. Манай Ардчилсан намынхан ч бай дэмжих л ёстой. Манай намынхан дэмжих ёстой.

Тийм учраас харин танаас би асуух гээд байгаа юм. Та намынхантайгаа тэмцэж чадах уу?

Тэгэхээр энэ чинь бас л хариулах ёстой байхгүй юу. Бид залуу үеийнхэн. Бид тэмцэх ёстой. Анд найз, ах дүү, танилын тал, танилын нүүр халуун боловч Та бидний эх орон ирээдүй илүү хайран байна шүү дээ. Түүнээс танил талаа харвал, хамт байснаа яривал, ах дүүгээ яривал энэ явахгүй шүү.

Тийм учраас Та ч гэсэн залуу хүний хувьд намтайгаа ахан дүүс хамааралгүйгээр авлигын эсрэг бол хэнтэй ч тэмцэх хэрэгтэй. Энэ цагт бол бид ирээдүйгээ, бидний үр хүүхэд амьдрах нийгмийг арай эрүүл болгож чадна гэдэгт би эргэлздэггүй.

**С.Бямбацогт:** Ө.Шижир гишүүнд 1 минут.

**Ө.Шижир:** Авлига хаана байна гэхээр эрх барьж байгаа газар л байгаа.

- Төсөвтэй, мөнгөтэй газар байгаа.
- Төрийн мөнгөтэй газар байгаа.

— Үүнийг дагаж авлига л байгаа.

Хувийн хэвшил дээр авлигал гэдэг зүйл бараг яригдахгүй.

Тэгэхээр хэн өнөөдөр төрд эзэн байгаа юм, хэн өнөөдөр төрийн байгууллага удирдаж байгаа юм.

Тэгэхээр танай намын удирдах зөвлөлийн гишүүд, Бага хурлын гишүүд, тодорхой тооны албан тушаалтнууд байгаа.

Сүүлийн 10 жилд 60 тэрбум.

Ер нь энэ авлигалын эх үндэс юунаас эхэлсэн бэ гэхээр төрийн албан тушаалыг 60 тэрбум төгрөг худалдахаас эхэлсэн.

- 60 тэрбумаар авсан хүмүүс энэ мөнгөө нөхөхийг хүссэн байх.

- Магадгүй 600 тэрбум болгож авахыг хүссэн байх.

- Магадгүй 6 их наяд болгосон ч байж магадгүй.

Яагаад гэвэл би дахиад хэлье.

- ▷ Хулгайлахгүй бол хүрэлцэхээр хэмжээний баялаг,
- ▷ хулгайлахгүй бол хүрэлцэхээр хэмжээний мөнгө Монгол Улсад байна.

- Үлдсэн жоохон мөнгөн дээр 3.6 сая иргэд амьдарч байна.

Сүүлийн 10 жилээр зүгээр санаандгүй байдлаар түүвэр хийгээд үзэхэд –

- ✦ 60 тэрбум луйвар,
- ✦ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан,
- ✦ Боловсролын зээлийн сан,
- ✦ Нийгмийн даатгалын сан,
- ✦ Хөгжлийн банкны хулгай,
- ✦ Ногоон автобус,
- ✦ Ковидын үеийн худалдан авалт,
- ✦ Нүүрсний хулгай,
- ✦ мэргэжлийн хяналт,
- ✦ гаалийн хулгай,
- ✦ төрийн өмчийн компаниуд,
- ✦ Эрүүл мэндийн даатгалын сан,
- ✦ Хөдөө аж ахуйн... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Ерөнхий сайдад хариулъя.

**Н.Учрал:** Цахим хөгжлийн сайдаар томилогдоод би Таны нэрлэж байгаа Боловсролын зээлийн сан, ашигт малтмалын бүх лиценз, газрын мэдээлэл, ЖДҮ-гийн сан, Хөдөлмөр эрхлэлтийн сан, Нийгмийн даатгалын сан. Энэ бүх мэдээллийг би [shilen.gov.mn](http://shilen.gov.mn) дээр нээсэн.

Эргэн төлөлт 35 хувьд 7 сарын дотор хүрсэн.

Төр ард түмэндээ итгэсэн цагт үр дүн хүрдэг. Ард түмнээрээ шүүлгэсэн цагт авлигачид ичдэг байхгүй юу.

Тийм учраас энэ мэдээллүүдийг ил тод болгосон юм. Ил тод болгосон. Түүн шигээ цаашдаа үүнийг углуургаар нь шийдэхийн төлөө явна.

Засгийн газар мэдээж мөрдөн шалгах алба биш ээ. Хэн нэгэн хүнийг шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй байхад олны өмнө дүүжилж чадахгүй. Гэхдээ Засгийн газар түүн дээр ажлын хэсэг ажиллуулж шаардлагатай нотлох баримт, мэдээллүүдийг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

Тийм ч учраас шилжүүлсээр ирсэн. Хуулийн байгууллага яагаад ажлаа хийхгүй байна вэ гэдгийг шаардаж ажиллана.

**С.Бямбацогт:** Өлзийхүүгийн Шижир гишүүнд баярлалаа. Одоо Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууна.

**Л.Мөнхбаясгалан:** Ерөнхий сайд аа, өдрийн мэнд.

Та хөл бөмбөгийн тэмцээн үздэг үү? Хөл бөмбөгийн тэмцээн үздэг үү?

**Н.Учрал:** Би үздэггүй шүү дээ. Бараг.

**Л.Мөнхбаясгалан:** Тийм үү?

**Н.Учрал:** Тийм.

**Л.Мөнхбаясгалан:** Тэгвэл дэлхийн хамгийн олон үзэгчтэй хөл бөмбөгийн тэмцээний нэг дүрэм байдаг л даа. Зөрчил гаргасан тамирчинд ийм шар карт буюу шар хуудас өгдөг юм.

Тэгээд би Танд өнөөдөр энэ шар хуудас буюу Улсын Их Хурлын гишүүний асуултыг өөрийн биеэр өгөх гэж байна л даа.

Ямар учиртай вэ гэхээр миний сонгогдсон говийн бүсийн 4 аймгийн нэг Говьсүмбэр аймгаас байнга гомдол ирдэг юм. Тэнд Шивээ-Овоо гэдэг төрийн өмчит компани байдаг.

Энэ Шивээ-Овоо компанийн Тэргүүн дэд захирлаар Э.Цасчихэр гэдэг хүн ажиллаж байсан. Саяхан ажлаа хүлээлгэж өгсөн.

Энэ хүнд холбоотой удаа дараа гомдол буюу баримтууд ирдэг юм. Энэ хүн Увс аймгийн Засаг дарга байсан. Увс аймгийн Ардын намын дарга байхдаа авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдоод анхан шатын шүүхээс ял аваад дараа нь 10 сая төгрөгөөр торгуулсан ийм түүхтэй хүн.

Үүнийг Таны зөвлөх Чимэдийн Хүрэлбаатарын оролцоотойгоор Шивээ-Овоо компанийн Тэргүүн дэд захирлаар тавьсан.

Энэ хүн Шивээ-Овоо компанид дизель түлш нийлүүлэх тендерийг одоо Увс аймгийн Ардын намын дарга Б.Одгэрэл гэдэг хүний байгуулаад хоёрхон сар болсон ямар ч эдийн засгийн түүхгүй, бизнесийн түүхгүй компанид 8 удаагийн үйлдлээр 108 тэрбум төгрөгийн тендер өгсөн байдаг юм. Одоо энэ хүн Увс аймгийн Ардын намын дарга байхгүй юу.

Тэгэхээр би Танд энэ үйлдэл болгоныг тухайн тендерийн хууль болгоны заалттай харьцуулаад бичсэн энэ асуултыг тавьж байгаа юм.

Та асуултыг хуулийн хүрээнд 14 хоногийн дотор мэргэжлийн Байнгын хороо болон Улсын Их Хурал дээр өөрийн биеэр асуултын хариуг өгөхийг би шаардаж байна.

Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй хүмүүс өнөөдөр Монгол... /минут дуусав/

**Н.Учрал:** Мэдээлэл өгсөнд баярлалаа.

Тэгээд Таны өгсөн мэдээллийг би шалган нягтлах болно. Тэгээд сөрөг хүчин илүү соргог байдаг. Цаашдаа ч гэсэн ийм зөв шударга мэдээ, мэдээллийг өгч хамтарч ажиллахыг хүсэж байна.

Тэгээд би асуулгын хариуг 14 хоногийн дотор Танд хүргүүлье.

**С.Бямбацогт:** Л.Мөнхбаясгалан гишүүн асуултаа гүйцээгээд асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Тэгээд шар картыг 2 удаа авах юм бол улаан болж тоглолтоос хасагддаг дүрэмтэй. Хөл бөмбөг.

Тэгэхээр улс төрийн тоглолтоос битгий улаан карт авч хасагдаасай гэж би Танаас хүсэж байна.

Таны танхимд ч гэсэн өнөөдөр авлига, албан тушаалын хэрэгтэй нөхөр сууж байгаа шүү. Та түрүүн миний зоригт итгээрэй гэсэн. Таны зоригт итгэж байгаа шүү.

Үүнийгээ шалгуулаад даруйхан Улсын Их Хуралд эргэн тайлбарлах хэрэгтэй гэж бодож байна. Шаардлагатай бол нэр хэлж болно. Шаардлагагүй бол ингээд дуусгая.

**С.Бямбацогт:** Хариулт шаардлагагүй гэж байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын урилгаар Говь-Алтай аймгийн хувиараа бизнес эрхлэгч оёдолчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын байр бий болгож, баялаг бүтээж, татвар төлж байгаа Та бүхэнд гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ш.Бямбасүрэн:** Өдрийн мэнд. Ерөнхий сайд.

Би танаас Монголын улс төрд байдаг л мэт үзэгдэл болоод байгаа ёс зүйн хамааралтай асуудлыг хөндөж асуумаар байна.

Энэ бол ерөөсөө манай нам, танай нам гэх юм бол байхгүй. Монголын асуудал.

Ер нь төрдөө итгэх итгэл, ард түмний итгэл, төрөө дээдлэх түүхэн уламжлал маань үгүй болж байгаагийн л илрэл болоод байгаа асуудал юм.

Асуулт нь юу юм гэхээр ер нь авлига, албан тушаалын хэрэгт холбогдсон, шүүхээр ял шийтгүүлсэн, төрийн өндөр дээд албан тушаалд ажиллаж байсан хүмүүс нам, улс төр, төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоор байх нь төрд хууль тогтоох байгууллагад итгэх иргэдийн итгэл сулрах үндэс болж байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү? Энэ дээр Таны байр суурийг сонсьё.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Би бол эмээтэйгээ өссөн хүүхэд. Манай эмээ өглөө болгон “Төрийн минь сүлд өршөө” гэж сүү өргөдөг хөгшин байлаа.

Бид төрийг тэгж хүндэтгэж сүсэглэдэг өвөг, дээдсийн удам. Өнөөдөр төрөө хүндлэхээ больсон нь бидэнтэй холбоотой.

Тийм ч учраас төрийн өндөр албыг хашиж байгаа хүн өөрөө эхлээд –

- ёс зүйтэй байх ёстой.
- Үлгэрлэлтэй байх ёстой.
- Манлайлалтай байх ёстой.
- Хариуцлагатай байх ёстой.

Тэгж байж бусдад шаардлага тавина.

Тийм учраас хувийн зохион байгуулалт, өөртөө тавих шаардлагаа би өнөөдрийг хүртэл их өндөр тавьсаар ирсэн.

Тийм ч учраас би намынхаа залуу гишүүдэд хүртэл хэлдэг. Залуу хүн улс төрд орсноор Үндсэн хуулиар олгогдсон олон эрх чөлөөгөө хасуулдаг шүү.

Тийм учраас ёс зүйтэй бай гэж. Ёс зүйгүй хүн бусдад шаардлага тавихгүй. Би Их Хурлын даргаар томилогдоод ч хэлж байсан. Энэ танхимаас хууль төрдөг болохоос хулгайч төрөх ёсгүй гэж. Би энэ үг, байр суурь дээрээ хатуу байгаа. Энд танил тал, ах дүү, найз нөхөд огт хамаагүй.

Тийм учраас амнаасаа гарч байгаа үг болгондоо хариуцлагатай хандаж, төрөө дээдэлдэг Монголын ард түмний сэтгэл, итгэлийг дахин сэргээх нь бидний залуу үеийнхний үүрэг.

Тэгэхээр Ш.Бямбасүрэн гишүүн маш зөв үг хэллээ.

Тэгээд төрийнхөө нэр хүндийг сэргээхийн төлөө бидний үеийнхэн хичээж зүтгэцгээе л гэж уриалмаар байна.

**С.Бямбацогт:** Заалны микрофон жоохон чангалмаар.

Ерөнхий сайд өндөр болохоор микрофоноос хол сул сонсогдоод байх шиг байна.

Ш.Бямбасүрэн гишүүн асууя.

**Ш.Бямбасүрэн:** Тэгээд Монголчууд мартаагүй байгаа даа.

Хэдхэн жилийн өмнө нэг ЖДҮ-гийн хөнгөлөлттэй зээлийг Монгол Ардын намын 40 гишүүн толгой дараалаад авч байсан.

Тэгээд өнөөдөр энэ хүмүүс хуулийн болон ёс зүйн хариуцлага хүлээгээд улс төрөөс холдох ёстой байтал эсрэгээрээ бүр өндөр албан тушаал аваад явж байгаа.

Жишээ нь, ЖДҮ гээд хөнгөлөлттэй зээлийг авсан хүмүүсийн нэг нь бол Та өөрөө. Танаас ч зогсохгүй Таны танхимын хэд хэдэн сайд нар бас энэ зээлийг авч байсан.

Тэгэхээр ийм учраас л төр засагт итгэх иргэдийн итгэл буураад байгаа юм. Тэгээд энэ мэт асуудлыг намын даргын хувьд ч тэр, Ерөнхий сайдын хувьд ч тэр цаашид ер нь ямар бодитой алхам хийх юм? Ямар зарчим барьж ажиллах вэ гэж асууя.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Улс төрд олон жил яваа хүн ард түмнээрээ шүүлгэх нь, ард түмнээрээ шүүмжлүүлэх нь байдаг л үзэгдэл.

Гэхдээ үнэн мөнийг тогтоох ёстой. Би эдгээр тусгай сангуудын бүх мэдээллийг ил болгож байсан хүн.

Хоёрт, би энэ сангаас ямар нэгэн нөлөөлөл, ашиг, зээл, тусламж авсан зүйл байхгүй. Хамгийн эхэнд би тайлбарыг нь хэлж байсан. Зах зээлд шилжсэн цаг үеэс хойш миний гэр бүл, миний ээж, аав ариун цагаан хөдөлмөрөөр өнөөдрийг хүрсэн хүмүүс.

Хөдөлмөрлөж хүн болдог гэдгийг амьдралаараа харуулж яваа.

Тийм учраас хөдөлмөрч хүн болгонд саад тээг болдог хүнд суртал, дүрэм журмыг чөлөөлж өгөх юмсан гэдэг итгэл үнэмшлээр би хүн болж хүмүүжсэн.

Тийм учраас надад нуугаад хаагаад байх, ард түмнээсээ нуугдаад байх нэг ч зүйл байхгүй. Миний ахуй амьдрал, гэр бүл, бизнес, хөрөнгө орлогын мэдүүлэг, бүх зүйл ил тод. Цаашид ч би энэ байр сууриа барьж ажиллана.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Далайн Батбаяр гишүүн асуултаа асууя.

**Д.Батбаяр:** Танд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би орон нутгийн удирдлагуудын авлигын хэрэгтэй холбоотой нэг бодит түүх Танд хэлж өгье. Маш богинохон.

Алслагдсан сумын сургуулийн уурын зуух яг ид идэр есийн хүрд нь эвдэрсэн байгаа юм.

Тэгээд одоо хэрэгжиж байгаа хуулиараа Засаг дарга тендер зарлаад явах юм бол 1-ээс 3 сарын дотор тендер нь зарлагдаад үр дүн нь гараад, ажил нь хийгдээд, өнөө сургуулийн маань зуух засагдахаар байсан.

Тухайн сумын Засаг дарга яасан бэ гэхээр яг тухайн сумандаа байдаг гарын уртай хүний компани оруулж ирээд шууд гэрээ хийгээд өнөө зуухыг нь засаад 10 хоногийн дотор зуухыг буцаад ажилд нь оруулсан.

Ингэснээрээ хүүхдүүдийн хичээл тасалдаагүй, дотуур байр нь хөлдөөгүй, сургууль нь хөлдөөгүй. Цааш ажил хэвийн явсан байгаа юм. Сургалт нь.

Харамсалтай нь яасан бэ гэхээр дараа жилийнх нь аудитын дүгнэлтээр бусдад давуу байдал бий болгосон, Тендерийн хуулийг зөрчсөн, Худалдан авалтын тухай хуулийг зөрчсөн учраас Эрүүгийн хуулийн 22.1 гэдэг заалтаар яллагдагч болоод явсан байгаа юм. Сумын Засаг дарга.

Гэтэл нөгөө талдаа бодит байдал дээр одоо яаж байна вэ гэхээр нэг нам дотроо хоорондоо үзээд эхлэхээрээ, тэмцэлдээд эхлэхээрээ янз бүрийн нүүрсний хэргүүд, янз бүрийн ногоон автобусны хэргүүд гээд маш их хэмжээний тоотой, маш их олон эзэн холбогдогчтой, үнэн худал нь мэдэгдэхгүй хэргүүд сошиалаар дүүрдэг. Үүний эцэс нь харагддаггүй. Тэгээд хэрүүл маргаан дууслаа. Өнөө хэргүүд маань замхраад алга болдог. Ийм байдал үргэлжилж байна.

Тэгэхээр миний асуудалд юу байгаа вэ гэхээр хоёр асуулт байгаа юм.

Нэгдүгээр асуулт нь, авлига, албан тушаалын хэрэгтэй тэмцэж байгаа энэ тэмцэл, энэ бодлого маань өөрөө байгаа болохгүй байна. Энэ үр дүнгүй байна.

- ▶ Ажил хийж яваад авлигын асуудалд орооцолддог тохиолдлууд байна.
- ▶ Авлига аваад арга хэмжээ, хариуцлага авагддаггүй, хариуцлага үүрдэггүй тохиолдлууд их байна.

**С.Бямбацогт:** Үргэлжлүүлээд 1 минутыг өгье.

**Д.Батбаяр:** Тэгэхээр ажил хийж явж байгаад эндэх тохиолдлууд нь их байгаад байна. Авлига авсан боловчиг арга хэмжээ авхуулахгүй тохиолдлууд нь байгаад байна.

Юуг харуулаад байна гэхээр энэ бодлого маань өөрөө байгаа олохгүй байна гэдгийг харуулаад байна.

Тэгэхээр бид 10 жилийн хугацаагаа аваад үзье. 10 жилийн хугацаанд засаг барьсан намын даргын хувьд Та авлигын эсрэг энэ тэмцэл үр дүнгүй байгаа гэдэг дээр ямар байр суурьтай байна. Нэгдүгээр асуулт нь.

Хоёрдугаарт нь, Авлигын төсөөллийн индекс гэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2015 оноос хойш тасралтгүй доошоо буусан байна. Ирэх жил ахиад буух юм бол Та Ерөнхий сайдынхаа хувьд хариуцлага хүлээж чадах уу гэсэн ийм хоёр асуулт байна. Баярлалаа танд.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм. Би тантай санал нэг байна. Өнөөдрийн тогтолцоо асуудлыг шийдэхгүй. Үүнийг углуургаар нь шийдэх ёстой.

Тийм учраас 2016 оноос хойш эхлүүлсэн ажлуудаа л үргэлжлүүлж байна л гэж би хэлээд байгаа юм.

- Системийн хувьд, дэд бүтцийн хувьд бэлэн.
- Хуулийн хувьд олон ажлыг ахиулсан, урагшлуулсан.

Орчин үед авлигатай тэмцэхийн тулд ил тод байдлыг хүчээр шахаж шаарддаг.

Хоёрт, дижитал шилжилтийг дэмждэг. Лиценз, зөвшөөрөл төрөөс олгож байгаа эрх олголтуудыг нь бүгдийг нь хүний оролцоогүй болгодог.

Дээрээс нь хариуцлагын системийг зөвхөн “Кэй Пи Ай” дээр үндэслэдэг. Эдийн засгийн хөгжлийн сайд байхдаа “Кэй Пи Ай” үндэсний 10 үзүүлэлтийг оруулж байсан.

Үндэсний индикаторууд дээрээ хэмжээд хариуцлага тооцдог механизм руу явна.

Дээрээс нь авлигатай тэмцэнэ гэдэг бол төрийн төлөө шударгаар ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг хамгаалахад орших ёстой. Бас.

Тийм учраас өнөөдөр худалдан авах ажиллагааг ахалдаг төрийн албан хаагчгүй боллоо шүү дээ. Энэ чинь юу вэ гэхээр бүгдээрээ шийдвэр гаргахаас айж байна. Бүгдээрээ гарын үсэг зурахаас айж байна.

Тийм учраас бид төрийн албан хаагчдыг шударгаар ажлаа хийхэд хамгаалах механизмыг нь хамтад нь авч явах ёстой.

Дээрээс нь бид энэ Тендерийн хуульдаа өөрчлөлт оруулах ёстой учраас Их Хурлын гишүүдийн хамтаар энэ Тендерийн хуулийг боловсруулж байсныг өргөн мэдүүлнэ.

Тендерийн хуулиар бид үе шатуудыг ойлгомжтой болгоно. Зарим шаардлагатай өөрчлөлтүүдийг хийх ёстой. Тэгэхгүйгээр өнөөдрийн Тендерийн хуулиар буюу зөвхөн үнэ бага санал өгсөн бол ч гэдэг юм уу, төрийн өмчит компаниуд хоорондоо заавал тендер авч бараа, материал худалдан авдаг. Өнөөдөр ялангуяа үйлдвэр заводууд дээр жишээ нь машин нь эвдэрлээ гэхэд заавал тендер зарлаж тоног төхөөрөмж авдаг байдлаасаа болоод тэнд эдийн засаг л гацаад байгаа шүү дээ. Тэгээд бид гацаанаас гаръя гэж байгаа бол зоригтой хийх ёстой.

Тийм учраас Их Хурлын гишүүддээ амьдралыг илүү ярьж, тантай би санал нэгдэж байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Цэндийн Баатархүү гишүүн 3 минут. Болсон.

**Ц.Баатархүү:** Их Хурлын гишүүддээ өдрийн мэндийг хүргэе.

Монгол Улс ардчиллын баян бүрд байсан бол өнөөдөр авлигын баян бүрд болох хэмжээнд байна. Энэ бол авлигын төсөөллийн индекс болон авлигатай холбоотой бусад үзүүлэлтээр харагдаж байна.

Авлигатай уриа лоозонгоор, бас уран үгээр биш учир шалтгаанаар нь тэмцэх ёстой. Би бол тэгж боддог.

Монголын төр авлигатай тэмцэх, хулгайтай тэмцэх энэ тэмцэлд ялагдсан гэж бодож байна.

Монгол Улсын Засгийн газарт авлигатай тэмцэх улс төрийн хүсэл эрмэлзэл байна уу гэдэгт би эргэлзэж байгаа.

Таны уран үг, үйлдэл хоёр зөрж байна. Учир юу юм бэ гэхээр авлига хаана байна вэ гэхээр –

- хаана нь нууц байна, түүнд авлига оршдог,
- хаана нь мөнгө, төсөв их байна, түүнд авлига оршдог.

Улсын Их Хурал хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс Хянан шалгах түр хороо байгуулах санаачилгыг гаргасан.

- **Ухаа худгийн хянан шалгах түр хороог** танай Засгийн газрын зарим гишүүд дэмжээгүй.
- **Харбины гэрээг ил тод болгох хянан шалгах түр хороог** танай Засгийн газрын гишүүд дэмжээгүй.

Одоо танаас дахиж асууя. Улсын Их Хурал дээр Засгийн газрын нууцад авсан энэ гэрээг, цаашдаа олон гэрээнүүдийг ил тод болгох, нээлттэй болгох, нэг мөсөн эргэлзээг нь тайлах энэ Хянан шалгах түр хороог танай Засгийн газар дэмжих үү?

Тэр дундаа 1992 оноос хойш Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын газар олголт хуулийн хүрээнд байсан уу, үгүй юу гэдгийг хянан шалгах түр хороог Ерөнхий сайдын хувьд Та дэмжих үү гэдэгт тодорхой хариулт өгөөч ээ.

**Н.Учрал:** Адилхан залуу хүн байж тэгээд юун ч амархан бууж өгдөг юм. Би бол бууж өгөхгүй. Тэгээд Ц.Баатархүү сайд аа.

Та миний ажлыг тухайн үед аваад миний өрөөнд орж ирж Таны эхлүүлсэн цахимжилтын энэ олон ажил, e-mongolia дээр хийсэн ажлууд, шилэн ажиллагаа бол авлигыг бууруулах уг үндсийнх нь шийдэл байжээ гэж хэлж байсныг би тод санаж байна.

Тийм учраас би уран үг ярихдаа их дургүй хүн. Гэхдээ хийсэн ажлаа бол бахархалтайгаар ярьдаг. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс цахим засаглалын индексээрээ л урагшилсан юм. “Нээлттэй засгийн түншлэл” авлигыг бууруулах

ганц шийдэл ч энэ л гэж хэлсэн юм. Дэлхийн засгийн газруудын дээд хэмжээний уулзалт үүнийг л үнэлсэн.

Тийм учраас цахимжилтыгаа амилуулъя гэвэл Таны ярьдаг энэ бүртгэл, газар олголт, лиценз бүгдийг нь blockchain дээр оруулъя. Энэ бүрэн боломжтой. Ингээд дараа нь бүх хамаарлууд нь тогтоогдоод явна гэдэгт би эргэлзэхгүй байгаа.

Тэгэхээр “авлигын баян бүрд” гэж хэлж болохгүй. Монголд ардчилал байгаа. Би үргэлж итгэдэг. Монголд ардчилал байгаа шүү. Монголын ард түмэн ардчиллын төлөө үзэл санаатай. Бидний үеийнхэн энэ зах зээлд шилжсэн нийгэмд төрж өссөн хүмүүс үгээ хэлдэг, үзэл бодлоо илэрхийлдэг, шүүмжилж чаддаг. Бид их азтай оронд төрсөн хүмүүс шүү.

Тийм учраас сөрөг хүчний индрээс ярих бас чухал байдаг байх. Гэхдээ бүгдийг үгүйсгэж сөрөг хүчин хийх нь надад таалагдахгүй байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. 3 минутад манай Б.Жаргалан гишүүн 1 минут 30 секунд асуугаад хариулт авъя. Тэгэх үү. Боломж олгоод. Зүгээр үү?

Тэгвэл Ц.Баатархүү гишүүн нэмэлт асуултаа асууя.

**Ц.Баатархүү:** Сөрөг хүчний индэр гэдэг зүйл байхгүй.

Бид нэг Монгол Улстай. Улсын Их Хурлын гишүүд нэгдэж нийлээд хяналтын түр хороо байгуулах энэ санаачилгуудыг Та Ерөнхий сайдынхаа хувьд дэмжих үү гэж би асуугаад байгаа.

Тэр дундаа нийслэл Улаанбаатар хотын газар олголтыг хянан шалгах түр хороо байгуулахыг дэмжих юм уу? Хэрвээ үнэхээр авлигатай тэмцье гэвэл Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд асуудлыг нээлттэй болгох энэ санаачилгыг л Засгийн газар дэмжээд өгөөч гэдэг ийм тодорхой асуулт асууж байгаа. Энэ бол улс төрийн асуулт биш. Ажил хэргийн асуулт байлаа.

Та харин маш их уурсаж улс төржиж байгаа байдалд би их харамсаж байгаагаа илэрхийлье.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд.

**Н.Учрал:** Түр хороо байгуулах эрх Их Хурлын эрх. Энэ газар олголттой мэдээллийг би одоогоос 2022 он байх шүү. 2022 онд shilen.gov.mn дээр тавьсан шүү дээ.

Улаанбаатарын бүх газар олголтыг, хүний өөрийн гэлтгүй бүгдийг нь тавьсан. Хэн нь ч ороод хэн газар олгосон юм, хэний газар юм. Бүгдийг нь мэдэж болно шүү дээ. Үгүй үгүй. Улаанбаатар хотыг тэр газар олголттой холбоотой түр

хороо байгуулаад Их Хурлын гишүүд дэмжвэл би орж ирээд мэдээллээ хийгээд би бүгдтэй нь хамтраад ажиллана. Энэ бол Их Хурлын гишүүд олонхоороо шийдэх асуудал шүү.

Тийм учраас ардчилсан парламентыг би үргэлж хүндэтгэнэ. Ардчилсан парламент ямар ч түр хороо байгуулсан би үргэлж дэмжинэ. Шаардлагатай бол би орж ирээд асуултад нь хариулна. Та бүхний санал, санаачилга шаардлага бүхнийг биелүүлнэ.

Монгол Улс бол парламентын засаглалтай орон.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалан:** Авлигал бол тогтолцооны суурь асуудал болсон гэж Та хэллээ.

Тэгвэл энэ авлигажуулсан тогтолцооны үндэс суурь нь, хөдөлгөх хүч нь, амин сүнс нь сүүлийн 36 жилийн дийлэнх олонх цаг хугацаанд эрх барьсан Монгол Ардын нам өөрөө болоод байна гэдгийг Та хүлээн зөвшөөрөх үү?

2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө танай намын 60 тэрбум төгрөгөөр төрийн өндөр албан тушаалд наймаалцах нууц төлөвлөгөө ил болсон боловч танай нам сонгуульд үнэмлэхүй олонхын ялалт байгуулсан.

Энэ цаг хугацаанаас хойш төрийн хулгай, хэргийн тоо, үнийн дүн тэрбумаар биш их наядаар хэмжигдэх болсон.

Авлигын эсрэг тэмцэл чинь нам дотроосоо эхлэх ёстой. Танай нам цэвэршихгүй бол Монгол Улс хөгжихгүй гэдгийг Монголын иргэд бүгд харж байна. Тэгээд энд та танай, манай гээд байх зүйл ерөөсөө байхгүй.

Сүүлийн 10 жилд Монгол Улсын төсөв үлэмж тэлсэн. Төрийн өмчийн компаниуд даам гарсан. Авлига огцом өссөн. Энэ бүхэнд танай намын л оролцоо байсан.

Тэгэхээр Та нам дотроо энэ цэвэрлэгээг хийж чадах юм уу, үгүй юу гэдгийг л бид харж байгаа. Танай гэж хэлсээр байгаад улс төрийн хэлмэгдүүлэлтийг сүүлийн 10 гаруй жилийн туршид явуулж байгааг хүлээн зөвшөөрөх үү?

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Танай манай гэж ярих нь бол зохимжгүй. Бид хүнээс илүү системээ л ярих ёстой.

Тэгэхээр Та бид залуу хүмүүс. Хуучны арга барилаасаа салж, жоохон урагшаа харж, зоригтой золбоотой ажиллахгүй бол танай манай гэж хэрэлдсээр байтал болохоо болилоо шүү.

11 сарын 17-нд намын даргаар би сонгогдсон. Тийм. Миний цаг бол тэндээс эхэлсэн. Тийм.

Тийм учраас авлигатай тэмцэх тэмцэлд би үргэлж хатуу байр суурьтай зогсоно. Танай манай гээд байх юм байхгүй. Бүх нам цэвэрших ёстой. Улс төрийн намууддаа би үргэлж уриалдаг.

- Нам дотроо цэвэрлэгдэх ёстой,
- цэвэрших ёстой,
- хариуцлагатай байх ёстой,
- ёс зүйтэй байх ёстой.

Тэгж чадаад нам нь эрүүл байвал төр нь эрүүл байна. Өөрөө парламентын засаглалын хамгийн сонгодог засаглал чинь өөрөө юу вэ гэхээр нам нь төрийг бүрдүүлдэг. Нам нь цэвэрших ёстой.

Тийм учраас намаа цэвэршүүлэхийн төлөө бидний залуучууд аль аль талдаа хичээн зүтгэе. Тийм. Танай манай гэж яривал танайд ч байна манайд ч байна. Гэхдээ 11 сарын 17-нд миний цаг эхэлснээс хойш бол би намаа цэвэрлэх, цэгцлэх ажилдаа ханцуй шамлаж орсон.

Харин танайд байгаа хүмүүсийг надаас илүү Та бүгдээрээ л мэдэж байгаа.

Тийм учраас наад хүмүүстээ ч гэсэн адилхан хариуцлагыг нь яриад одоо ингээд урагшлахгүй бол бүгдээрээ хүн ярьсаар яваад байвал дийлэхгүй шүү.

Ерөнхий сайд болоод би хэлсэн шүү дээ.

Ерөөсөө л хүн ярихгүй би.

- Шүгэл үлээж хэт их попрохгүй ээ.
- Янз бүрийн кино драм хийхгүй ээ.
- Энтертайнмент хийхгүй ээ.

Үр дүнгээрээ харуулна гэж. Би өнөөдөр 24 хонож байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Ямар ч байсан цөөнхийн бүлгийн гишүүд бүгд асуултаа асууж амжлаа.

Ингээд цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 15 минут. /алх цохив/

Д.Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Сайн байна уу? Та.

Нэгдүгээр асуулт болохоор 2014 оноос хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болсон.

Тэгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэх процесс нь хуульдаа тодорхойгүйгээсээ болоод үзэмжийн шинжтэй, улс төрийн шинжтэйгээр хуулийн этгээдүүдэд хариуцлага ногдуулахдаа, таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахдаа үзэмжийн шинжтэй арга хэмжээнүүд авдаг болсон.

Бизнесийн үйл ажиллагааг түдгэлзүүлэхдээ, мөн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахдаа, данс тооцоог нь хаахдаа энэ байдлууд аж ахуйн нэгжүүдэд маш хүндээр тусаж байгаа.

Тэгээд бизнесийн байгууллагуудын хувьд эрсдэлийн түвшнийг үзэхэд бизнесийн тасалдал маш том байр суурийг эзэлдэг.

- Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд 1-ээс 3 сар болоход үйл ажиллагаа нь зогсоод, дансыг нь хаахад эрсдэлд орж, дампуурах хэмжээнд очдог.
- Дунд болон том аж ахуйн нэгжүүдийн хувьд 3-аас 6 сар болоход эрсдэлд орж, дампуурах хэмжээнд бараг очдог.

Тэгээд аж ахуйн нэгжтэй, өөрөөр хэлбэл субъектив сэдэлгүй хуулийн этгээдэд хариуцлага ногдуулахдаа тодорхой процессгүйгээсээ болоод энэ аж ахуйн нэгжүүдийг яг хэрэг хянан шийдвэрлэх явцдаа дампууруулах хэмжээнд. Өөрөөр хэлбэл хувь хүнээр бол хэрэг хянан шийдвэрлэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулах явцдаа бараг цаазаар авах хэмжээний ийм ялтай хууль эрх зүйн орчин өнөөдөр байна.

Тэгээд үүнтэй холбогдуулаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулахаар. Өөрөөр хэлбэл саяын тэр шүүхээс таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа, тодорхой үйл ажиллагааг түдгэлзүүлэхдээ болон прокуророос мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулахдаа хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр гаргахдаа тодорхой нөхцөлүүдийг харгалзаж үздэг, тодорхой хугацаатай процесстой санал оруулсан байгаа.

**Н.Учрал:** Д.Энхтүвшин гишүүн Зөвшөөрлийн хуулийн ажлын хэсгийг ахалж байгаа.

Дээрээс нь бизнесийн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр боомилдог, дансыг нь хугацаагүй хаадаг, хяналтгүй байдаг тогтолцоог өөрчлөх гээд Эрүүгийн процессын хуулийг хөндөөд явж байгааг би зарчмын хувьд дэмжиж байгаа.

Тийм учраас энэ хууль асар их чухал. Данс битүүмжлэх ч бай, үл маргах журмаар өр барагдуулах, мөрдөн шалгах явцад компаниудын үйл ажиллагааг саатуулах арга хэмжээ нь өөрөө хяналттай байх ёстой гэдэг. Би үүнийг дэмждэг.

Тийм ч учраас сая Ерөнхий сайдаар томилогдсоныхоо дараа татварын байцаагч нарын хаасан байсан нийгмийн даатгалын болоод данснуудыг нээсэн.

Ингээд данснуудыг нээсний дараа 12 мянга орчим байх шүү. Данс нь. Нээсний дараа 10 хоногийн дотор 37 тэрбум. Өнөөдөр 42 тэрбум төгрөг эргэж төлөгдсөн.

Тэгэхээр төр ард түмэндээ, иргэд, аж ахуйн нэгжүүдээ итгэж чадвал, тэр боломжийг олговол ямар тод үр дүн байдаг вэ гэдгийг энэ шийдвэр нотолж байгаа гэж бодож байгаа. Хаагаад, хязгаарлаад илүү далд эдийн засгийг л бий болгоод байдаг.

Тийм учраас компаниудын үйл ажиллагаа, баялаг бүтээгчдийг дэмжих нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа.

Тийм учраас бүх үл маргах журмаар татвар хаадаг, компаниудын дансыг битүүмжилдгийг хяналтад байлгая. Үүн дээр тодорхой эрүүгийн процессынх нь механизмыг эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад үүссэн харилцааны хэм хэмжээг нь маш зөв зохицуулъя гэдэг энэ санал, санаачилга Та бидний хамтын ажил гэж би үзэж байгаа.

Тэгээд цаашдаа иргэддээ итгэж урагшилна. Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг барих үеэр ч гэсэн бид хэрвээ өр төлбөрөө төлөөгүй байсан хэдий ч бид тодорхой цалингаа тавих, тодорхой хэсгийг нь үлдээж байж компани хэвийн үйл ажиллагаа явах бололцоогоор хуулиар хангуулахаар Татварын хуулийг өргөн барина.

**С.Бямбацогт:** Тодруулах уу? 1 минут. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Бизнес эрхлэгчдэд өнөөдөр тулгамдаж байгаа нэг чухал асуудал бол хүний нөөцийн асуудал байгаа.

Тэгэхээр хүний нөөцтэй холбогдолтойгоор танай зөвлөхүүдийн илэрхийлж байгаа байр сууриудаас харахад оюутан болон тэтгэврийн насны хүмүүсийг

хөдөлмөрийн зах зээл дээр оруулж ирэх талаар тодорхой хэмжээний бодлого, энэ талаар арга хэмжээ авах тийм бодолтой байгаа гэж ойлгосон.

Тэгэхээр энэ талаар ямар нэгэн төлөвлөж байгаа татвар хураамж ч юм уу, хөдөлмөрийн зах зээлийг тэлэх талаар хийж байгаа, бодож байгаа ажил байгаа юу?

Дээр нь гаднаас, ялангуяа улирлын шинжтэй бизнесүүд дээр гаднаас ажиллах хүчин авахтай холбогдуулж татвар ногдуулж байгаа байдлыг өөрчлөх, татвар хураамжийг нь багасгах ийм бодол байгаа юу гэсэн асуулт байна.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Ажиллах хүчний оролцооны түвшин өнгөрсөн жил 63.2 хувьтай байсан. Одоо 61-д хүрлээ. Нэг ёсондоо 10 хүн тутмын 6 нь ажил огт хайхгүй, ажил эрхлээгүй байна гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр ажиллах хүчний оролцооны түвшнийг ахиулна гэдэг бол хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх бололцоотой бүлгүүдийг дэмжих бодлого.

Тийм ч учраас төрийн албаны багц хуулийн шинэчлэлийг хийнэ. 213 мянган төрийн албан хаагч байгаад данхар төрийн албатай болсон гэж ярьдаг. Гэхдээ нэг сургууль баригдаад л 150 багш, ажилчид нэмэгдээд байхаар төрийн алба данхар юм шиг харагдаад байдаг.

Тэгэхээр бид “public service”, “CV service” гэсэн ангиллаа тодорхой болгож урагшилна.

Яг Таны хэлж байгаагаар оюутны цагийн хөдөлмөр эрхлэлтийг тодорхой болгоно.

Дээрээс нь ахмад настны тэтгэвэртээ гарсан хэдий ч ажиллах бололцоотой хүмүүст ажил олгох шинэ механизмыг бий болгоно. Ингэж байж ажиллах хүчний оролцооны түвшнийг ахиулна.

**С.Бямбацогт:** Баярлалаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тогтмолын Мөнхсайханы урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Шинэ Монгол” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ удахгүй болох гэж байгаа улсын шалгалтдаа сайн бэлдээрэй. Тэгээд хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцахын ерөөлийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс, энд сууж байгаа “Шинэ Монгол”

сургуулийг үндэслэн байгуулагч Ж.Галбадрах багшийнхаа нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье. /алга ташив/

Одоо Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

**О.Саранчулуун:** Надад хууль тогтоомжийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой хоёр асуулт байгаа. Дараа нь тодруулахдаа төсөвтэй холбоотой хоёр асуултыг тодруулъя.

2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үйлдлийн чадамжийг олон улсын жишгээр үнэлнэ гэдэг ийм төлөвлөгөө орсон байгаа.

Энэ дээр яригдаад л байдаг, яригдаад л байдаг бараг 10 жил болж байгаа. Тэгээд ерөөсөө ахиц гардаггүй.

Тэгэхээр нь 2025 оны 12 сард миний бие өөрөө бүх яамдыг оролцуулаад бид хэлэлцүүлэг хийсэн. 3 яаманд замын зураглалыг нь гаргаж өгсөн. Яаж хийхийг нь заагаад, тайлбарлаад, олон улсынх нь хүмүүсийг авчраад ингээд эхлүүлээч гэсэн. Одоо 2026 он болж байна.

Тэгэхээр Гэр бүлийн яам дээр илүү манлайлаад, Эрүүл мэнд боловсролын яам оролцоод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийнхээ яг хөгжлийн бэрхшээл нь юундаа байгаа юм бэ гэдгийг нь тодруулдаг тогтолцоо руугаа шилжмээр байна.

Энэ дээр ажил ямар шатад явж байгаа талаар мэдээлэл хүсэж байна.

Хоёрдугаарт нь, ахмад настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй ч юм уу, ер нь хүнд өвчний дараа хүн эмнэлгээс гараад эхний 6 сар очих газар байдаггүй. Ерөөсөө байхгүй. Сувиллууд тийм хүнд нөхцөл хүлээж байхгүй. Амь нас нь эрсдэлтэй гээд. Эрүүл мэндийн хувьд.

Тэгэхээр хүмүүсийн очих газар хэрэгтэй байгаа.

Тэгэхээр үүнийг бид яаж зохицуулах ёстой юм бэ? Энэ дээр уг нь бид 5 жилийн төлөвлөгөөнд сэргээн засах тусламж үйлчилгээг олшруулна гээд ярьчихаад байгаа. Гэхдээ дээр ямар алхам товлогдсон бол оо? Одоо дээр Засгийн газрын үйл ажиллагааны хувьд болон юу төлөвлөж байгаа талаар мэдээлэл авъя.

**Н.Учрал:** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлуулахад би ажлын хэсэгт ажиллаж байсан.

Өөрөө 6 жил Сонгинохайрхан дүүрэг дээр гэр бүлийнхээ санал санаачилга, санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан “Тэмүүжингийн

андууд” гээд цэцэрлэгийг ажиллуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ жаргал зовлон дотор би 6 жил ажиллаж амьдарсан хүн.

Тийм ч учраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийгээ дэмжье гэдэг итгэл үнэмшил надад байдаг учраас О.Саранчулуун гишүүнтэйгээ энэ асуудал дээр хамтарч ажиллаж, Их Хурал дээр ч тэр ажлын хэсгийг нь ахлуулж байсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд би төсвийн бодлогоо чиглүүлнэ гэдгийг Танд хариуцлагатай хэлье.

Азийн хөгжлийн банкны 96 тэрбумын нэг санхүүжилт байгаа юм билээ. Түүнийг бодитой хэрэгжүүлэхэд, ялангуяа тэр Дорнод, Улаанбаатар, Дархан гээд хэд хэдэн газар байгаа юм билээ. Тэгээд энэ барилга байшинг бариулахад би онцгойлон анхаарна.

Дээрээс нь улсын хэмжээнд барилга, байшинг барихад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандартыг нэвтрүүлэх шаардлагыг үргэлж шахаж шаардана.

Аймаг, орон нутагт үүнийг дэмжлэг үзүүлж ажиллана.

Тэгээд мэдээж энэ асуудлуудыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, мөн Эрүүл мэндийн яам санхүүжилтийг нь тодорхой болгоход анхаараарай гэдэг би тодорхой чиглэлийг өгч төлөвлөгөө гаргаж ажиллуулна гэдгээ хэлье. Тийм.

**С.Бямбацогт:** Отгоны Саранчулуун гишүүн нэмэлт 1 минут.

**О.Саранчулуун:** Барилга, хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд нэлээн ахицтай явж байгаа юм байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнээ дахин үнэлэх систем рүү шилжих дээр онцгой анхаарч, энэ эхэлсэн замын зураглалаа бариад явахад 3 яаманд газрын зураг нь бэлэн байгаа шүү. Энэ дээр ажил хэрэг болгох хэрэгтэй байгаа.

Хоёрдугаар асуудлыг хэлье. Улсын төсвийн асуудал байгаа. Төсөв дээр төсвийг тодорхойлж оруулж ирэхдээ, төсвийн зардлын ангиллыг тодорхойлохдоо хөгжлийн бэрхшээлтэй хүн хүртээмжтэй холбоотой зардлыг харагдахуйц байдлаар гаргаач ээ гээд байгаа юм. Энэ нь төсвийн бүх захирагч нарт хамаатай асуудал байгаа.

Засаг дарга нар, яам Тамгын газар, агентлаг бүгдээрээ. Энэ нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авсан тухай асуудал биш байгаа. Орчноо хүртээмжтэй болгох, мэдээллээ хүртээмжтэй болгох. Одоо Та бид хоёрын ярьж байгаа яриаг хүртэл доогуур нь хадмалтай болгоод хүмүүст хүргэх асуудлуудыг зардалд тусгамаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ талаар би саналыг Сангийн яаманд удаа дараа тавьсан байгаа. Энэ ажил дээр өнөөдөр ямар ахиц гаргах вэ? Ер нь... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Та бидний баталсан төсөв дээр 49 тэрбум төгрөг, Азийн хөгжлийн банкны зээл, тэгээд Японы сангийн тусламж гээд хэд хэдэн төсөв байгаа юм билээ.

Би үүний хэрэгжилтийг нь шахаж шаардаж ажиллана гэдгээ Танд хэлье.

Ирэх оны төсвийг барихад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч зорилтот чиглэсэн хөтөлбөрүүдийг бас тусгах дээр төсвийн бодлогоо чиглүүлье.

Гэхдээ өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төсвийн тогтвортой байдлын хуулиар бид чинь төсвийнхөө бараг 75 хувийг урсгалыг санхүүжүүлж байна. Тэгээд 8 их наядын хөрөнгө оруулалттай. 8 их наядын 4 их наяд нь нийслэлд. Үлдсэн 4 их наядын 1.3 зээл, 1.3 нь гээд. Ингээд ерөөсөө чинь хумигдмал байдалтай.

Тэгэхээр урсгалыг санхүүжүүлэх шаардлага байгаа юм.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын хуулиа эргэж харах хэрэгтэй байгаа шүү гэдгээ хэлье.

**С.Бямбацогт:** О.Саранчулуун гишүүн тодруулж асууя.

**О.Саранчулуун:** Энэ дээр нэг ойлголтыг тодруулах хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн юм уу, энэ бүлэг хүн амын асуудлыг ярихдаа бид шинэ зардал нэмэх тухай ярина гэхээсээ илүү одоо байгаа зардлыг, төлөвлөлтийг зөв зохистой чиглүүлэх ажил байгаа.

Жишээлбэл, өнгөрсөн Засгийн газар буюу Г.Занданшатар Ерөнхий сайд байхад бид “Хөгжлийн бэрхшээл ба улсын төсөв” гэдэг хэлэлцүүлэг хийгээд хүүхдүүдээ эрт оношлох тоног төхөөрөмж авъя гээд шийдсэн. Одоо болтол түүн дээр яг ямар процесс болсон бэ гэдэг мэдээллийг ээжүүд, гэр бүлийнхэн асуусаар байгаа байхгүй юу.

Ер нь энэ тендер нь зарлагдсан юм уу, тоног төхөөрөмжөө авсан юм уу. Хүүхдүүдээ эрт оношилж чадах тусмаа эрт сэргээн засаад, хөдөлмөрийн чадвартай ажил хийдэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ хөл дээрээ босгох боломжтой болох гээд байгаа байхгүй юу.

Дээрээс нь гадагшаа явж эмчилгээ хайдаг, хандив гуйдаг нөхцөл буурах гээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр мэдээлэл, явцыг авъя.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Төсвийн зарим ангиллыг шинэчлэн батлах тухай Сангийн сайдын тушаал байдаг. Тэгээд тушаал батлагдсан.

Тэгэхээр зарлагын ангиллаар нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээ гэсэн арга хэмжээг энд нь тусгаад явж байгаа юм.

Тэгэхээр энэ арга хэмжээнийх нь дотор Таны хэлж байгаа гол бодлого, үйл ажиллагаануудыг тусгаж ажиллая. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн байгууллагад очиж үйлчилгээ авахтай холбогдуулсан тусгайлан шаардагдах үйлчилгээний зардлыг тодорхой болгож төлөвлөө.

Тэгээд Г.Занданшатар Ерөнхий сайдын үеэс эхлүүлсэн ажлыг Та бид хамтдаа үргэлжлүүлэхэд би нээлттэй байна гэдгээ хэлье. Тийм.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цагтаа бүгд багтлаа.

Одоо асуултаа ирүүлсэн Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна.

Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 30 минутаас хэтрэхгүй.

16.00 цагаас санал хураалттай. Хоёр асуудлаар санал хураалт явах ёстой. Чуулганы хуралдааны танхимдаа 16.00 цагт бэлэн байхыг Их Хурлын гишүүддээ урьдчилж зарлаж байна.

Хуралдаан зохион байгуулах газар Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүд, зөвлөлүүд гишүүдээ санал хураалтад бэлтгүүлээрэй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна.

**М.Нарантуяа-Нара:** Сайн байна уу? Өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр Н.Учрал Ерөнхий сайд Ерөнхий сайд болсноосоо хойш залуу хүний эрч хүч, зоригор үнэхээр олон зүйлүүдийг, тэр дундаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд таатай байдлаар хэрэгжүүлэхээр хичээж байгаа нь үнэхээр сайшаалтай сайхан байна.

Харин энэ дунд маш олон гоё гоё шийдвэрүүд гарч байгаа ч гэсэн бодит амьдрал дээр яг хэрхэн уялдаа холбоо, тогтвортой байдал, үр нөлөө үзүүлж байгаа талаар иргэдийн дунд эргэлзээ үүссэн асуудлууд байгаад байна л даа.

Жишээлбэл, сая аж ахуйн нэгжүүдийг тийм ээ, татварын өртэй аж ахуйн нэгжүүдийн дансыг битүүмжилсэн байсан байдлыг нэг сарын хугацаанд нээж өглөө.

Энэ тэгвэл нийтдээ хэдэн аж ахуйн нэгжүүд татварын өртэй байснаас 12 мянга 100 гаруй аж ахуйн нэгжүүдийн дансыг нээсэн бэ? Жишээлбэл, дансаа нээлгээгүй зарим нэгэн компаниуд байна. Тийм ээ. “Монполимет” группээс авхуулаад дансаа нээлгэе гэж байна.

Тэгэхээр энд ямар нэгэн шалгуураар нээсэн үү? Тэгээд нийт өрийн хэмжээ хэд байснаас одоогийн байдлаар хэдэн аж ахуйн нэгжүүд өр төлбөрийг барагдуулсан ийм үр дүн гарч байна.

Өөрөөр хэлбэл данс нээсэн асуудал маань тийм ээ, данс хааж байна, данс нээж байна. Ер нь төр аль болох хувийн хэвшилд оролцохгүй байя гээд байгаа. Гэхдээ данс хаадаг байдлыг бүр больж болдоггүй юм уу?

Нөгөө талаар бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг нэг сарын хугацаанд дансыг нь нээж өгч байгаа нь энэ өөрөө нэг сарын хугацаанд аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа бүрэн нөхөх, өрөө төлөх, борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх ийм бодит дэмжлэг болж чадаж байна гэж Та харж байна уу? Жишээлбэл, яг одоо энэ цаг үед худалдан авалтын түвшин эрс буурсан, эдийн засаг ер нь нэлээн хэцүү байна.

Тэгэхээр энэ нийгмийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаар бас шат шатад шийдвэрийн хэрэгжилт ямар байгаа талаар мэдээлэл өгөөч ээ гэж хүсэж байна.

Мөн түүнчлэн 146 аж ахуйн нэгж... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Гүйцээгээд асууя.

**М.Нарантуяа-Нара:** 146 бизнесийн үйл ажиллагааг сонгосон шалгуур үндэслэл нь юу байсан юм бол оо? Бас ямар судалгаанд үндэслээд бизнесийг сонгосон бэ?

Энэ дунд ч жишээлбэл тийм ээ, шалгуур үзүүлэлтгүй байх ёстой гэсэн чинь нөгөө талд хэрэглэгчийн эрх ашиг, эрүүл, аюулгүй байдлыг хэн хангах вэ гэдэг асуудлууд бас хэрэглэгч талаасаа үүсээд байна л даа.

Мөн түүнчлэн шалгуургүй боллоо. Зөвшөөрөл авахгүйгээр хэрэгжих, хийх боломжтой боллоо гэсэн мөртлөө жишээлбэл “Гэйт” компанийг л гэхэд 5 саяар

торгосон байна. Гэтэл Таны гаргасан энэ шийдвэрийг доод шатад хэрэгжүүлэхгүй байгаа асуудлыг хэрхэн яаж хангах вэ гэдэг талаар асуулт асууя.

**Н.Учрал:** 12 мянга 549 татвар төлөгч байсны 396 нь шүүхийн шийдвэртэй байсан.

Тэгэхээр нэгэнт шүүхийн шийдвэр гарсан бол Засгийн газар шүүхийн шийдвэрийн дээр шийдвэр гаргах бололцоо байхгүй. Нэгэнт шийдвэр гүйцэтгэл тодорхой болсон.

Хэрвээ данс нь нээгдээгүй гэвэл тэр бол шүүхийн шийдвэр гарсан 396-д багтаж байгаа гэж би бодож байна. Яг тоо нь бол 12 мянга 153 татвар төлөгчийн битүүмжилсэн байсан дансыг нээсэн.

10 хоногийн дотор 42 тэрбум төгрөг төлөгдсөн. Нэг ёсондоо тухайн компани дансаа нээгээд үйл ажиллагаагаа явуулаад эхлэхээр нэмэгдэж байна гэсэн үг.

Тэгэхээр төр иргэддээ итгэх ёстой. Гэхдээ үүний цаана юу вэ гэхээр сая Д.Энхтүвшин гишүүний санаачилж байгаа хуультай уялдуулаад бид тэр битүүмжилсэн дансыг нээхдээ хяналтад байлгадаг. Эрүүгийн процессын хуулийг хөндөж бизнесийнхэндээ илүү их боломж олгох талаас нь анхаарах ёстой.

146 үйл ажиллагааг [license.mn](http://license.mn) дээр ороод шууд мэдэгдээд эхэлж байгаа.

Яагаад ийм шийдвэр гарсан бэ гэхээр Их Хурал баталсан Зөвшөөрлийн хууль байдаг. Энэ Зөвшөөрлийн хуулиар 381 зөвшөөрөл л листэд байгаа.

- Тусгай зөвшөөрөл.
- Энгийн зөвшөөрөл.

Энэ зөвшөөрөл бичигдээгүй бусад төрлийн бүх үйл ажиллагаа чөлөөтэй эрхэл гэдэг хуультай.

Тэгэхээр энэ зөвшөөрөл бичигдээгүй үйл ажиллагаануудыг–

- сайдын тушаал гаргаад,
- Нийслэлийн иргэдийн Хурлын тогтоол гаргаад,
- Засгийн газрын тогтоол гаргаад,
- журам гаргаад –

-хуульчилсан байсан, дүрэмлэсэн байсан, журамласан байсан.

Нэг ёсондоо зөвшөөрөл гэж нэр байхгүй мөртлөө –

- эрх олголт,

- батламж,
- лиценз,
- сертификат,
- магадлан итгэмжлэл гээд.

Энэ бол өөрөө хуульд авсан шийдвэр байхгүй юу.

Тэгэхээр 5 даваа давдаг байсан. Тэр 5 давааг бид даваагүй болгоод галын дүгнэлт, тэр нөгөө хот тээврийн гэрээ хоёрыг төр өөрөө очиж хийдэг болсон.

Энэ шийдвэрийг аймаг, орон нутагт шахаж шаардаж, сургалт зөвлөгөөнүүдийг хийж байгаа.

Энэ шийдвэр ямар түвшинд хэрэгжиж байгаа вэ гэдэг талаар долоо хоног болгон Ерөнхий сайдын албан даалгаврын тайланг сонсож байгаа.

Сая гурав дахь өдрийн засгийн хурлаар ажлын хэсэг байгуулж, хяналт шалгалт оруулж байгаа. Орон нутагт.

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулж болно.

**Н.Учрал:** Тийм.

Тэгэхээр манай Засгийн газрын гол концепц бол хувийн хэвшилдээ л их орон зайг тэлье гэж байгаа юм.

Тэгэхээр хувийн хэвшил энэ тэнцвэржүүлсэн орлого GDP-ийн харьцаа 28 болоод, энэ орон зайд ажиллаж чадах юм бол ерөөсөө зах зээл өөрөө эрүүл болох юм байна.

Дээрээс нь төр өөрөө зөвшөөрлөөс татгалзаад, лицензээс татгалзаад эхлэх юм бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих юм байна.

Ер нь Монголд цаашдаа хөдөлмөр эрхэлж байгаа, хийе бүтээе гэсэн хэн бүрийг дэмжих нь л манай Засгийн газрын бодлого.

Тийм учраас хөдөлмөрлөж байгаа хүнд саад болдоггүй, чөлөөлдөг энэ эрх чөлөөний 4 чөлөөлөлт гээд байгаа чөлөөлөлтийн хүрээнд “Эрх зүйн чөлөөлөлт” гээд би гадаадын хөрөнгө оруулалтын хууль, Эдийн засгийн эрх чөлөөний хууль гээд хуулиудыг өргөн мэдүүлэх гэж байна.

“Эдийн засгийн чөлөөлөлт”-ийн хуульд татварын 7, 8 томоохон өөрчлөлтийг хийх гэж байна.

Ингээд “Ногоон хөгжлийн чөлөөлөлт” гээд сэргээгдэх эрчим хүчийг дэмжих чиглэлүүдээр.

“Авлигын эсрэг чөлөөлөлт” гээд бас тодорхой ажлуудыг төлөвлөж ажиллаж байгаа.

**С.Бямбацогт:** М.Нарантуяа-Нара гишүүнд баярлалаа.

Одоо Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

**Б.Мөнхсоёл:** Сайн байцгаана уу? Өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр миний асуулт ипотекийн зээлтэй холбоотой. Ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн тоо маш олон байгаа. Үүнийг бүгд л мэдэж байгаа.

Игээд өнөөдөр иргэд маш их хүлээлттэй. Зарим нь бүр 2-оос дээш жил ипотекийн зээлд хамрагдах хүсэлтээ өгөөд хүлээж байгаа. Зарим нь аргаа бараад хээл хахууль өгөх шинжтэй ийм иргэдийн гомдлууд байна.

Игээд статистик тоонуудыг харах юм бол нийт ипотекийн зээлдэгчдийн 22 хувь буюу 28 мянга 167 иргэд 5 сая буюу түүнээс дээш орлоготой иргэд байгаа нь нөгөө ипотекийн зээлийн анхны бодлого болох—

- бага, дунд орлоготой иргэдийг дэмжих,
- агаарын бохирдлыг бууруулах,
- орон сууцжуулах –

-гэсэн зорилгоосоо гажсан байдалтай байгаа юм.

Тэгээд өндөр орлоготой иргэдийн хувьд арилжааныхаа банканд хандаад ийм ипотекийн моргажийн зээл авах боломж байгаа шүү дээ.

Тэгэхээр хэрэвзээ ипотекийнхээ зээлийн журмынхаа дагуу 80 метр квадрат хүртэл талбайтай анх удаа орон сууц авч байгаа иргэддээ энэхүү зээлийг хэрвээ олгосон бол 11 мянга 526 иргэдэд 2.12 их наяд төгрөгийн зээл олгох боломж байсан буюу энэ хэрээр Улаанбаатар дахь яндангийн тоо цөөрөх, орон сууцын хангалт сайжрах боломж байжээ. Боломж буюу алдагдсан боломжийн өртөг бий болсон байна.

Тэгэхээр танаас асуух зүйл юу вэ гэхээр ипотекийн зээлийн тогтолцооны хэрэгжиж байгаа өнөөгийн байдалд Та өөрөө хэр их сэтгэл хангалуун байна? Бодит байдал ийм тоогоор илэрхийлэгдэж байна.

Энэ журмынхаа, бодлогынхоо гажуудлыг хэрхэн сайжруулах, ямар арга хэмжээ авах бодлоготой байгаа вэ?

Дараагийн нэг асуудал нь 2-оос дээш удаа ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо хэд байгаа вэ?

**Н.Учрал:** 2013 онд анх үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Засгийн газар энэ ипотекийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм билээ.

Би сүүлд авсан мэдээллээр –

- Ипотект 11.7 их наяд төгрөг гаргаад байна.
- Тэгээд 133 мянган өрхийг хамруулаад байна.

Тэгэхээр яг Таны хэлж байгаа байхгүй юу. 133 мянган өрх 11.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийгээд байхад яагаад яндангийн тоо буурахгүй байна вэ гэдэг асуулт.

Тийм учраас Их Хурлын даргаар ажиллаж байхдаа би Монголбанканд бас тодорхой чиглэлүүдийг өгч ажиллаж байсан.

Нэгд, зөвхөн зорилтот бүлэгт чиглэх ёстой. Ерөөсөө л гэр хороолол руу чиглэх ёстой. Ерөөсөө энэ чинь зорилтот бүлэг рүүгээ л чиглэх ёстой шүү дээ.

Гэтэл яагаад 2 авсан, 3 авсан, эсвэл эхнэр нь нөхөр дээрээ нэг гэр бүл мөртлөө авсан байна вэ гэдэг дээр бид тодорхой дүгнэлт хийх ёстой.

2014-2016 онд л байх. Нөгөө 2, 3 авсан, давтагдсан тоо гарсан юм байна лээ. 2016 оноос хойш яг энд тэгж давтагдаад байгаагүй.

Тэгэхээр одоо бол ипотекийн хөтөлбөр дээр зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлнэ гэж зорино.

Баялгийн сангийн хуулийн дагуу бид чинь нөгөө хуримтлалын сан дээр үүсээд байгаа санхүүжилтийн хуримтлалыг ипотека рүү чиглүүлдэг.

Тэгэхээр шинэ бүтээгдэхүүн гаргана. Тэр **shared mortgage** гээд нөгөө 50 хувь нь түрээс, 50 хувь нь ипотека буюу **mortgage** гээд. Тийм хэлбэрийн Англид тэр байдаг. Биднийг оюутан байхад.

Тэгэхээр тэр хөтөлбөрийг хэрэгжүүлэе гэдэг би тодорхой чиглэлийг өгсөн.

Тэгэхээр одоо өөрчлөлт бий болно.

Хоёрт, нэг зүйл нь ипотекийн зээлд хамрагдах гэж байгаа. Хуучин арилжааны банкнууд хүрч ирээд тодорхой хэмжээний санхүүжилтээ Монголбанкнаас аваад явдаг байсан. Цаана нь ямар ямар иргэн тэр зээлд хамрагдаж байгаа вэ гэдэг лист нь ил биш байсан. Үүнийг ил болгохоор шийдвэрлэсэн. Их Хурлын дарга байхдаа.

Тэгэхээр үүнийгээ... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Б.Мөнхсоёл гишүүн тодруулж асууя.

**Б.Мөнхсоёл:** Бас нэг асуудал байна.

Өнөөдөр ч гэсэн Гадаад зээлийн тухай хуулийн төсөлтэй холбогдоод хүмүүс ярьж байна. Гишүүд асуулт асууж байна. Би ч өөрөө бас Төсвийн байнгын хороон дээр олон асуудал хөндсөн.

Нэг талдаа –

- төсвийн сахилга батын асуудал байна,
- төсвийн оновчтой, өгөөжтэй зарцуулалт байна.

Нөгөө талдаа нэгэнт олон улсын зах зээлээс босгосон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд босгосон зээлээ бас зөв, оновчтой зарцуулах асуудал ингээд хоёрдмол шинжтэй байдалд орчхоод байна гэдэг дээр холбоотой.

Жишээлбэл, Сэлбэ дэд төвтэй холбоотой газар чөлөөлөлтийн асуудал байна шүү дээ. Орон сууцжуулах хөтөлбөр. Түүн дээр 500 тэрбум төгрөгийг бэлнээр мөнгөн хэлбэрээр зарцуулсан байгаа байхгүй юу.

Та энэ дээр ямар бодолтой байна. Уг нь орон сууцаар солилцоо хийх байсан бол илүү оновчтой байх байсан юм биш үү гэж асуумаар байна?

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм. Том төслийг явуулахад бид ямар ч хэлэлцээрийг хийхэд санхүүгийн модель дээрээ хэлэлцээр хийх ёстой шүү дээ.

Тэгээд энэ чинь ямар үр өгөөжтэй юм, ямар ашигтай юм. Гэтэл зөвхөн ингээд нэг тендер зарлаад гэрээ байгуулснаар асуудлыг бас шийдэхгүй.

Тийм ч учраас одоо бид төсвөө эргээд харах ёстой байгаа юм. Жишээ нь, манай төсвийн чинь 31 их наядын орлого олж байгаа.

- 31.6 их наядын орлого олж байгаа.
  - төсвийн 75 хувиа урсгалаа санхүүжүүлээд,
  - үлдсэн 8 их наядын 4-ийг нь нийслэлд,
- 4 их наядын –
  - 1.3 гадаад зээл,
  - 1.3 шинэ хөрөнгө оруулалт,
  - үлдсэн нь урдахаа санхүүжүүлж байна.

Тэгэхээр ийм байгаа байхад эдийн засаг агшиж байх үед ийм чөдөрлөсөн байдлаар энэ дотор цаашаа эдийн засгаа идэвхжүүлж ерөөсөө чадахгүй байгаа.

Тийм учраас “Сэлбэ дэд төв” дээр ч гэсэн санхүүгийн хувьд тооцоолол эргэж хийж харах ёстой байх.

**С.Бямбацогт:** Баярлалаа.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 8-ын “в” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүүхэд, багачууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн өмнөөс сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Амьдралд нь эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Хаврын чуулганаар Улсын Их Хурал сургуулийн орчинд суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, аливаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Сургуулийн орчны эрүүл мэнд аюулгүй байдлын тухай хуулийн төсөл хэлэлцэж байгаа.

Мөн өсвөр үе, хүүхэд залуусыг хорт зуршилд автах, донтохоос урьдчилан сэргийлэх, тамхидалтыг бууруулах зохицуулалттай Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх гэж байгаа, хэлэлцэж байгаа.

Зөвхөн энэ хууль дээр гэхэд Ховд аймгаас 4800 гаруй хүүхэд гарын үсэг зурж, сурагчдын дунд электрон тамхины хэрэглээ их байна, эрүүл мэндээр хохирох эрсдэлтэй нүүр тулж байгаа тул урьдчилан сэргийлэх зохицуулалт хуулийн төсөлд тусгаж өгөөч гэж санал ирүүлсэн байсан.

Мөн Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр гишүүн, Боловсролын сайд асан бас Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж Их Хуралд удахгүй хэлэлцүүлэх гэж байгаа.

Тийм болохоор сурагчид Та бүхний эрх ашигтай холбоотой Улсын Их Хурал хэлэлцэж байгаа хуулийн төсөлд анги хамт олноороо нэгдээд саналаа өгөх боломжтой гэдгийг эрхэм хүндэт хүүхэд, багачуудаа илэрхийлье. Тэгээд идэвхтэй оролцоотой байгаарай. /алга ташив/

**С.Бямбацогт:** Одоо Пүрэвжавын Ганзориг гишүүн асуултаа асууна.

**П.Ганзориг:** Та бүхний өдрийн амгаланг айлтгая.

Би –

- ▶ Нэгд, макро эдийн засгийн орчин,
- ▶ Хоёрт, зээлийн хүүгийн асуудал,
- ▶ Гуравт, Үндэсний баялгийн сангийн менежменттэй –

-холбоотой гурван тодорхой асуулт асууя.

Нэгдүгээрт, гадаад дэлхийн геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор, гадаад нөхцөл байдал, дотоод нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал нэгдүгээр улирлын байдлаар 1.4 их наяд гараад байгаа.

Тэгэхээр энэ нөхцөл байдлуудаас хамаараад Таны Засгийн газар 2026 оны төсвийн орлого, зарлага, алдагдлын шинэчилсэн төсөөлөл гаргасан уу? Энэ төсөөлөл ямар байдлаар гарч байгаа вэ гэдгийг тодруулмаар байна.

Хоёрт, энэ нөлөө маань эргээд яг энэ инфляцыг өсгөх, шатахууны үнэ нэмэгдэх гээд иргэдийн бодит орлогыг бууруулах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хумигдах гээд эрсдэлүүд үүсэж болзошгүй байгаа.

Тэгэхээр иргэдийн бодит орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хумихгүй байх чиглэл дээр ямар бодлогын арга хэмжээнүүд авч ажиллахаар төлөвлөж байгаа вэ?

Тухайлбал, татварын багц хуулийн асуудал. 2024 оны анхны парламент бүрдсэнээс хойш бид 3 дахь жил рүүгээ ярьж байгаа. 2 удаа Засгийн газраас боловсруулаад Их Хуралтай хамтраад өргөн барьсан ч буцаагаад эргүүлээд татсан.

Тэгэхээр Татварын багц хуулийг энэ хаврын чуулганд оруулж ирж батлуулах уу? Ингэж аж ахуйн нэгж, ард иргэдийнхээ татварын нэг талдаа дарамт, ачааг бууруулах, тэр хэмжээгээрээ ард иргэдийн амьдрал, орлого нэмэгдэнэ, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тэлнэ.

Нөгөө талдаа төрийн үйл ажиллагаа үр ашиггүй, үрэлгэн, харалган зардлууд багасна. Ингэж байж төр илүү цомхон, эдийн засагт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэнэ гэж харж байгаа. Энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ?

Хоёрт, зээлийн хүү маш өндөр байгаа манай Монгол Улсын хувьд. Үүний гол нэг шалтгаан бол банкны салбарын хэт төвлөрөл, өрсөлдөөний хязгаарлагдмал байдал байгаа. Энэ дээр Та урт хугацааны хямд эх үүсвэрүүдийн дутагдалтай байгаа асуудал дээр гадаадын банкныг оруулж ирэх дээр Их Хурлын дарга... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Пүрэвжавын Ганзориг гишүүн нэмэлт 1 минут.

**П.Ганзориг:** Гадаадын банкиг оруулж ирж өрсөлдөөн нэмэгдүүлэх, томоохон урт хугацааны төсөл, хөтөлбөрүүдийг явуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр тодорхой санал, санаачилгууд гаргаж ярьж байсан. Үүнийг хэзээ, хэрхэн яаж хийх вэ?

Гуравт, Үндэсний баялгийн сангийн хөрөнгө 6.7 орчим их наяд хүрээд явж байгаа.

Гэтэл бид гадаадын банкууд дээр үүнийгээ жилийн 4 орчим хувийн хүүтэй хадгалж байгаа. Нөгөө талаасаа бид эх үүсвэр, бонд босгохдоо гаднаас 2 дахин өндөр өртөгтэй босгож байгаа.

Тэгээд Үндэсний баялгийн сангийнхаа нөөцийг бид гадаад валютын нөөцийгөө нэмэгдүүлэх замаар буюу богино хугацааны төлбөрийн чадвараа сайжруулах зорилгоор ашиглаад байгаа.

Гэтэл Үндэсний баялгийн сангийн чинь гол зорилго урт хугацааны ирээдүйдээ хэрэглэх гол эх үүсвэр, хуримтлал болж байдаг юм. Үүнийг яг улс төрөөс ангид, мэргэжлийн түвшинд мэргэжлийн удирдлагатай болгох, менежменттэй болгох ажлыг хэзээнээс хэрхэн яаж хийх вэ гээд энэ гурван асуултыг асууя. Баярлалаа.

**Н.Учрал:** Өнөөдрийн гол орлогын тасралт аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр 560.0 тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татвар дээр 200.0 тэрбум тэрбум төгрөг тасарсантай холбоотой.

Энэ бол өнгөрсөн оны сүүлд нөгөө урьдчилгаа төлбөр, татваруудыг авсан. Тэгээд үүнээсээ болоод эхний 3 сарын байдлаар алдагдал 1.3-д хүрсэн байна.

Тийм учраас цаашдаа яг энэ олон улсын эдийн засгийн хурцадмал байдлын үед Засгийн газар төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Тэгээд энэ хүрээндээ бол мэдээж түлш эрчим хүчний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай байна.

Тэгээд энэ хүрээндээ юутай ч шатахууны үнэ өсөхгүй, тогтвортой барихаар Оросын Холбооны Улстай тодорхой хэлэлцээрүүдийг хийгээд ирсэн. Үүнтэйгээ холбогдуулаад мэдээж түлш, шатахуун өөрөө инфляцад гол нөлөөлдөг.

Тийм учраас үнийг тогтвортой барихаасаа гадна ногоон санхүүжилтийг дэмжих чиглэлээр ирэх долоо хоногийн Засгийн газрын хурал дээр тодорхой шийдвэрүүдийг гаргах гэж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх арга хэмжээнүүдийг хөдөө аж ахуйн салбарт авсан. Тодорхой эх үүсвэр гаргаж хөнгөлөлттэй зээлүүдийг олгож эхэлсэн.

Дээрээс нь Монголбанк дээр ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг тусдаа бүтээгдэхүүн болгож хэрэглээний зээлийн ангиллаас гаргаж шийдвэрлэх гэж байна.

Мөн эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийг тасралтгүй хангах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг механизмыг шинэчилж байна.

Зарлагын чиглэлээр бүх шатад мэдээж хэмнэлтийг бий болгосон.

Эдийн засгаа идэвхжүүлэх чиглэлээр ирэх оны төсвийг илүү эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр бэлтгэж байна.

Татварын багц хуулийг би Ерөнхий сайдаар томилсныхоо дараа... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Гүйцээгээд хариулъя. 1 минут.

**Н.Учрал:** Татаж авсан. Тэгээд Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийг барих гэж байна. Татварын багц хуулийн шинэчилсэн найруулга гэхээсээ илүү өнөөдөр хэрхэн компани аж ахуйн нэгжүүдийгээ дэмжих вэ гэж гэдэг чиглэлээр.

Жишээ нь, НӨАТ төлөгчийн босгыг 400 сая болгох, 2.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой бол аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгох. Одоо жишээ нь татвар төлөгч зөвхөн татварын байгууллага талаас биш иргэн талаасаа харсан эдийн засгаа идэвхжүүлэх чиглэлийн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг өргөн барих гэж байна.

Зээлийн хүү компани, аж ахуйн нэгж, иргэн болгонд үүсээд байгаа том асуудал.

Тэгэхээр үүнийг би Их Хурлын дарга байхдаа үнийн өсөлтөөс иргэдээ хамгаалах арга хэмжээний тухай тогтоолыг гаргасан. Тэр тогтоолоо өөрөө хэрэгжүүлж байна.

Гадаад банк оруулж ирэх хэлэлцээрүүдийг хийж байна.

Их Хурлын гишүүд Та бүхнийг банкны хуулийг баталж өгөхийг хүсэж байна. Энэ тохиолдолд гаднын банкууд оруулж ирэх нөхцөл бүрэн бүрдэнэ гэдэг итгэлтэй байна.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Нэг удаа гээд би бас. Уг нь цаг байгаад байгаа юм. Тэгээд нэг л удаа тодруулах ёстой гээд. Тийм дэгтэй гээд манай хуралдаан зохион байгуулах, Тамгын газраас тэгээд болдоггүй. Уучлаарай.

Одоо Батын Батбаатар гишүүн асуултаа асууна.

Үүний дараа санал хураалттай. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Үдээс өмнө хэлэлцсэн хоёр асуудлаар санал хураалт байгаа. Энэ хоёр санал хураалтаа явуулах юм бол өнөөдрийн чуулганы хуралдаан өндөрлөнө. Гишүүдийг чуулганы танхимд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

**Б.Батбаатар:** 10 минутын хугацаа байх шиг байна.

Тийм болохоор товчхон, шууд асуултууд асууя. Бас товчхон хариулаад өгөөрэй.

Нэг асуулт дээр нэг удаа тодруулга нэмж болно гэж ойлгож байгаа. Олон асуулт асуух санаа байна.

Сүүлийн 10 жил Монгол Ардын нам засаг барьж байгаа. Энэ нь иргэдийн амьдрал бодитоор сайжирсан гэж Та намын дарга, Ерөнхий сайдын хувьд үзэж байна уу? Тийм, үгүй гэдгийг хариулж өгнө үү?

Микрофоныг нь өгөөрэй. Ерөнхий сайд би эндээс хэлэх үү?

**С.Бямбацогт:** 2 минутад нэг удаа асууна. Тодруулж 1 минут асууна. Олон удаа асуух дэг байхгүй. Тийм үү? Хуралдаан зохион байгуулахын дарга.

Тийм болохоор 2 минутдаа асуултаа хангалттай асуугаад, дахиад тодруулах бол 1 минут.

**Б.Батбаатар:** Ойлголоо. Нэг дэх асуулт саяынх.

- Хоёр, хэрвээ сайжирсан гэж байвал бодит орлого, инфляц, ядуурлын аль үзүүлэлтүүдээр үүнийг батлах вэ? Яг тоо, хугацаатай нь хэлнэ үү.
- Гурав, өнөөдөр мах, гурил, шатахууны үнэ иргэдийн орлогоос хурдан өсөж байгааг Та амжилт гэж үзэж үзэж байна уу, эсвэл бодлогын алдаа гэж үзэж байна уу?
- Дөрөв, дотоодын нийт бүтээгдэхүүн өссөн гэж ярьдаг ч яагаад дундаж өрхийн бодит орлого, худалдан авах чадвар өсөхгүй байна вэ?
- Тав, Залуучууд гадагшаа олноор гарч байгаа нь боломж нэмэгдсэний шинж үү, эсвэл дотоод орчин хангалтгүй байгаагийнх уу?
- Зургаа. Томоохон авлигын хэргүүд дээр өндөр дээд албан тушаалтанд бодитоор ял авсан хэдэн тохиолдол байна вэ? Энэ нь системийн гажуудал гэдгийг Та хүлээн зөвшөөрөх үү?

- Долоо, эрчим хүчний хомсдол жил бүр давтагдаж, хувийн болон гадаад хөрөнгө оруулалтын төслүүд удааширч, хэрэгжихгүй байгаа нь бодлогын алдаа юу, эсвэл хэрэгжилтийн чадавхын асуудал уу?
- Найм, хэрэв дээрх асуудлууд системийн шинжтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байвал яг ямар 3 бодит реформыг ямар хугацаанд хэрэгжүүлэх вэ?
- Ес, хэрэв Таны хэлсэн бодлого тодорхой хугацаанд бодит үр дүн өгөхгүй бол Та улс төрийн хариуцлага хүлээж огцрох хүртэл шийдвэр гаргах уу? Тийм уу, үгүй юу гэдэг.

**Н.Учрал:** Яг 10 жилийн өмнөхтэй харьцуулбал тодорхой хэмжээнд сайжралгүй яах вэ. 10 жилийн өмнө чинь Монгол Улс дампуурах уу, яах вэ дээрээ тулсан байсан үе шүү дээ. Хөтөлбөрт орсон байсан үе шүү дээ.

Тэгээд манай улс “бага орлоготой” орноос “дундаас дээгүүр орлоготой” орны статуст шилжсэн. 10 жилийн өмнөхтэй харьцуулахад шүү дээ.

- 89.9 их наядын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болоод байна шүү дээ. Өнөөдөр.
- Ирэх жил 100 руу явна гэж ярьж байгаа.
- 10 жилийн өмнө 22.9 их наяд байсан шүү дээ.
- 10 жилийн өмнө 6 их наядын төсөвтэй байсан шүү дээ.

—Одоо 5 дахин өсөөд байгаа шүү дээ.

—Одоо 31.6 их наядын төсөвтэй болсон.

- Экспорт тухайн үед юу байсан бэ. 4.5, 4.6, 4.7 тэрбум доллар.
- Өнөөдөр 15.7 тэрбум долларын экспорт хийдэг болсон шүү дээ.

Нүүрсний экспортыг ярихаар манай гол экспортын 90 гаруй хувь эзэлж байгаа нүүрсний экспорт чинь одоо бараг 25 сая тонныг гаргадаг байсан. Өнөөдөр бид чинь баталсан төсөв дээр 90 сая тонн байхгүй юу.

Тэгэхээр өсөөгүй гэвэл биш. Гэхдээ өрхийн хаалгаар оруулж чадаагүй. Би бол түүнтэй санал нэг байна.

- Нэг ёсондоо иргэдээ үнийн өсөлтөөс хамгаалж чадаагүй.
- Нэг ёсондоо эдийн засаг тэлж байх үедээ хуримтлагдсан хуримтлалыг зөв зүйлд зарцуулж чадаагүй.

Мөнгө олох нь нэг асуудал. Мөнгийг зөв хуваарилах нь дараагийн асуудал байхгүй юу.

Тэгэхээр хуримтлагдсан үедээ олсныхоо хэрээр үрсэн. Олсныхоо хэрээр зарсны хор уршиг өнөөдөр гарсан.

Тийм учраас цаашдаа өрхийн хаалгаар эдийн засгийг яаж оруулах вэ гэвэл мөчлөг сөрсөн бодлого гэдэг чинь хуримтлалыг бий болгож байгаад хуримтлалаа зорилтот бүлэгтээ чиглүүлэхийг хэлж байгаа.

Түүнээс биш нөгөө 33.5 их наядын орлого олоод төдий хэмжээгээрээ зараад яваад байвал өнөөдөр юунд хүрч байгаа вэ гэдгээ бид харж байгаа. Тэгэхээр тэгж хариулъя.

Та 9 асуулт асуусан. Бүгдийг нь 2 минутад хариулах чинь.

**С.Бямбацогт:** Ерөнхий сайдын минутыг сунгая.

**Н.Учрал:** Хоёр дахь нь сайжирсан гэвэл бодит орлого, инфляц гээд. Би үүнийг хариулсан гэж ойлгоё. Тэгэх үү.

Гурав. Өнөөдөр мах, гурил, шатахууны үнэ иргэдийн орлогоос хурдан өсөж байгааг Та амжилт хийж үзэж байна уу гэж байгаа юм байна. Тийм ээ.

Би хөдөө аж ахуйн салбар, хүнсний салбарт махны нийлүүлэлт, мах нөөцлөх асуудлууд дээр тодорхой арга хэмжээнүүдийг авч байгаа.

Дээрээс нь импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх 6 төслийг ирэх долоо хоногт төлөвлөж зарлана.

Шатахууны үнэ 2.2 тэрбум долларын импорт хийдэг ийм л улс. Нэг улсаас хамааралтай. Тэгэхдээ шатахууны үнээ ямар ч байсан барилаа.

Эрчим хүчний салбарт ч гэсэн инфляцад гол нөлөө үзүүлж байгаа учраас үнийг хөөрөгдүүлэхгүйгээр үнийг өсгөхөөсөө илүүтэйгээр салбарын дотоодын шинэчлэлийг хийхийг зорино.

Дотоодын нийт бүтээгдэхүүн өссөн гэж ярьдаг ч яагаад дундаж орлого өсөхгүй байна вэ гэхээр ерөөсөө хуримтлуулж байх үедээ зөв зохистой зарцуулж чадаагүйн хор гай энд гарсан гэдгийг хэлье.

**С.Бямбацогт:** Батын Батбаатар гишүүн тодруулж асууя.

**Б.Батбаатар:** Есөн асуултад бүгдэд нь хариулт авч чадахгүй байна.

Тийм учраас тодруулж асуух зарим зүйлийг асуухад их хүнд болж байна.

Би эдийн засгийн өсөлт, тоон тухай асуугаад байгаа юм биш. Иргэдийн бодит амьдралын тухай асуугаад байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөх чинь төрийн асуудал. Иргэдийн бодит орлого, худалдан авах чадварын асуудлуудаар 3 тоо хэлээд өгөөч гэж байгаа юм.

Тэгээд бид ингээд инфляц ийм өндөр байхад бодит орлого нь инфляцаа давж чадахгүй байгаа асуудал дээр яаж анхаарах ёстой юм бэ? Энэ чинь одоо яг ингээд инфляцаа давж чадахгүй яваад байгаа л цалин орлого байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр өрхийн худалдан авалтын чадвар. 10 жилийн өмнө хөргөгчид байсан мах хэдэн килограмм байдаг байсан бэ? Өнөөдөр хэдэн килограмм байна? Хөргөгчөө онгойлгоод харахад, хадгаламжийн дэвтэр, дансаа нээгээд харахад өр нь өссөн байна уу, дансны үлдэгдэл нь өссөн байна уу гэдэг энэ тоонууд дээр ярьж асуух ёстой юм.

Дээрээс нь тэр залуучууд... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Ерөнхий сайд хариулъя.

**Н.Учрал:** Тийм. Ер нь төсвийн бодлого буруу явж иржээ. Би үнэнийг хэлье.

- Орлого 2.9 сая төгрөг.
- Зарлага нь 3.1 сая байгаа байхгүй юу. Өрхийн.

Тэгэхээр тэр 2.9, 3.1 саяын хоорондын зөрүүг юугаараа нөхөж байна вэ гэвэл зээлээр.

Тэгээд–

- зээлээс зээлийн хооронд,
- банкаас банкны хооронд,
- банк бусаас банк бусын хооронд яваад байдаг.

Ингээд төсвийн бодлого өөрөө алдагдаад эхлэхээр–

- цалин нэмнэ гэдэг,
- тэтгэвэр нэмнэ гэдэг,
- тэтгэмж нэмнэ гэдэг.

Тэгээд эцэст нь эргээд харахаар нөгөө үнээ хөөргөдөг.

Тэгэхээр өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ инфляцад тооцогдож байгаа бүтээгдэхүүний чинь 6-хан бүтээгдэхүүнээр л ард түмний амьжиргааг ярьж байгаа шүү дээ.

Тийм учраас бид зээлийн хүүг бууруулах, банкны салбарт өрсөлдөөнийг бий болгох ажлыг хийхгүй бол нөгөө валютаа гөвөхгүйн тулд Монголбанк нь –

- бодлогын хүүгээ чангаруулаад байдаг,
- өр, орлогын харьцаагаа илүү хатууруулаад байдаг,
- зээл нь гарч чадахаа болиод байдаг.

Ерөөсөө “төсвийн бодлого”, “мөнгөний бодлого” уялдаагүй байсан энэ байдал өнөөдөр өргөсөн учраас... /минут дуусав/

**С.Бямбацогт:** Баярлалаа. Батын Батбаатар гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Ерөнхий сайд Ням-Осорын Учрал Танд баярлалаа.

Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Өнөөдөр Ерөнхий сайдын асуулгын цаг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал даргын хувьд анхны удаа боллоо. Тэгээд Н.Учрал даргадаа, хариуцлагатай оролцсон Засгийн газрын гишүүддээ баярлалаа.

Мөн Улсын Их Хурлын асуулгын цаг дээр асуулт асуухаар нэрээ ирүүлсэн олонх, цөөнхийн бүлгийн гишүүд, цөөнхийн гишүүд бүгд асуултаа асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий сайдад талархал илэрхийлье.

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа. /алх цохив/

---

### **Долоо.Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсох**

---

Одоо Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урья.

16.00 цагаас санал хураалттай. Гишүүдийг цуглаж байх хооронд баталсан тогтоолын төслийн эцсийн найруулгыг сонсож байх уу.

Гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. 16.00 цаг болж байна. Хоёр асуудлаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн

найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж Улсын Их Хуралд танилцахад бэлэн болсон байна.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Ялангуяа Ардчилсан намын бүлгийн гишүүд нэлээн дундуурхан харагдаж байна. Гишүүд санал хураалтдаа хүрэлцэн ирнэ үү.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийн урилгаар Төв аймгийн Монгол Ардын намын хорооны дэргэдэх Социал-демократ Ахмадын холбооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монгол Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс ахмадууд Та бүхэндээ амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Та бүхний залуу халуун насандаа Монгол Улсынхаа төлөө хөдөлмөрлөж зүтгэж байсныг тань хойч үе нь үргэлж дурсаж санадаг шүү. Баярлалаа.

Гишүүд суудалдаа сууна уу. Байнгын хорооны горимын саналаар гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд хурууны хээгээ уншуулж санал хураалтдаа бэлтгэе. Танхимд нэлээн олон гишүүн сууж байна даа. 36 гишүүн санал хураалтад бэлэн болсон харагдаад байх юм. Ирцэд 105 гишүүн орсон байгаа.

Санал хураалтад 42 гишүүн бэлэн болсон байна. Санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүдийг санал хураалтдаа бэлдэхийг урьж байна, хүсэж байна.

Мөн санал хураалтдаа чуулганы танхимд ирээгүй гишүүдийг ирэхийг урьж байна. Санал хураалтад бэлэн 54 гишүүн байна. Ирцийн санал хураалт, бүртгэлийн санал хураалт явуулъя.

Өглөө ирцдээ ороод санал хураалтдаа оролцохгүй явдаг байдал жоохон газар аваад байгаа. Үүнийг бид зохицуулах ёстой. Одоо ирцийн санал хураалт. /алх цохив/

Ирцдээ орж амжаагүй, бүртгэлд орж амжаагүй гишүүд гараа өргөөрэй. Г.Очирбат гишүүн ороогүй байна. Одоо зөвшөөрсөн гээд санал хураалтад нэр нь гарч байгаа гишүүд танхимдаа сууж байгаа, санал хураалтад бэлэн байгаа

гишүүд байна. Татгалзсан гэж гарч байгаа гишүүд энэ танхимд байхгүй байгаа гишүүд гэж ойлгож болно. Гэхдээ энд байхгүй гэж гарсан дотор манай Г.Очирбат гишүүний нэр байх шиг байна. Өөр Ч.Анар гишүүн. Д.Пүрэвдаваа гишүүн бүртгэлдээ орно уу, Та. Тэгэхгүй болохоор Та ажлаа хийхгүй байгаа харагдаад байна. Ард түмэн татгалзсан гэдгийг чинь хараад ажлаа хийхгүй байна гээд ярьж байна.

Өөр гишүүд орж ирэх гишүүд байна уу? Гишүүд ирцдээ ороорой, бүртгэлдээ ороорой. Гишүүд суудалдаа сууцгаана уу? Бүртгэлийн санал хураалт, ирц бүртгэлийн санал хураалт.

106 гишүүн ирцэд орсноос 59 гишүүн одоо яг санал хураалтад оролцож байна. Ажлаа хийгээд яг энэ танхимд сууж байна. Өөр танхимд сууж байгаагаас эсрэг гарсан гишүүд байна уу? Д.Пүрэвдаваа гишүүн эсрэг гарсан байна. Ингээд 60 гишүүн танхимд сууж байна.

Үлдсэн 45 гишүүн бол үндсэндээ ирцдээ ороод санал хураалтад оролцохгүй. Өөрөөр хэлэх юм бол ажлаа хийдүүлж байгаа гэж ойлгож болно. Ингээд санал хураалт явуулъя.

Байнгын хорооноос Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 106 гишүүн оролцсоноос 58 гишүүн зөвшөөрч, 54.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

106 ч биш л дээ. 61 гишүүн оролцсоноос 58 шүү.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн нэг санал хураалт. Ингээд өнөөдрийн чуулган өндөрлөнө.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлдэхэд хонх дуугардаг билүү? Санал хураалтдаа бэлтгэж дууссан уу? Хэдэн гишүүн байна. 60 гишүүн байна. Санал хураалтдаа бэлдсэн. Тийм ээ. Санал хураалт явуулъя.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 106 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Х.Баасанжаргал гишүүнийг дэмжсэн саналд тооцож авъя.

Дараагийн санал хураалт. Дахиад нэг санал хураалт байгаа шүү.

Хамт өргөн мэдүүлсэн Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд ээ, байж байгаарай. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураасан би. Буруу ойлгосон гишүүд байгаа юм биш биз дээ. Тэгээд горимын саналаа гаргачих. Байхгүй.

Санал хураалтад 106 гишүүн оролцсоноос 49 гишүүн буюу 46.2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. /алх цохив/

Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно. Энэ дагуу буцаасан тогтоол батлагдсанд тооцлоо. /алх цохив/

Ингээд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газарт эрх олгох тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. /алх цохив/

**Хуралдаан 5 цаг 45 минут үргэлжилж, 16 цаг 20 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**